

**ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН
НИЙТЛЭГ БАГЦ ДҮРЭМ**

**ТӨМӨР ЗАМЫН
ТЕХНИК АШИГЛАЛТЫН
ДҮРЭМ**

**УЛААНБААТАР ХОТ
2018 ОН**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Төмөр замын техник ашиглалтын дүрмийн зорилго нь төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төмөр замын байгууламж, техник тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний үндсэн хэмжээ болон тэдгээрийн ашиглалт, засвар, үйлчилгээнд тавигдах шаардлага, галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах дэг горим, дохиоллын зарчим, төмөр замын **байгууллагын** ажилтны ажиллах журмыг тогтооход оршино.

1.2. Энэхүү дүрмийг төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, нийтлэг багц дүрэмд заасны дагуу төмөр замын тээвэрлэлтийг зохион байгуулах үүрэг бүхий төмөр замын суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч, аж ахуйн нэгж байгууллага дагаж мөрдөнө. Техник ашиглалтын дүрмийг хэрэгжүүлснээр төмөр замын салбарын бүх байгууллага, нэгжийн хоорондын ажлын уялдаа холбоо, тээвэрлэлтийн аюулгүй, тасралтгүй хэвийн байдал хангагдана.

1.3. Нийтийн ба дагнасан хэрэглээний зам, талбайд байх байгууламж, техник тоног төхөөрөмж ба хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, барих, төлөвлөх, ашиглахтай холбоотой бүх журам, заавар **нь** энэхүү дүрмээр тогтоосон шаардлагад **нийцсэн** байна.

1.4. Төмөр замын нэр томъёоны тайлбарыг энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол төмөр замын нэр томъёоны үндэсний стандартад заасныг баримтлана.

1.5. Техник ашиглалтын дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: /Төмөр замын тээврийн тухай хууль, холбогдох стандартад заасан утгаар ойлгоно./

Аж ахуйн галт тэрэг – Төмөр замын байгууллагын суурь бүтцийн засвар, үйлчилгээ хийх, хэвийн ажиллагааг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаанд ашиглагдах галт тэрэг

Алсын удирдлагатай зөрлөг –

Ачаа-зорчигчийн галт тэрэг – Хөдөлгөөн багатай замын хэсэгт ачаа ба зорчигч тээвэрлэхэд зориулагдсан ачааны ба зорчигчийн вагонаар бүрдүүлэн найруулсан галт тэрэг

Ачааны вагон – Ачаа тээвэрлэхэд зориулагдсан битүү вагон, хагас вагон, тавцант вагон, цистерн, бункерт хагас вагон болон тусгай зориулалтын вагон

Тээвэрлэгдэх ачааны төрөл, зориулалтаас хамааран битүү, хагас, тавцант, цистерн, думпкар, хоппер болон тусгай зориулалтын гэж ангилагдан ялгагдан

тэдгээрт зориулагдсан хийц, бүтэц, зохион байгуулалттай хөдлөх бүрэлдэхүүний нэгж

Ажил удирдагч – Төмөр замын төхөөрөмж, байгууламжид засвар, үйлчилгээ хийх үед ажил удирдах үүрэг, хариуцлага хүлээх албан тушаалтан

Ажил удирдагч – Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, төхөөрөмж байгууламжинд хийгдэх засвар, үйлчилгээний ажлыг зохион байгуулах, ажлын үр дүнгийн хувьд хариуцлага хүлээх үүрэгтэй албан тушаалтан

Албан тоормослолт – Урьдаас төлөвлөсөн газарт галт тэрэгний хурдыг аажмаар бууруулах буюу түүнийг зогсоохын тулд шатлан хийх тоормослолт

Албан тоормослолт – Урьдаас төлөвлөсөн газарт галт тэрэгний хурдыг аажмаар бууруулах буюу түүнийг зогсоохын тулд шатлан хийх үйлдэл

Ачилтын овор – Шулуун тэгш зам дээр зогсох хөдлөх бүрэлдэхүүний тэнхлэг, замын тэнхлэг нэгэн босоо хавтгайд байрлах үед задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачсан ачаа /сав, баглаа, боодол, бэхэлгээг оролцуулан/ гадагш илүү гарахгүйгээр дотор нь багтаж байх замын тэнхлэгт эгц хөндлөн хязгаар хүрээ

Барих мухар зам – Сунгуу уруу дээр явж байгаа галт тэрэг жолоодлого алдсан, өртөөний замаас зүтгүүргүйгээр өөрөө хөдөлсөн хөдлөх бүрэлдэхүүнийг оруулах зориулалттай мухар зам

Барих мухар зам – Сунгуу уруудуур дээр явж байгаа галт тэрэг жолоодлого алдсан, өртөөний замаар зүтгүүргүйгээр өөрөө хөдөлсөн хөдлөх бүрэлдэхүүнийг оруулах зориулалттай

Барилга байгууламжийн ойртох хязгаар – Замын тэнхлэгт эгц хөндлөн хүрээ дүрс дотор төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн байх ба бусад байгууламж, төхөөрөмж, түүнээс гадна байрлах зай хэмжээ

Баримтлах уруудуур – Тахирын эсэргүүцлийг оруулан тоормосны замаас багагүй урттай, тухайн хэсэг дэх хамгийн их уруудуур

Баримтлах уруудуур – Тахирын эсэргүүцлийг оруулан тормозны замаас багагүй урттай, тухайн хэсэг дахь хамгийн их уруудуур хэвгийн хэмжээ юм. Татах тооцооны үед удирдах өгсүүрийн хэвгийн хэмжээгээр тухайн мөр дахь ачааны галт тэрэгний хувьд байж болох жингийн норм, тийм жинтэй галт тэрэг тухайн өгсүүр дээгүүр ямар хэмжээний (V_{min}) хурдтай явахыг тогтоодог бол баримтлах уруудуур хэвгийн хэмжээг ашиглан тухайн уруудуур хэсэг дээр зүтгүүрийг жолоодох жолоодлогын (тормозын хангамж, удирдлага) дэглэмийг тодорхойлдог

Бие даасан галт тэрэг –

Билет газарч – Оруулах гэрлэн дохионы хориглосон заалттай үед галт тэрэг өртөөнд газарчтай хүлээн авах зөвшөөрөл. “Билет газарч”-ийг өнгөт металлаар (зэс, гууль) хийнэ

Билет газарч –Оруулах гэрлэн дохионы хориглосон заалттай үед галт тэрэг өртөөнд газарчтай хүлээн авах зөвшөөрөл

Блок-хэсэг – Зүтгүүрийн автомат дохиоллыг бие даасан дохиоллын хэрэгсэл болгон ашиглах ба автомат хориглолын үед өнгөрүүлэх гэрлэн дохиогоор (блок хэсгийн хилээр) хязгаарлагдсан хоорондын замын хэсэг

Блок-хэсэг – Зүтгүүрийн автомат дохиоллыг бие даасан дохиоллын хэрэгсэл болгон ашиглах ба автомат хориглолын үед өнгөрүүлэх гэрлэн дохиогоор (блок хэсгийн хилээр) хязгаарлагдсан хоорондын зам болон өртөө, зөрлөгийн хүлээн авах, явуулах замын хэсэг

Блок-хэсэг – Зүтгүүрийн автомат дохиоллыг бие даасан дохиоллын хэрэгсэл болгон ашиглах ба автомат хориглолын үед өнгөрүүлэх гэрлэн дохиогоор хязгаарлагдсан хоорондын замын хэсэг

Галт тэрэг – Тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхээр нэг бүлэг болгон найруулж холбосон ажиллагаатай зүтгүүр ба сүүлийн дохио бүхий хөдлөх бүрэлдэхүүн

Галын галт тэрэг –Төмөр замын тээврийн үйл ажиллагааг гүйцэтгэхээр нэг бүлэг болгон найруулж холбосон ажиллагаатай зүтгүүр болон сүүлийн дохиотой хөдлөх бүрэлдэхүүнүүд, тэдгээрт ажиллах төмөр замын мэргэжлийн ажилчид

Галт тэрэг - Төмөр замын тээврийн үйл ажиллагааг гүйцэтгэхээр нэг бүлэг болгон найруулж холбосон ажиллагаатай зүтгүүр болон сүүлийн дохиотой хөдлөх бүрэлдэхүүнүүд, тэдгээрт ажиллах төмөр замын мэргэжлийн ажилчид

Галт тэрэгний дохио – Галт тэрэг, зүтгүүр болон бусад хөдлөх нэгжийн аль нь болохыг тодорхойлох, тэдгээрийн хөдөлгөөний хэвийн ажиллагааг хянах зориулалт бүхий дохио

Галт тэрэгний хөдөлгөөний зохицуулагч – Галт тэрэгний хөдөлгөөнийг нэг цэгээс хянаж, шаардлагатай үүрэг даалгавар өгч, удирдан зохицуулах үүрэг хүлээсэн ажилтан

Галт тэрэгний хөдөлгөөний зохицуулагч – Галт тэрэгний хөдөлгөөнийг нэг цэгээс хянаж, шаардлагатай үүрэг даалгавар өгч, удирдах, удирдан зохицуулах үүрэг хүлээсэн ажилтан

Галт тэрэгний хөдөлгөөний зохицуулагчийн төвлөрүүлэлт - Төвлөрүүлэлтээр тоноглогдсон хэсэглэлд галт тэрэгний хөдөлгөөнийг алсаас

удирдах, цахилгаан төвлөрүүлэлтийн сум, дохио болон бусад төхөөрөмжүүдийг хянах байгууламж

Галт тэрэгний хөдөлгөөний зохицуулагчийн төвлөрүүлэлтийн байр – хэсгийн өртөө, зэрлэгийн төвлөрүүлэгдсэн байгууламжийг алсаас удирдах ААБайр

Галт тэрэгний эрчимтэй хөдөлгөөн –Нэг замт хэсэгт хоногт зорчигчийн ба ачааны галт тэрэгний хөдөлгөөний хэмжээ нь зурмагаар 24 хосоос дээш байх

Гол зам -Хоорондын зам, өртөөний хилийн зааг доторх түүний үргэлжлэх хэсэг

Гол тоологч –

Дамжуулах болон зөөврийн галт тэрэг –

Дохио – Галт тэрэгний ба сэлгээний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангах болон түүнийг тодорхой зохион байгуулах зорилгоор үзэгдэх ба дуун хэлбэрээр өгөгдөх тушаал

Дохионы тэмдэг – Хөдөлгөөний ажилтанд тодорхой тушаал ба заавар өгөх зориулалт бүхий үзэгдэх тэмдэг. Дохионы тэмдэгт хязгаарын шон, улаан, шар, ногоон самбар, шүгэл дуугарах гэх мэт

Дохионы тэмдэг – Хөдөлгөөний ажилтанд тодорхой тушаал ба заавар өгөх зориулалт бүхий үзэгдэх тэмдэг

Замын пост – Нэг замтай төмөр замын шугамд байрлах тодорхой зориулалтаар ашиглах замын хөгжилгүй хэсэглэх газар

Замын тэмдэг – Төмөр замын шугамын аяс, урт, замын төхөөрөмж, байгууламжийн орших газрыг заасан байнгын заагч

Замаас авагддаг хөдлөх нэгж – Зам төмрөөс гараар авч буулгаж болох авагддаг дрезин, замын вагонцор, зам хэмжүүрийн, сэв шалгуурын болон бусад тэргэнцэр

Замаас авагддаг хөдлөх нэгж – Зам төмөр дээрээс гараар авч буулгаж болох авагддаг тэргэнцэрүүд. Тэдгээр нь моторт тэргэнцэр, замын вагонцор, зам хэмжүүрийн, сэв шалгуурын болон бусад тэргэнцэрүүд г м олон төрөл байна

Зорчигчийн галт тэрэг – Зорчигчийн болон тээшний вагонуудаар бүрдүүлэн найруулсан зорчигч, тээш, шуудан тээвэрлэхэд зориулагдсан галт тэрэг. Харилцааны төрлийн хувьд зорчигчийн галт тэргийг 700 км-ээс дээш аялах алсын, 700 км дотор аялах орон нутгийн, 150 км дотор аялах хот дүүргийн галт тэрэг гэж ангилна

Зорчигч, тээш, шуудан тээвэрлэх вагонуудаар бүрдүүлэн найруулсан, хатуу тогтоосон хугацааг баримтлан явуулах, харилцааны төрлөөр нь энгийн, буухиа, орон нутгийн, олон улсын, алсын, хот дүүргийн гэж ангилагдан тэдгээрт зориулагдсан төрөл, хийц, төхөөрөмж, системтэй галт тэрэг

Зорчигчийн галт тэрэг – Зорчигчийн болон тээшний вагонуудаар бүрдүүлэн найруулсан зорчигч, тээш, шуудан тээвэрлэхэд зориулагдсан галт тэрэг. Харилцааны төрлийн хувьд зорчигчийн галт тэргийг 700 км-ээс дээш аялах алсын, 700 км дотор аялах орон нутгийн, 150 км дотор аялах хот дүүргийн гэж ангилна

Зорчигч буух, суух газар – Зөвхөн зорчигч буух суухад зориулагдсан хоорондын зам дахь зогсоол

Зорчигчийн вагон – Зорчигч тээвэрлэхэд зориулагдсан вагон

Зорчигчдын ая тухтай, аюулгүй байдлыг бүрэн хангаж чадахуйц техник, тоног төхөөрөмж, системтэй тэдгээрийн хэвийн найдвартай ажиллагааг хянан, тодорхойлох дохиологч, мэдрэгчтэй, зорчих зайнаас хамааран алс аяллын, орон нутгийн, хот дүүргийн хөдлөх бүрэлдэхүүний нэг нэгж

Зорчигчийн вагон – Зорчигч тээвэрлэхэд зориулагдсан төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн

Зөрлөг – Галт тэрэг хүлээн авах, явуулах, гүйцэж түрүүлэх, зөрүүлэхэд зориулагдсан, нэг замтай шугам дахь зам бүхий хэсэглэх газар

Зурмаг – Галт тэрэгний хөдөлгөөнтэй холбогдолтой бүх салбарын ажлыг уялдуулж зохицуулсан нэгдсэн технологи

Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг- Төмөр замын тээврийн бүх салбаруудын ажлын үндэс тээвэр зохион байгуулалтын ажлын төлөвлөгөө. Өртөө зөрлөгийн нэвтрүүлэх чадварыг дээд зэргээр ашиглан хөдлөх бүрэлдэхүүнийг оновчтой зохион байгуулж хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган зорчигч ба ачаа тээвэрлэлтийг цаг тухайд нь биелүүлнэ. Галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой бүх салбарын ажлыг уялдуулж зохицуулсан нэгдсэн технологийн баримт бичиг

Зүтгүүрийн бригад – Зүтгүүрийг жолоодож галт тэрэг зөөвөрлөх болон сэлгээний ажил гүйцэтгэхээр томилогдсон төмөр замын мэргэжлийн машинч, туслах машинч

Зүтгүүр – Цахилгаан тэрэг, илчит тэрэг, уурын тэрэг, хийн трубинт, мотовоз гэх мэт

Зүтгүүр – Төмөр замын тээврийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулагдсан тээврийн хэрэгсэл буюу тусдаа вагонууд болон галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнүүдийг татах хэрэгсэл. Зүтгүүр нь цахилгаан тэрэг, илчит тэрэг, хийн трубинт тэрэг, моторт тэрэг г м олон төрөл байна

Зүтгүүрийн автомат дохиолол – Бие даасан дохиолол холбооны хэрэгсэл. Ийм төхөөрөмжтэй хоорондын замд галт тэрэгний хөдөлгөөн зүтгүүрийн гэрлэн дохиогоор зохицуулагдана

Зүтгүүрийн автомат дохиолол –Төмөр замын тээвэр дэх дохиоллын системийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулж буй дохионы заалтыг зүтгүүрийн машинчийн бүхээгт шууд дамжуулдаг систем юм

Моторт вагон – Төмөр замаар өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүн

Төмөр замаар өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний нэгж

Мухрын өртөө –

Өртөө - Галт тэрэг хүлээн авах явуулах, зөрүүлэх, гүйцэж түрүүлэх, ачаа хүлээн авах олгох, зорчигчдод үйлчлэх тавцан, талбай, агуулахтай, галт тэрэг найруулах, задлах, галт тэрэгний бусад техникийн ажиллагаа хийж болох замын хэсэглэх газар

Өртөөний төвлөрүүлэлтийн байр – Сум ба дохионы удирдлагыг төвлөрүүлсэн өртөөний байр

Өртөөний жижүүр – Галт тэрэг хүлээн авах, явуулах, өртөөнд ачаа тээвэрлэлт, сэлгээний ажилд оролцогч ажилтнуудыг бие даан нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий өртөөний даргын ээлжийн туслах ажилтан

Радио галт тэрэг-Зүтгүүр дэх аюулгүй байдлын системээр иж бүрэн тоноглогдсон галт тэрэг /сүүлийн вагоны иж бүрдэл суурилагдсан./

Салбар зам – Сэлгээний болон ачих, буулгах ажил хийх зориулалтаар төмөр замын шугам болон өртөөний замаас салбарлаж тавьсан зам

Суурь бүтэц эзэмшигч - Суурь бүтцийг өмчлөх буюу эзэмших эрхтэй, суурь бүтэц ашиглах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд

Суурь бүтэц эзэмшигч-Суурь бүтцийг өмчлөх ба эзэмших эрхтэй, суурь бүтэц ашиглах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд

Сунгуу уруудуур – Дараах хэмжээний огцом ба урттай уруудуурыг хэлнэ:

Уруудуур	Үргэлжлэх урт
0.008-аас 0.010 хүртэл	8 км ба түүнээс илүү
0.011-ээс 0.014 хүртэл	6 км ба түүнээс илүү
0.0015-аас 0.017 хүртэл	5 км ба түүнээс илүү
0.018-аас 0.02 хүртэл	4 км ба түүнээс илүү
0.021 ба түүнээс огцом	2 км ба түүнээс илүү

Сунгуу уруудуур – Сунгуу уруудуур хэвгийн хэмжээг ашиглан татах тооцооны үед тухайн уруудуур дээр галт тэргийг жолоодох тормозын удирдлагын дэглэмийг тодорхойлоод зогсохгүй төмөр замын зураг төслийг зохиох явцад тухайн сунгуу уруудуурын өмнө байрлах өртөө зөрлөгийн зам, дохиолол, хориглолын байгууламжуудад тавигдах нэмэлт нөхцөл шаардлагуудын хэрэгцээг тодорхойлно. Сунгуу уруудуур хэвгийн онцлог нь тэдгээрийн үргэлжлэх хэмжээнээс хамаардаг онцлогтой.

Уруудуур

0,0008-0,001 хүртэл

0,011-0,014 хүртэл

0,0015-0,017 хүртэл

0,018-0,02 хүртэл

0,021 ба түүнээс огцом

Үргэлжлэх урт

8 км ба түүнээс илүү

6 км ба түүнээс илүү

5 км ба түүнээс илүү

4 км ба түүнээс илүү

2 км ба түүнээс илүү

Суман шилжүүлэг – Хөдлөх бүрэлдэхүүнийг нэг замаас нөгөө зам руу оруулахад зориулагдсан төхөөрөмж

Сумчны байр – Удирдлага нь төвлөрүүлэгдээгүй хэд хэдэн суман шилжүүлгийг сумчин шилжүүлэхэд зориулагдсан ажлын байр

Сумчны байр–Удирдлага нь төвлөрүүлэгдээгүй хэд хэдэн суман шилжүүлэгүүдийг үйлчилдэг сумчины /ажилтан/ ажлын байр. Уул байранд сум дохионы хамаарлын зарим тоноглолууд, сумыг шилжүүлэх, үйлчилэхэд шаардагдах багаж хэрэгслэлүүд тавигдсан байдаг

Сэлгээний удирдагч /найруулагч/-Сэлгээний ажил гүйцэтгэхэд оролцож буй ажилтнуудын үйл ажиллагааг шууд удирдах ажилтан

Сэлгээний бүрэлдэхүүн – Сэлгээ хийж байгаа зүтгүүртэй болон өөр хооронд нь холбосон бүлэг вагон

Сэргээн босгох галт тэрэг –

Татах зам - Өртөөний замууд дээр сэлгээний бүрэлдэхүүнийг татаж тараан байрлуулах зам

Технологийн холбоо –

Тоормосны зам – Машинчийн зогсоох цоргоны бариулыг тоормосны байдалд шилжүүлсэн агшнаас галт тэрэг бүрэн зогсох хүртэл хугацаанд галт

тэрэгний туулсан зам. Тоормосны замыг тоормослолтын төрлөөс шалтгаалж албаны, албаны бүрэн, яаралтай гэж ангилна

Тоормосны зам – Машинчийн татах цоргоны бариулыг тоормосны байдалд шилжүүлсэн агшнаас галт тэрэг бүрэн зогсох хүртэл хугацаанд галт тэрэгний туулсан зай. Тоормослолтын төрлөөс шалтгаалж албаны, албаны бүрэн, яаралтай гэж ангилна

Төмөр замын шугам – Төмөр замын хоорондын зам болон өртөө, зөрлөг дэх түүний үргэлжлэл

Төмөр замын шугам – Төмөр замын хоорондын зам болон өртөө зөрлөг дэх түүний үргэлжлэл. Галт тэрэгний хөдөлгөөнийг хангах техникийн байгууламж ба төхөөрөмжийн нэгдэл. Төмөр замын шугамыг гол замын тоогоор нь нэг, хоёр, олон замтай. Шаталтын төрлөөр нь цахилгаан, дотоод шаталтын. Зам төмрийн царгийн өргөнөөр нь өргөн, нарийн царигтай. Хөдөлгөөний онцлогоор нь ачааны, зорчигч тээврийн, холимог, хурдны. Зориулалтаар нь төмөр замын гол шугам, хот хоорондын, хот дүүргийн, салаа зам. Төмөр замын шугам өртөөдтэйгээ төмөр замын сүлжээг үүсгэнэ

Төвлөрүүлэгдсэн суман шилжүүлэг – Сум ба дохионы төвлөрүүлсэн удирдлагын байрнаас суман шилжүүлэг шорыг шилжүүлдэг тусгай байгууламж

Төвлөрүүлэгдсэн суман шилжүүлэг – Сум ба дохионы төвлөрүүлсэн удирдлагын байрнаас суман шилжүүлэг шорыг шилжүүлдэг байгууламж

Төвлөрүүлэгдээгүй суман шилжүүлэг – Сумны шилжүүлэх механизмын тусламжтайгаар шорыг гараар шилжүүлдэг сум

Төвлөрүүлэгдээгүй суман шилжүүлэг – Сумны шилжүүлэх механизмын тусламжтайгаар шорыг гараар шилжүүлдэг

Туслах пост – Замын хөгжилгүй зөвхөн салбар замын нийлсэн газрыг үйлчлэх хоорондын зам дахь пост

Туслах пост – Замын хөгжилгүй зөвхөн салбар замын нийлсэн газрыг үйлчлэх хоорондын зам дахь ажлын байр

Тусгай зориулалттай зам – Хоорондын зам болон өртөөн дэх хамгаалах, барих мухар зам, салбар зам

Тусгай найруулсан галт тэрэг –

Тусгай хөдлөх бүрэлдэхүүн – Цас, элс цэвэрлэгч, цас арилгах ба буталмал чулуу цэвэрлэх машин, чигжүүр, зам тавигч, өргөгч кран гэх мэт хөдлөх нэгж

Түлхэгч зүтгүүр – Төмөр замын өгсүүр ихтэй зарим хэсэгт нэг зүтгүүрийн хүчин чадлаас хэтэрсэн жинтэй галт тэргэнд зүтгүүрийн чадлыг нэмэгдүүлэх үүрэг бүхий зүтгүүр

Түлхэгч зүтгүүр – Төмөр замын өгсүүр ихтэй зарим хэсэгт нэг зүтгүүрийн хүчин чадлаас хэтэрсэн жинтэй галт тэргэнд зүтгүүрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх үүрэгтэй

Тээшийн галт тэрэг – Зорчигчийн ачаан тээшийг тээвэрлэх зориулалт бүхий вагонуудаар бүрдсэн, тогтоосон хуваариар явах галт тэрэг

Зорчигчийн ачаан тээшийг тээвэрлэх зориулалт бүхий дотоод тоног, техник хэрэгсэлтэй вагонуудаар бүрдсэн, тогтоосон хуваариар явах галт тэрэг

Тээшийн галт тэрэг – Зорчигчийн ачаан тээшийг тээвэрлэх зориулалт бүхий дотоод тоног, техник хэрэгсэлтэй вагонуудаар бүрдсэн, тогтоосон хуваариар явах галт тэрэг

Удирдлагын бүс –

Удирдах өртөө –

Урт бүрэлдэхүүнтэй галт тэрэг – Тогтоосон нормоос хэтэрсэн урт бүрэлдэхүүнтэй ачааны галт тэрэг

Төмөр замын тухайн хэсэг, өртөө, зөрлөгийн хүлээн авах, явуулах замын хамгийн их уртын нормоор хязгаарлах, зорчигчийн болон ачааны вагонуудтай галт тэрэг

Урт бүрэлдэхүүнтэй галт тэрэг – Төмөр замын тухайн хэсэг, өртөө, зөрлөгийн хүлээн авах, явуулах замын хамгийн их уртын нормоор хязгаарлах, зорчигчийн болон ачааны вагонуудтай галт тэрэг

Хажуугийн зам – Өртөөний гол замаас бусад зам. Хажуугийн зам руу хөдлөх бүрэлдэхүүн суман шилжүүлгээр даялан орно

Хамгаалах мухар зам – Өртөө, зөрлөгт галт тэрэг хүлээж явах, явуулах замнал руу хөдлөх бүрэлдэхүүн орохоос урьдчилан сэргийлэхэд зориулагдсан мухар зам

Хамгаалах мухар зам - Өртөө, зөрлөгт галт тэрэг хүлээн авах, явуулах замнал руу хөдлөх бүрэлдэхүүн орохоос урьдчилан сэргийлэх зориулалттай

Хамгаалах сум – Галт тэрэг хүлээн авах, явуулах замнал бэлтгэх үед хөдлөх бүрэлдэхүүнийг бэлтгэсэн замнал руу гаргахгүй байхаар тавигдсан сум

Хамгаалах сум – Өртөө, зөрлөгт галт тэрэг хүлээн авах, явуулах замнал бэлтгэх үед хөдлөх бүрэлдэхүүнийг замнал руу гаргахгүй байхаар тавигдсан сум

ХАХ-Е систем –

Хот дүүргийн галт тэрэг –

Хөдлөх бүрэлдэхүүн – Зүтгүүр, вагон, мотовоз зэрэг төмөр замаар явдаг техник

Зүтгүүр, вагон, түүнчлэн төмөр замаар явдаг бусад техник

Хөдлөх бүрэлдэхүүн – Зүтгүүр, вагон, түүнчлэн төмөр замаар явдаг бусад техникийг

Хөдлөх бүрэлдэхүүний овор – Шулуун, тэгш замд тавигдсан хөдлөх бүрэлдэхүүний ачаа гадагш цухуйхгүй дотор нь багтаж байх замын тэнхлэгт эгц хөндлөн хязгаарын хүрээ

Шулуун, тэгш замд тавигдсан хөдлөх бүрэлдэхүүн түүний эд, ачаа нь гадагш цухуйхгүй дотор нь багтаж байх замын тэнхлэгт эгц хөндлөн хязгаарын хүрээ

Хөдөлгөөн багатай хэсэг – Хоногт зурмагаар 8 хосоос бага зорчигчийн ба ачааны галт тэрэг өнгөрөх хэсэг

Хөргүүрт галт тэрэг – Түргэн муудаж гэмтэх ачаа тээвэрлэхэд зориулагдсан хөргөх төхөөрөмжтэй вагоноор найруулсан галт тэрэг

Хөргүүрт галт тэрэг – Түргэн муудаж, гэмтэх, тодорхой тогтоосон температурт тээвэрлэх ачаанд зориулагдсан, ажиллагаатай цахилгаан, хөргөлт, халаалт, агааржуулалтын системүүд, дизель зэргээр тоноглогдсон эдгээр техник, тоног төхөөрөмжийг байрлуулах бүтэц зохион байгуулалт бүхий тэвштэй вагонуудаар найруулсан галт тэрэг

Хүлээн авах явуулах зам - Өртөө, зөрлөгт галт тэрэг хоорондын замаас хүлээн авах, явуулах зориулалттай зам

Хүлээн авах явуулах зам - Зорчигч буулгах, суулгах, галт тэрэг зөрүүлэх, технологи ажиллагаа гүйцэтгэдэг өртөөний зам

Хүмүүсийн галт тэрэг – Хүмүүс суулгасан 10 ба түүнээс дээш вагон бүхий ачааны галт тэрэг

Хэвгий – Төмөр замын өгсүүр, уруудуур хэсэг

Хэсэглэх газар – төмөр замын шугамыг хоорондын зам болгон хэсэглэх газар

Хэсгийн өртөө - Зүтгүүр, зүтгүүрийн бригад солих, хөдлөх бүрэлдэхүүнд техникийн болон ачаа тээврийн үзлэг шалгалт, ачилт, буулгалт, зэхэлт хийх, галт тэргийг шинэчлэн найруулах зорилго бүхий өртөө

Цонх – Хоорондын ба өртөөний зам засварлах, уртасгах ажил хийх зорилгоор хөдлөх бүрэлдэхүүн өнгөрөхийг түр зогсоох хугацаа

Яаралтай тоормослолт – Галт тэргийг маш богино хугацаанд зогсоох зорилгоор хийх үйлдэл. Энэ агшинд тоормосны гол хоолой дахь агаарын даралт 0 кг/см² болтол огцом буурдаг

Ялгалтын зам – Сэлгээний дов болон татах замаас бүрэлдэхүүнийг тараан байрлуулж найруулахад зориулсан бүлэг зам

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ НИЙТЛЭГ ҮҮРЭГ

2.1. Төмөр замын тээврийн ажилтан дор дурдсан нийтлэг үүрэгтэй байна.

2.1.1. Төмөр замын тээврийн тухай хууль, **нийтлэг багц дүрмийг** чанд биелүүлэх, техник хэрэгслийг технологийн горим, стандартын дагуу ашиглах, зорчигчийн аялах аятай нөхцөлийг бүрдүүлэх, ачаа, тээш, ачаан тээшийг бүрэн бүтэн тээвэрлэх, үйлчлүүлэгчийн тээвэрлэлтийн **хэрэгцээ** ба галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг найдвартай хангах, хүрээлэн буй орчинд хохирол учруулахгүй байх;

2.1.2. Техник ашиглалтын **дүрмийн шаардлага**, төмөр замын тээврийн хэвийн, аюулгүй үйл ажиллагааг хангахад чиглэсэн өөрийн үүргийг биечлэн **гүйцэтгэх**;

2.1.3. Төмөр замын **байгууллагын** ажилтнаар техник ашиглалтын **дүрмийг** сахин биелүүлэх шаардлага тавих үүргийг **ажил олгогч, ажил удирдагч** хариуцах;

2.1.4. Хүний эрүүл мэнд, амь нас, хөдөлгөөний аюулгүй ажиллагаанд хохирол учруулахуйц гэмтэл, саад илэрвэл нэн даруй галт тэрэгний болон сэлгээний хөдлөх бүрэлдэхүүнийг зогсоох, уул саадтай газрыг хааж хамгаалах, гэмтлийг түргэн засаж арилгах арга хэмжээ авах;

2.1.5. Төмөр замаар үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг бүрэн хангаж эелдэг, уриалгахан хөнгөн шуурхай үйлчилж, тэднээс төмөр замын тээвэрт тогтоосон **дүрэм журмыг** сахин биелүүлэхийг шаардах;

2.1.6. Албан үүргээ гүйцэтгэхдээ тухайн байгуулагаас тогтоосон **дүрэмт хувцас, ялгах тэмдгийг зохих журмын дагуу хэрэглэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагын үүднээс олгогдсон хамгаалах хэрэгсэл, ажлын тусгай хувцасыг бүрэн хэрэглэх;**

2.1.7. Хөдөлмөрийн аюулгүй **байдал**, эрүүл ахуйн болон галын аюулгүй байдлыг хангах дүрэм, журам, стандарт, хэмжил зүйн норм, нормативыг мөрдөж ажиллах.Тухайн аж ахуйн нэгжийн удирдлага эдгээр дүрэм, журмын биелэлтийг хариуцах;

2.1.8. Зүтгүүр, төмөр замаар өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүн ба хөдлөх нэгжийн жолоодлогын бүхээг болон хөдөлгөөний аюулгүй ажилллагааг хангахтай холбогдсон дохио, сум, аппарат, хэрэгсэл, механизм мөн түүнчлэн дээр дурдсан тоног төхөөрөмжийг удирдан ажиллуулдаг байранд зохих эрхгүй хүнийг үл оруулах;

2.1.9. Зохих эрхтэй **ажилтан** албан үүргээ **гүйцэтгэхдээ** зүтгүүр, төмөр замаар өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүн ба хөдлөх нэгжийг жолоодох болон хөдөлгөөний хэвийн ажиллагаа хангахтай холбогдсон дохио, сум, аппарат, хэрэгсэл, механизмыг ажиллуулах;

2.1.10. Харьяалал болон өмчийн төрөл хэлбэрээс үл хамаарч зүтгүүр, моторт вагон, галт тэрэг, өөрөө явагч бусад хөдөлгөөнт нэгжийг жолоодох, тэдгээрийн хөдөлгөөнийг удирдах төмөр замын ажилтан нь мэргэжлийн сургалтын байгууллага (төв)-д бэлтгэгдэж, эрхийн үнэмлэх авсан байх;

2.1.11. Зохих журмын дагуу **дадлагажигч ажилтанг** зүтгүүр, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүн ба хөдлөх нэгжийг жолоодох болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон дохио, сум, аппарат, бусад механизмыг эрх бүхий ажилтны хяналт дор жолоодох, ажиллуулахыг зөвшөөрөх;

2.2. Төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам эзэмшигч нь галт тэрэгний ба сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой үйл ажиллагаа явуулдаг ажилтан нартаа техникийн сургалт явуулах, мэргэжлийг нь дээшлүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

2.3. Харин зүтгүүрийн бригад, галт тэрэгний зохицуулагч, өртөөний жижүүр, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний бригадын ажилтанг мэргэжлээр нь бэлтгэж, сонгон шалгаруулж ажиллуулна. Мэргэжилтэн бэлтгэх, сонгон шалгаруулалт явуулах журмыг Төрийн захиргааны **төв** байгууллага батална.

2.4. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан нь тогтоосон журмаар мэргэжлийн сургалтад хамрагдаж, мэргэжил дээшлүүлж, шалгалт өгч тэнцсэн байх:

- Монгол Улсын төмөр замын тээврийн тухай хууль
- Төмөр замын техник ашиглалтын дүрэм
- Төмөр замын дохиолол **холбооны** журам
- Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам
- Ажлын байрны тодорхойлолт болон тэдний үүргийг тогтоосон бусад баримт бичиг
- Хөдөлмөрийн аюулгүй **байдал**, эрүүл ахуйн стандарт, дүрэм, журам
- Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой төмөр замын ажилтны сахилгын тусгай журам

– Вагон болон чингэлэгт ачаа ачих, бэхлэх болон ачилт буулгалтын ажил хариуцсан ажилтан хөдлөх бүрэлдэхүүнд ачаа ачих, бэхлэх техникийн нөхцөлийн талаар шалгалтад хамрагдсан байх.

2.5. Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд бус холбоотой ажилтан нь нийтлэг үүргийг мэдэж байхаас гадна хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан байх.

2.6. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой нэмэлт ажил, үүрэг гүйцэтгэхээр албан тушаал хавсрах, ажил, мэргэжил хослох, түр эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгүүлэхэд тогтоосон журмын дагуу сургалтад хамрагдаж, шалгалт өгсөн төмөр замын тээврийн ажилтанг томилон ажиллуулах.

2.7. Мэргэжлийн сургалтад хамрагдаж, төмөр замын тээврийн хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмаар шалгалт өгсөн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон журмын дагуу эрүүл мэндийн үечилсэн үзлэгт орж тэнцсэн, 18 насанд хүрсэн иргэнийг галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил, албан тушаалд томилон ажиллуулна. (Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11-т тус жагсаалтыг төрийн захиргааны төв байгууллага батлахаар хуульчлагдсан)

~~— Зүтгүүр, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүн /моторт вагон, галт тэрэг, мотовоз, тусгай автомоторис, төмөр замаар явдаг барилгын машин, кран г.м./-ийн машинч, туслах машинч~~

~~— Галт тэрэг өртөөний, сэлгээний, зүтгүүрийн, эрчим хүчний, вагоны паркийн зохицуулагч диспетчер~~

~~— Өртөө, зөрлөг, парк, суман шилжүүлэг удирдлагын байр, гарам, довын жижүүр, түүний туслах~~

~~— Өртөөний жижүүр, сэлгээний диспетчер, ялгах довын, төвлөрсөн постын, вагоны техник үйлчилгээний оператор, зам хэмжигчийн оператор, сэв шалгах тэргэнцэрийн оператор~~

~~— Галт тэрэгний найруулагч, түүний туслах, вагоны хөдөлгөөний хурдыг төхируулагч ивүүрчин~~

~~— Дохиочин, сумчин~~

~~— Галт тэрэгний ачаа вагон хүлээлцэгч~~

~~— Зам, гүүр, хонгил, эрчим хүч хангамж, вагоны техник үйлчилгээний газар, вагон салгахгүй засварлах мастер~~

~~— Суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний засварын мастер~~

~~— Вагон үзэгч~~

~~— Зам ба хиймэл байгууламжийг арчлах, засах бригадын дарга~~

~~— Зам ба хиймэл байгууламжийн эргүүлийн ажилтан~~

~~— Зам хэмжигч вагоны төхируулагч /накладчик/~~

~~— 3-аас дээш зэрэгтэй замчин~~

~~— Зөрчигчийн галт тэрэгний дарга, мастер~~

~~— Галт тэрэгний цахилгаан механик~~

~~— Вагоны үйлчлэгч~~

~~— Хөргүүрт вагоны механик~~

~~— Дохиолол, хөлбооны байгууламжийг засварлах ба үйлчлэх цахилгаан механик, монтёр~~

~~— Өндөр хүчдлийн шугам татах ба трансформаторын дэд станц, цахилгаан хэлхээний сүлжээний өндөр хүчдэлийн дор засварлах, үйлчлэх цахилгаан мастер, монтёр~~

2.8. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны ажлын байр нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАЙГУУЛАМЖ, ТӨХӨӨРӨМЖ

3.1. Ерөнхий зүйл, овор

3.1.1. Төмөр замын тээврийн байгууламж ба төхөөрөмж (цаашид “байгууламж ба төхөөрөмж” гэх) нь эвдрэл, гэмтэл, доголдолгүй бүрэн бүтэн байна.

3.1.2. Байгууламж ба төхөөрөмжид эвдрэл гэмтлээс гарахаас урьдчилан сэргийлэх, эдэлгээний удаан хугацааг хангах, нормативт үзлэг шалгалтыг тогтмол хийх, техникийн засвар үйлчилгээг чанартай гүйцэтгэх, хэвийн ажиллагааг хангах явдал нь тухайн **байгууламж төхөөрөмжийг** ашиглаж байгаа өртөө, депо, хэсэг, аж ахуйн нэгж, тэдгээрийн удирдах болон төхөөрөмж, байгууламжийг **хариуцсан** ажилтны гол үүрэг байна. Ажилтан нь албан үүргийн хүрээнд **байгууламж, төхөөрөмжийн** ашиглалтын дүрэм, журам, заавар, стандартад тавигдах шаардлагыг мэдсэн байна.

3.1.3. **Байгууламж, төхөөрөмж**, механизм, тоноглол нь батлагдсан стандарт, зураг төслийн баримт бичиг болон техникийн нөхцөлд тохирсон байх ба **Төрийн** захиргааны **төв** байгууллагаас баталсан журмын дагуу гэрчилгээтэй байна. Эдгээр нь техникийн ба ашиглалтын чухал өгөгдлийг тусгасан паспорттой байна.

3.1.4. **Байгууламж, төхөөрөмж** нь эрх бүхий байгууллагаас тогтоосон хурдтайгаар галт тэргийг өнгөрүүлэх шаардлагыг хангасан байна.

3.1.5. **Байгууламж, төхөөрөмжийн** зураг төслийн баримт бичиг батлах эрх бүхий **этгээд** зөвшөөрсөн тохиолдолд тухайн **байгууламж, төхөөрөмжийн** бүтцэд өөрчлөлт оруулж болно.

3.1.6. Суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, үндсэн байгууламж, төхөөрөмжийн үечилсэн засварын хугацаа, ангиллыг холбогдох стандартаар тогтоох ба харин арчлалтын норм, журам, үлгэрчилсэн технологийн горимыг суурь бүтэц эзэмшигч батална.

3.1.7. Шинээр барьсан ба шинэчилсэн төмөр замын шугам, барилга байгууламж, төхөөрөмжийг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу ашиглалтад хүлээн авна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмыг үндэслэн тогтоосон техникийн баримт бичиг (техник захиражийн акт, ажиллах журам)-ийг баталж, уул байгууламж

төхөөрөмжийг үйлчлэх ажилтан дээрх баримт бичгийн мэдлэгээр шалгалт өгсний дараа ажиллуулах зөвшөөрлийг олгоно.

3.1.8. Төмөр замын гол ба салбар замын байгууламж, төхөөрөмж нь улсын стандартаар тогтоосон төмөр замд барилга, байгууламжийн ойртох хязгаар болон хөдлөх бүрэлдэхүүний «С» оврын шаардлага хангасан байна.

3.1.9. Депо, засварын газар, ачих буулгах талбай болон байгууллага, аж ахуйн нэгж, компанийн үйлдвэрийн байгууламж, төхөөрөмж, үйлдвэрийн дэвсгэр нутгийн хоорондох байгууламж төхөөрөмж нь улсын стандартаар тогтоосон төмөр замд барилга, байгууламжийн ойртох хязгаар болон хөдлөх бүрэлдэхүүний «СП» оврын шаардлагыг хангасан байна.

3.1.10. Шинээр барих ба шинэчлэх байгууламж, төхөөрөмж дээр дурдсан стандартын «С» ба «СП» оворот тохирсон байх шаардлагатай.

3.1.11. Барилгын засварын болон бусад ажлыг гүйцэтгэхэд байгууламж, төхөөрөмжийн овор хэмжээг зөрчихийг хориглоно.

3.1.12. Төмөр замын гол ба салбар замын байгууламж, төхөөрөмж нь улсын стандартаар тогтоосон төмөр замд барилга, байгууламжийн ойртох хязгаар болон хөдлөх бүрэлдэхүүний "А", "Б", "С" "Е" оврын шаардлага хангасан байна.

3.1.13. Депо, засварын газар, ачих буулгах талбай болон байгууллага, аж ахуй нэгж, компанийн үйлдвэрийн байгууламж, төхөөрөмж, үйлдвэрийн дэвсгэр нутгийн хоорондох байгууламж төхөөрөмж нь улсын стандартаар тогтоосон төмөр замд барилга, байгууламжийн ойртох хязгаар "Д", "СП" оврын шаардлагыг хангасан байна.

3.1.14. Шинээр барих ба шинэчлэх байгууламж, төхөөрөмж дээр дурдсан стандартын "А", "Б", "Д", "С", "Е" ба "СП" оворот тохирсон байх шаардлагатай.

3.1.15. Барилгын засварын болон бусад ажлыг гүйцэтгэхэд төхөөрөмж, байгууламжийн овор хэмжээг зөрчихийг хориглоно.

3.1.16. Хос замт шугамын замын тэнхлэг хоорондын зай шулуун хэсэгт 4100 мм-ээс доошгүй байна. Өртөөн дээрх зэргэлдээ замуудын тэнхлэг хоорондын зай шулуун хэсэгт 4800 мм-ээс доошгүй, туслах чанарын зам, хөдлөх бүрэлдэхүүн зогсоох зам, ачих буулгах талбайн замуудын тэнхлэг хоорондын зай 4500 мм-ээс доошгүй байна.

3.1.17. Ачааг нэг вагоноос нөгөө вагонд шилжүүлэн ачихад зориулагдсан замын тэнхлэг хоорондын зай 3600 мм байж болно. Тахир хэсэг дэх зэргэлдээ замуудын тэнхлэг, өртөө ба хоорондын зам дахь замын тэнхлэг, барилга, байгууламжийн ойртолтын оврын хоорондын хэвтээ зайг төмөр замд барилга байгууламж ойртох ба хөдлөх бүрэлдэхүүний оврын стандартад нийцүүлэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар тогтооно.

3.1.18. Задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачсан ачаа /сав, баглаа, боодол, бэхэлгээг оролцуулан/ замын хэмжээнд ачилтын тогтоосон овор хэмжээний дотор байрлагдсан байна. Задгай хөдлөх бүрэлдэхүүний ачилтын овор хэмжээний дотор байрлуулах боломжгүй ачааг хэтрүү овортой ачаа тээвэрлэх тухай Төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон журмаар тээвэрлэнэ. Ачилт их хийдэг

газар болон салбар замд ачааг овор хэмжээний дотор зөв байрлуулсан эсэхийг шалгах **зориулалттай** оврын хаалга байгуулна.

3.1.19. Замын дэргэд буулгах буюу ачихаар бэлтгэсэн ачааг төмөр замд барилга, байгууламжийн ойртох болон хөдлөх бүрэлдэхүүний оврын стандартад заасан зайд хурааж бэхэлнэ. Зам засварын ажилд зориулан буулгах чигжээнээс бусад ачааг 1200 мм хүртэл өндөртэй бол захын зам төмрийн толгойн гадна ирмэгээс 2.0 метр, түүнээс өндөр бол 2.5 метрээс ойргүй зайд байрлуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЗАМЫН АЖ АХУЙН БАЙГУУЛАМЖ, ТӨХӨӨРӨМЖ

4.1. Төмөр замын суурь бүтэц нь өөрийн орны болон **хүлээн** зөвшөөрөгдсөн олон улсын стандартын шаардлагыг хангасан, тухайн хэсэгт тогтоосон хамгийн их хурдтай явах галт тэрэгний аюулгүй бөгөөд жигд хөдөлгөөнийг хангаж байна.

4.2. Замын засвар, арчлалт, үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжийн байрлал, түүний зам, техник байгууламж, төхөөрөмж нь тогтоосон жин, хурдтай галт тэргийг нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

ЗАМЫН ДЭВСГЭР БА ОГТЛОЛ ЗУРАГ

4.3. Замын эргэлтийн өнцөг, радиус, түүний тойрог ба шулуун хэсгийн холбоос, хэвгийн босоо хавтгай дахь элементүүдийн өөр хоорондын холбогдох нөхцөл ба хэвгийн аяс зэрэг нь замын батлагдсан дэвсгэр, дагуу, хөндлөн огтлолын зураг тохирч байна.

4.4. Өртөө, зөрлөг болон гүйцэж түрүүлэх газрыг тэгш шулуун талбарт байрлуулах боловч шаардлагатай тохиолдолд 0,0015-аас үл хэтрэх хэвгйд байрлуулж болно.

4.5. Бартаатай нөхцөлд хэвгийн хэмжээг ихэсгэхийг зөвшөөрөх боловч 0,0025-аас ихгүй байна. Харин газар зүйн байрлалын хувьд онц бартаатай газарт хэвгийн хэмжээ Төрийн захиргааны **төв** байгууллагын зөвшөөрснөөр 0,0025-аас их байж болно. Замын хэвгий нь 0,0025-наас их хэсэглэх газарт сэлгээ хийж зүтгүүр ба вагоныг бүрэлдэхүүнээс салгахыг хориглоно.

4.6. 0,0015 хэвгйд өртөө, зөрлөг болон гүйцэж түрүүлэх газрыг байрлуулах ба бартаатай нөхцөлд 0,0025 хүртэл ихэсгэхийг Төрийн захиргааны **төв** байгууллагын зөвшөөрсөн техникийн нөхцөлөөр шийдвэрлэнэ.

4.7. Хэвгий газарт байрласан өртөө, зөрлөгт тогтоосон нормын жинтэй галт тэрэг байрнаас хөдлөх нөхцөлийг хангасан байна. Хоорондын замд зорчигчийн галт тэрэг байрнаас хөдлөж болохуйц 0,006-аас ихгүй хэвгийтэй газар зорчигчийн бууж суух зогсоолыг байгуулж болох ба онцгой тохиолдолд 0,006-аас 0,008 хүртэл хэвгийтэй газар зогсоол байгуулах зөвшөөрлийг Төрийн захиргааны **төв** байгууллага өгнө.

4.8. Өртөө, зөрлөг, гүйцэж түрүүлэх газар, зарим парк, татах замыг шулуун хэсэгт байрлуулна. Эдгээрийг хүнд нөхцөлд хурдны замд 2000 метр, I ба II зэрэглэлийн замд 1500 метр, III ба IV зэрэглэлийн замд 1200 метр радиустай тахир хэсэгт байгуулна.

4.9. Онц хүнд нөхцөлд I ба II зэрэглэлийн замд 600 метр, III ба IV зэрэглэлийн замд 500 метр радиустай тахир хэсэгт байгуулж болно.

4.10. Хүнд нөхцөлд татах замыг 500 метр хүртэлх радиустай тахир хэсэгт байгуулж болно.

4.11. Хэсэглэх газрын гол замыг тахир хэсэгт байрлуулах бол суман шилжүүлгийг замын шулуун хэсэгт байрлуулна. **Салбар замыг 200 метрээс багагүй буюу түүнээс дээш радиустай тойрог хэсэгт байрлуулж болно.**

4.12. Өртөөний хүлээн авах, явуулах зам, бусад замд нийлсэн салбар ба холбох зам нь өртөө буюу хоорондын зам руу хөдлөх бүрэлдэхүүн өөрөө өнхөрч гарахаас сэргийлсэн хамгаалах сум буюу хамгаалах мухар замтай байна.

4.13. Хамгаалах мухар замын ашигтай урт 50 метрээс доошгүй байна. Сунгуу руудуур бүхий хоорондын замын өмнөх өртөөнд шаардлагатай бол суурь бүтэц эзэмшигчийн баталсан зураг төслийн дагуу барих мухар зам барина.

4.14. Гол ба өртөөний зам, салбар замын дэвсгэр ба дагуу огтлолын байдлыг багаж хэрэгслээр тодорхой хугацаанд тогтмол шалгаж байна.

4.15. Дэвсгэр ба дагуу огтлолын байдлыг өөрчлөхөд хүргэсэн замын шинэчлэлт буюу бусад ажил хийгдэж байгаа хэсгүүдийг ажил дуусмагц гүйцэтгэгч байгууллагын захиалгаар эрх бүхий зураг төслийн байгууллага зохих шалгалтыг хийж холбогдох бичиг баримтыг замын засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжид шилжүүлж өгнө.

4.16. Ялгах, хэсгийн, ачааны томоохон өртөөн дээрх ялгах дов, довын бэлийн болон татах замуудын тууш огтлолыг 3 жилд нэгээс доошгүй удаа, бусад замд 10 жилд нэгээс доошгүй удаа тусгай багаж ашиглан шалгана.

4.17. Зам эзэмшигч аж ахуйн нэгж өөрийн эзэмшилд байгаа замын аж ахуйн бүх **байгууламж, төхөөрөмжийн** масштаб, бүдүүвч зураг, замуудын дагуу ба хөндлөн огтлолын зураг, баримт бичигтэй байна.

4.18. Замын огтлолын зураг, өртөөний масштаб ба бүдүүвч дэвсгэр зургийг эрх бүхий зураг төслийн байгууллага гүйцэтгэнэ.

ЗАМЫН УЛ ШОРОО, ДЭЭД БҮТЭЦ, ХИЙМЭЛ ТӨХӨӨРӨМЖ

4.19. Замын шулуун хэсэг дэх ул шорооны үндсэн талбайн өргөн нь тухайн замын дээд бүтэцтэй тохирч байвал зохино. Төмөр замын шугам нь нэг замтай хэсэгт 5,5 метр, хоёр замтай хэсэгт 9,6 метр, хадархаг ба шүүрүүлэгч хөрстэй хэсэгт нэг замтай бол 5,0 метр, хоёр замтай бол 9,1 метрээс багагүй байна.

4.20. Хоорондын замын шулуун хэсэгт шинээр баригдах төмөр замын ул шорооны дээд талын өргөний хэмжээ нь стандартын шаардлагад нийцсэн байна.

4.21. 2000 метрээс бага радиустай замын тахир хэсэгт ул шороог тогтоосон нормын дагуу өргөсгөнө. Шинээр барьж байгуулах төмөр замын шугамын ул шорооны үндсэн талбайн өргөнийг батлагдсан стандартаар гүйцэтгэнэ. Шинээр баригдсан төмөр замын ул шорооны дэнж замын хоёр талд 0,4м-ээс багагүй байна.

4.22. Ус хальдаг газрын ул шорооны ирмэг нь хүчтэй салхилах үеийн усны долгионы хамгийн их өндрөөс дээш 0.5 метрээс багагүй өндөр байна.

4.23. Замын шулуун хэсэгт болон 350 метр ба түүнээс их радиустай тахир хэсгийн зам төмрийн толгойн дотор талын талстуудын хоорондох царигийн өргөн нь өргөн царигийн төмөр замд 1520 мм, нарийн царигийн замд 1435 мм тус тус байна. Бага радиустай тахир хэсгийн царигийн өргөнийг доорх байдлаар тогтооно.

а. Өргөн царигийн төмөр замд:

349 метрээс 300 метр радиустай бол 1530 мм

299 метрээс бага радиустай бол 1535 мм

б. Нарийн царигийн төмөр замд:

349 метрээс 300 метр радиустай бол 1440 мм

299 метрээс бага радиустай бол 1450 мм байна.

4.24. Ашиглагдаж байгаа өргөн царигийн төмөр замыг 1520 мм царигт шилжүүлж дуусах хүртэл царигийн өргөн нь шулуун болон 651 метр ба түүнээс их радиустай тахир хэсэгт 1524 мм байж болно. Тийм хэсэгт бага радиустай тахирын царигийн өргөн нь доорхи хэмжээнээс хэтрэхгүй байна.

650 метрээс 451 метр радиустай бол 1530 мм

450 метрээс 351 метр радиустай бол 1535 мм

350 метрээс бага радиустай бол 1540 мм

4.25. Өргөн ба нарийн царигийн төмөр замын шулуун болон тахир хэсгүүдийн царигийн өргөний өөрчлөлтийн байж болох хүлцэлийн хэмжээ нь өргөсгөхөд 8 мм, нарийсгахад 4 мм-ээс хэтрэх ёсгүй. **349м ба түүнээс бага радиустай тахирт царигийн нарийсалт нь 6мм байж болно.** Хэрэв зам төмөр нь хажуугийн элэгдэлтэй байвал 650 метрээс бага радиустай тахир хэсгийн царигийн өргөсөлтийн хэмжээ нь 6 мм-ээс их буюу зам төмрийн толгойн дотор талын ажлын талстуудын бодит элэгдлийн хэмжээгээр өргөссөн байж болно. Тэгэхдээ тахир хэсгийн царигийн өргөн нь 350 метр ба түүнээс их радиустай тахирын өргөн царигийн төмөр замд 1535 мм-ээс, нарийн царигийн төмөр замд 1450 мм-ээс, 349 метрээс бага радиустай тахирын өргөн царигийн замд 1546 мм-ээс, нарийн царигийн замд 1461 мм-ээс тус тус хэтрэх ёсгүй.

4.26. Замын шулуун хэсэгт хоёр талын зам төмрийн толгойн дээд тал нэг түвшинд байна. Мөн энэ хэсэгт бүх уртын туршид нэг талын зам төмөр нөгөө талынхаас 6 мм өндөр байхаар арчилахыг зөвшөөрнө.

4.27. Замын тахир хэсгийн гадна талын зам төмрийн өндөрлөлтийг тахирын радиус ба түүгээр явах хөдөлгөөний хурдыг харгалзан суурь бүтэц эзэмшигчийн тушаалаар тогтоох бөгөөд, хэмжээ нь 150 мм-ээс хэтрэх ёсгүй. Харин шаардлагатай үед гол замын тахир хэсэгт Төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр уг өндөрлөлтийг 150 мм-ээс их байлгаж болно.

4.28. Замын шулуун ба тахир хэсгийн хоёр зам төмрийн түвшингийн зөрүү нь тогтоосон нормоос 4 мм-ээс илүүгүй байж болно.

4.29. Онцгой том хэмжээтэй, галт тэрэгний хөдөлгөөнд чухал үүрэг бүхий хиймэл төхөөрөмжийн жагсаалт, геологийн хүнд нөхцөлд байгаа болон хэв гажилтын нөлөөлөлд байгаа эдгээр төхөөрөмжийн ашиглалтын явцад хяналт тавих журмыг холбогдох эрх бүхий байгууллагатай зөвшилцөн суурь бүтэц эзэмшигч тогтооно.

4.30. Хиймэл төхөөрөмж нь шаардлагатай үед үзлэг хийх зориулалтын төхөөрөмж хэрэгсэлтэй байна. Дохиоллын ба оврын хяналтын төхөөрөмжөөр тоноглох гүүр, хоолойн жагсаалтыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

4.31. Төмөр замын гүүрийн байгууламж нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тооцооны нормыг үндэслэн даацаараа ангилагдан, арчлагдана.

4.32. Зам, замын байгууламжийн бүх төхөөрөмж нь зураг, стандарт нормтой байна.

4.33. Замын байдалд байнгын хяналт тавихад оношилгооны вагон, дрезин, автоматрис болон тэргэнцэр хэрэглэнэ.

ЗАМ ТӨМӨР

4.34. Зам төмөр нь галт тэрэгний хурд, нэг гол дээрх ачаалал, ачааны нягтралаас хамаарсан ашиглалтын шаардлага, нөхцөлд нийцэж байна.

4.35. Гол ба хүлээн авах, явуулах замын зам төмрийг суурь бүтэц эзэмшигчийн баталсан үечлэлийн дагуу оношилгооны хэрэгслээр шалгаж байна.

4.36. Ачааны эрчимжилт нь жилд 10 сая тонн километрээс их бөгөөд ачааны галт тэрэг 90 км/цаг, зорчигчийн галт тэрэг 120 км/цаг хүртэл хурдтай явдаг замд, зам төмрийн толгойн элэгдэл дараах хэмжээнээс хэтрэхгүй байна.

1м уртын жин 60кг ба түүнээс хүнд маягийн зам төмөрт:

Нийлмэл 12 мм

Хажуугийн 15 мм

1м уртын жин 50кг ба түүнээс хүнд маягийн зам төмөрт:

Нийлмэл 10 мм
Хажуугийн 13 мм

1м уртын жин 43кг ба түүнээс хүнд маягийн зам төмөрт:

Нийлмэл 6 мм
Хажуугийн 8 мм

Харин жилд 1 километрт оногдох ачааны хэмжээ 10 сая бохир тонн километрээс бага байвал:

1м уртын жин 60кг ба түүнээс хүнд маягийн зам төмөрт:

Нийлмэл 16 мм
Хажуугийн 15 мм

1м уртын жин 50кг ба түүнээс хүнд маягийн зам төмөрт:

Нийлмэл 13 мм
Хажуугийн 13 мм

1м уртын жин 43кг ба түүнээс хүнд маягийн зам төмөрт:

Нийлмэл 9 мм
Хажуугийн 10 мм

Элэгдэлтэй зам төмрийг гол ба өртөөний замд тавих журмыг суурь бүтэц эзэмшигч **батална**.

СУМАН ШИЛЖҮҮЛЭГ

4.37. Суман шилжүүлэг нь батлагдсан зураг ба замд тавьсан зам төмрийн маягтай тохирч байна. Суман шилжүүлэг нь дор дурдсан маркийн тоонолжтой байна.

а. Гол зам ба зорчигчийн галт тэрэг хүлээн авах, явуулах замд 1/11-ээс огцом биш, огтлолцсон замын үргэлжлэл болох зөрсөн ба дан суманд 1/9-ээс огцом биш, зорчигчийн галт тэрэг зөвхөн шулуун замаар өнгөрөх суман шилжүүлэг 1/9 маркийн тоонолжтой байж болно.

б. Ачааны хөдөлгөөнд зориулагдсан хүлээн авах, явуулах замд 1/9-ээс огцом биш, хэм тэнцүү салсан замын суманд 1/6-ээс огцом биш байна.

в. Гол зам дахь сөргүү сумны шорын өмнө хамгаалах хөндлөвч тавьсан байна.

4.38. Дараах гэмтэлтэй суман шилжүүлгийг ашиглахыг хориглоно.

а. Сумны шорын холбоос салсан.

б. Сумны нэгдүгээр татуургын эсрэг хэмжихэд шор нь жааз зам төмрөөс 4 мм ба түүнээс их завсартай болсон.

в. Шор эмтэрснээс дугуйн дэл шорон дээр гарах аюултай болсон, гол зам дахь сумны шор 200 мм ба түүнээс илүү, хүлээн авах-явуулах зам дахь сумны шор 300 мм ба түүнээс илүү, өртөөний бусад зам дахь сумны шор 400 мм ба түүнээс урт эмтэрсэн.

г. **Суман шилжүүлэг** шорын толгойн өргөн дээгүүрээ 50 мм ба түүнээс илүү байдаг огтлолд хэмжилт хийхэд шор жааз зам төмрөөс 2 мм ба түүнээс илүү суусан.

д. Суман шилжүүлгийн тоонолжийн зүрхэвчийн болон хаших зам төмрийн толгойн ажлын талстуудын хоорондын зай 1524 мм-ийн царигт 1477 мм-ээс, 1520 мм-ийн царигт **1472** мм-ээс, 1435 мм-ийн царигт 1391 мм-ээс тус тус бага байвал.

е. Хаших зам төмөр ба сахал зам төмөр хоёрын ажлын талстуудын хоорондын зай өргөн царигийн суман шилжүүлэгт 1435 мм-ээс, нарийн царигт 1348 мм-ээс их байвал

з. Тоонолж зүрхэвч, сахал төмөр буюу хаших төмөр хугарсан.

ж. Шор буюу жааз зам төмөр хугарсан.

и. Хаших зам төмрийн **2 нүхтэй хавчуулгатай үед 2 боолт тасарсан, 1 нүхтэй хавчуулгатай үед 1 боолт тасарсан.**

к. Жааз зам төмөр, шор, тоонолжийн зүрхэвч, сахал **зам** төмрийн босоо элэгдэл гол замд 6 мм, хүлээн авах явуулах замд 8 мм, бусад замд 10 мм-ээс их болсон.

4.39. Өртөөнд суман шилжүүлэг тавих болон авахыг суурь бүтэц эзэмшигчийн шийдвэрээр гүйцэтгэнэ.

4.40. Өртөөнд ба хоорондын замд шинээр тавьсан болон шинэчилсэн суман шилжүүлгийг суурь бүтэц эзэмшигчээс томилогдсон комисс хүлээн авна.

4.41. Дор дурдсан төвлөрүүлээгүй суман шилжүүлгийг хяналтын цоожоор тоногдсон байна.

а. Галт тэрэг хүлээн авах, явуулах замын сум, хамгаалалтын сум

б. Тэсэрч дэлбэрэх аюултай ачаатай вагон зогсоход зориулсан зам руу оруулах сум

в. Сэргээн босгох ба галын галт тэрэг зогсоход зориулагдсан зам руу оруулах сум

г. Хамгаалах ба барих мухар зам руу оруулах сум

д. Оношилгооны вагон, замын машин зогсоход зориулагдсан зам руу оруулах сум, дов, ялгах замд байрлуулснаас бусад төвлөрүүлсэн, хяналтын цоож бүхий **сумууд** нь зүүдэг цоожоор цоожилж болохуйц хэрэгслээр тоноглогдсон байна.

4.42. Төвлөрүүлээгүй сумыг гэрэлтүүлдэг ба гэрэлтүүлдэггүй сум заагчаар тоноглоно. Энэ талаар өртөөний техник-захирамжийн актад заана.

4.43. Суман шилжүүлэг, суман шилжүүлэг заагч, хаягч сум, шор, вагон бэхлэх суурин төхөөрөмжийг тавих, суурилуулах, засварлах, арчлах ажлыг **суурь бүтэц эзэмшигчийн** зам хариуцсан **нэгж** гүйцэтгэнэ.

4.44. Харин суман шилжүүлэг, суман шилжүүлэг заагч, хаягч сум, шор, вагон бэхлэх суурин төхөөрөмж нь дохиолол төвлөрүүлэлт хориглол, эрчим хүчний байгууламж, **хэрэгслээр** тоноглогдсон бол тэдгээрийн засвар, техникийн үйлчилгээг **суурь бүтэц эзэмшигчийн** дохиолол, холбоо, эрчим хүч **хариуцсан нэгж** гүйцэтгэнэ.

4.45. Зүтгүүр, вагон, замын болон бусад аж ахуйн нэгжийн замын суман шилжүүлэг ба сум заагчийг, цэвэрлэж арчлах, гэрэлтүүлэх, бүрэн бүтэн байлгахыг тухайн аж ахуйн нэгж хариуцна.

ТӨМӨР ЗАМЫН ОГТЛОЛЦОЛ, ГАРАМ, БЭЛЧИР

4.46. Төмөр замтай, автомашины зам нэгэн түвшинд огтлолцох, хиймэл төхөөрөмжийн доогуур гарах газрыг тогтоосон стандартад нийцүүлэн “Гарам ашиглах журам”-ын дагуу тогтооно.

а. Төмөр замтай нэг түвшинд огтлолцсон гармаар трамвай болон троллейбусны хөдөлгөөн нээхийг хориглоно.

б. Төмөр замтай нэг түвшинд огтлолцсон гармаар хотын нийтийн тээврийн том оврын зорчигийн автобусны шинэ шугам нээхдээ суурь бүтэц эзэмшигчтэй зөвшилцөнө.

в. “Онцгой шаардлагатай үед суман шилжүүлэг, өртөөний замуудтай хэсэгт тухайн хөрсний судалгаа болон огтлолцлын гүнийг тодорхойлж, шаардлага хангасан нөхцөлд суурь бүтэц эзэмшигчийн техникийн нөхцөлийн дагуу Төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр шийдвэрлэнэ”

4.47. Галт тэрэг болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хэмжээ, хурд, дохиоллын хэрэгслээр тоногдсон байдал, үзэгдэлтийн нөхцөлөөс шалтгаалж гарам зохицуулалттай ба зохицуулалтгүй байж болно. Гармыг зэрэглэлээс нь хамааруулан дохиоллын байгууламж, холбооны хэрэгслээр тоноглох, гэрэлтүүлэх, хаалтуудын хэвийн байдлыг тогтоох, арчлах, үйлчлэх асуудлыг Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар тогтооно.

4.48. Овор ихтэй ба хүнд жинтэй тээврийн хэрэгсэл, өөрөө явагч болон гинжит машин, механизмыг гармаар гаргахдаа тухайн замын засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжийн даргын зөвшөөрснөөр замын мастер буюу замын бригадын даргын хяналтын дор гүйцэтгэнэ.

4.49. Гармын жижүүр гарам дээр галт тэрэг болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, гармын хаалтыг цаг тухайд нь нээж, хааж, тогтоосон дохио өгч, өнгөрч байгаа галт тэрэгний байдлыг хянаж байна.

4.50. Хөдөлгөөний аюулгүй байдалд хөнөөл учруулж болох гэмтэл илрүүлвэл гармын жижүүр галт тэргийг зогсоох арга хэмжээ авах бөгөөд харин галт тэрэгний сүүлчийн дохио байхгүй байвал энэ тухай өртөөний жижүүрт буюу замын засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжийн диспетчерт илтгэх үүрэгтэй.

4.51. Цахилгаан болон холбооны шугам, нефть, хий, ус дамжуулах хоолой, бусад газар дээрх ба доорх байгууламжийг төмөр замтай огтлолцуулахыг төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр гүйцэтгэнэ.

4.52. Шинээр барьж байгаа шугам, салбар замыг өртөө хоорондын гол замд холбохыг хориглоно. Онцгой шаардлагатай үед суман шилжүүлэг, өртөөний замуудтай хэсэгт тухайн хөрсний судалгаа болон огтлолцлын гүнийг тодорхойлж, шаардлага хангасан нөхцөлд суурь бүтэц эзэмшигчийн техникийн нөхцөлийн дагуу Төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр шийдвэрлэнэ.

ЗАМЫН БА ДОХИОНЫ ТЭМДЭГ

4.53. Гол замын хажууд замын ба дохионы тэмдэг тавина. Суман шилжүүлэг болон замын холбогдох бусад газарт хязгаарын шон тавина. Төмөр замын зурвас газрын заагийг заах, ул шорооны далд (ил) төхөөрөмжийг газрын гадаргуу дээр тэмдэглэж тусгай тэмдэг тавина.

4.54. Дохионы тэмдэгт дараах тэмдэг хамаарна:

- а.** Мэдэгдэх самбар
- б.** Шүгэл дуугаргах тухай машинчид анхааруулах тэмдэг «Ш»
- в.** Зүтгүүрийг зорчигчийн тавцан, зорчигч буух, суух газрын дэргэд зогсоох тэмдэг
- г.** Осолтой газрын эхлэл ба төгсгөлийн тэмдэг
- д.** Цас цэвэрлэх машины далавч ба хусуурыг эвхэх, тэнийлгэх
- е.** Бялт тавих газрыг заагч
- ё.** Автомат хориглолын үед сунгуу өгсүүр газар улаан дохиог өнгөрч болох газрыг заагч тэмдэг «Д»
- ж.** Хоорондын замд галт тэрэгний тоормосны найдвартай ажиллагааг шалгах газрын тэмдэг «Т1, Т2, Т3»
- з.** Радио хориглолын бүсийн эхлэл, төгсгөл
- и.** Радио хориглол залгах
- к.** Удирдлагын төвтэй холбогдох хил

4.55. Замын тэмдэг:

- а. Километр ба зуутын тэмдэг
- б. Тахирын эхлэл, төгсгөлийн тэмдэг
- в. Хэвгий заагч
- г. Замын засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгж, хэсгийн заагийн тэмдэг

4.56. Дохионы тэмдгийг хөдөлгөөний чиглэлийн баруун гар талд, замын тэмдгийг километрийг тоолж эхэлсэн чиглэлийн дагуу баруун гар талд захын замын тэнхлэгээс 3100 мм-ээс доошгүй зайд тавина.

4.57. Сэтэрхийд (хадархагаас бусад) болон тэндээс гарах газарт (100м уртад) замын тэмдгийг захын замын тэнхлэгээс 5700 мм-ээс доошгүй зайд тавина. Хязгаарын шонг нийлж байгаа замуудын тэнхлэгийн хоорондын зай 4100 мм байх газарт, хоёр замын **тэнхлэгийн голд** тавина.

4.58. Ачаа шилжүүлэн ачихад зориулан хооронд нь ойрхон тавьсан хоёр замын тэнхлэгүүдийн хоорондын зай 3600 мм байх тэр газарт хязгаарын шонг тавина. Замын тахир хэсэгт дээрх зайг барилга байгууламжийн ойртох хязгаар тогтоосон стандартыг баримтлан ихэсгэсэн байна. Дохионы ба замын тэмдэг, заагч батлагдсан стандарт хэмжээтэй байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

ЗҮТГҮҮР БА ВАГОНЫ АЖ АХУЙ, СЭРГЭЭН БОСГОХ ХЭРЭГСЭЛ

5.1. Зүтгүүрийн депо, техник үйлчилгээний газар, зэхэлтийн болон зүтгүүрийн аж ахуйн бусад байгууламжийн байршил, тэдгээрт суурилагдсан тоног төхөөрөмж, **багаж хэрэгсэл** нь галт тэрэгний хөдөлгөөний **зурмагаар** тогтоосон хэмжээг хангах, зүтгүүр ба түүний сэлбэг, материалыг оновчтой ашиглах, техникийн үйлчилгээ, засварын ажлыг чанартай гүйцэтгэх, хөдөлмөрийн аюулгүй **байдал, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагад нийцсэн** байна.

5.2. Вагон депо, вагоныг **ачилтад** бэлтгэх, **техник үйлчигээний** газар, вагоны аж ахуйн бусад байгууламжийн байршил, тэдгээрт суурилагдсан тоног төхөөрөмж, **багаж хэрэгсэл** нь галт тэрэгний хөдөлгөөний **зурмагаар** тогтоосон хэмжээг хангах, вагоны сэлбэг, материалыг зөв зохистой ашиглах, техникийн үйлчилгээ, засварыг чанартай гүйцэтгэх, хөдөлмөрийн аюулгүй **байдал, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагад нийцсэн** байна.

5.3. Суурь бүтэц эзэмшигч нь байгалийн гамшиг, гал түймэр, осол, сүйрэл, гологдлын хор уршгийг арилгах зориулалтын техник хэрэгсэл бүхий сэргээн босгох болон гал унтраах галт тэрэгтэй байна. **Дээрх галт тэрэггүй суурь бүтэц эзэмшигч нь мэргэжлийн байгууллагаас гэрээгээр ашиглана.** Суурь бүтэц эзэмшигчийн тогтоосон газарт сэргээн босгох болон галын галт тэрэг, доор дурдсан техник хэрэгсэл, мэргэжлийн ажилтнуудаар зохион байгуулсан багийг байнгын бэлэн байдалд байлгана.

а. Сэргээн босгох галт тэрэг, зам сэргээхэд зориулагдсан автомашин, хүнд даацын кран, холбооны шугам түргэн сэргээх баг, автодрезин, бусад техник хэрэгсэл, хээрийн ослын баг.

б. Гал түймрээс урьдчилан сэргийлэх ба түүнийг унтраахад зориулагдсан галын галт тэрэг, галын автомашин, бусад техник хэрэгсэл, гал сөнөөгчийн баг.

5.4. Сэргээн босгох, галын галт тэрэг зогсоох замыг өөр хөдлөх бүрэлдэхүүнээр эзлүүлэхийг хориглоно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ӨРТӨӨНИЙ АЖ АХУЙН БАЙГУУЛАМЖ, ТӨХӨӨРӨМЖ

6.1. Өртөөний замын хөгжилт ба техник тоноглол нь галт тэрэгний хөдөлгөөний зурмагаар тогтоосон хэмжээ, галт тэрэг хүлээн авах, явуулах, ачаа, ачаан тээш ачих, буулгах, хөдлөх бүрэлдэхүүн боловсруулах ажиллагааны нормын биелэлт, техник хэрэгсэл, хөдлөх бүрэлдэхүүнийг өндөр бүтээмжтэй ашиглах, хөдөлгөөний ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна.

6.2. Төмөр замын буудал, тавцан, тасалбар худалдаалах болон бусад үйлчилгээний газар, байгууламж нь зорчигчдын аюулгүй байдлыг ханган зорчигчдод түргэн шуурхай, тохилог, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг хангасан байна. Шаардлагатай газарт зорчигчийн тавцан руу нэвтрэхэд зориулагдсан нүхэн гарц, явган хүний зам, гүүртэй байна. Чиг заах ба анхааруулах тэмдэг тавьж болно.

6.3. Томоохон өртөөд нь зорчигчийн ба хот дүүргийн галт тэрэгний явах цагийн хуваарь, лавлах төхөөрөмж, автомат хадгаламжтай байна. Хоорондын зам дахь зорчигч буух, суух газар нь саравч, сүүдрэвч бүхий тавцантай байна. Тасалбар худалдаалах газартай байж болно.

6.4. Өртөөний жижүүрийн ажлын байранд жижүүрийн ажилд шууд холбоотой автоматжуулсан ажлын байрны төхөөрөмж, удирдлага, хяналт, холбоо мэдээллийн хэрэгсэл, ерөнхий тэжээлийн салгуур бүхий төвлөрүүлсэн удирдлагын самбар байрлуулна.

Дээр дурдсанаас бусад шаардлагатай тоноглол, аппарат, хэрэгсэл байрлуулахыг хөдөлгөөн хариуцсан салбарын даргын зөвшөөрлөөр гүйцэтгэж болно.

6.5. Ачааны, зорчигчийн өндөр тавцан нь зам төмрийн толгойн дээд түвшингээс 1100 мм өндөр бөгөөд замын тэнхлэгээс 1920 мм-ийн зайд байна. Ачааны, зорчигчийн нам тавцангийн өндөр зам төмрийн толгойн түвшингээс 200 мм байх бөгөөд зам төмрийн тэнхлэгээс 1745 мм зайд байна.

6.6. Тавцангийн өндөр нь ашиглалтын үед дээр заагдсан хэмжээнээс ихсэх тал руугаа 20 мм, багасах тал руугаа 50 мм-ийн хүлцэлтэйгээр, замын тэнхлэгээс заагдсан хэмжээнээс ихсэх тал руугаа 30 мм, багасах тал руугаа 25 мм-ийн хүлцэлтэй байж болно.

6.7. Өртөө, хоорондын замд шинээр ба шинэчлэн засварлах өндөр тавцан нь зам засварын ажил, тавцан цэвэрлэх ажлыг механикжуулах, өртөөнд бол хөдлөх бүрэлдэхүүний явах ангид үзлэг хийх боломжийг хангасан хийцтэй байна.

6.8. Сум дохионы удирдлагын байрны байршил удирдаж буй сум, дохио нь сайн харагдаж байх нөхцөлийг хангана.

6.9. Өртөөний төвлөрүүлэлтийн ба сумчны байр суурь бүтэц эзэмшигчээс тогтоосон нормын дагуу шаардагдах дохионы хэрэгсэл, эд хогшил, багаж, материалтай байна.

6.10. Ялгах дов нь гэрлэн дохионы дохиолол, радио холбоогоор болон зүтгүүрийн машинч, найруулагчийн бригад бусад ажилтанд үүрэг даалгавар өгөх, харилцан ярилцахад зориулагдсан паркийн хоёр талын чанга яригчийн холбооны хэрэгслээр тоноглогдсон байна. Сумчны ба ивүүрчний байр нь гадна талын дуудлагын хэрэгслээр тоноглогдсон байна.

6.11. Ажлын ачаалал их хэсгийн ба ачааны өртөөнд галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний талаар үүрэг даалгавар, захирамж дамжуулах, сэлгээний зохицуулагч, өртөөний жижүүр, галт тэрэгний найруулагч, сэлгээний зүтгүүрийн машинч нар өөр хоорондоо болон техникийн контор, техник үйлчилгээний газар, ачаа тээврийн үзлэгийн газар, чингэлэгийн талбай, ачих буулгах газрын ажилтан нартай харилцан ярилцахад зориулагдсан радио холбоо, паркийн хоёр талын чанга яригч, бусад холбооны хэрэгслээр тоноглогдсон байна.

6.12. Хэсгийн, ачааны өртөө нь галт тэрэг, ачааны талаар шаардагдах мэдээг хүлээн авах, дамжуулахад зориулагдсан мэдээллийн тусгай холбоогоор, ачих буулгах анги, терминал, талбай нь зохицуулагчийн дотоод холбоо болон ачаа илгээгч, хүлээн авагчид мэдээлэл хүргэх холбооны хэрэгслээр тоноглогдоно.

6.13. Ачаа, тээврийн үзлэгийн газар, ачих буулгах, шилжүүлэн ачих ангийн зохицуулагч, ажилтан ачаа тээврийн үзлэг хийх болон ачилт буулгалтын ажлыг шуурхай зохион байгуулах, хяналт тавих зорилгоор радио холбоотой байна.

6.14. Өртөөнд зорчигчдод үйлчлэхэд зориулагдсан төхөөрөмж, галт тэрэг хүлээн авах, явуулах, ачилт буулгалтын ба сэлгээний ажил хийх, хөдлөх бүрэлдэхүүн зэхэх, вагон пүү, техникийн үйлчилгээ засвар хийх, зам, парк, өртөөний жижүүрээс галт тэрэг угтах газар, суман шилжүүлэг бэлчир, агуулах, гарам, шаардлагатай үед бусад зам болон газруудыг гэрэлтүүлсэн байна.

6.15. Гэрэлтүүлэг нь галт тэрэг, болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдал, зорчигч вагонд суух, вагоноос буух үеийн аюулгүй байдал, үйлчлэгч ажилтны тасралтгүй бөгөөд аюулгүй ажиллах, ачааг хамгаалах явдлыг хангасан байна.

6.16. Ачааны ажил багатай завсарын өртөөнд ачих буулгах, өртөөний бусад зам дээр ачааны ба сэлгээний ажил хийгээгүй үед тэдгээрийн гадна талын гэрэлтүүлгийг хэсэгчлэн унтрааж байх хэрэгсэлтэй байна.

6.17. Гадна талын гэрэлтүүлэг нь дохионы гэрлийн тод үзэгдэх явдалд нөлөөлөхөөргүй байна.

6.18. Ачаа, чингэлэг ачих буулгах, шилжүүлэн ачих анги /терминал/ вагон жин, ачилт буулгалтын зам, талбай, оврын хаалга, галт тэрэг, вагонд ачаа тээврийн зөрчил илрүүлэх автомат төхөөрөмж нь гэрэлтүүлэгтэй байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ДОХИОЛОЛ ХОЛБООНЫ БАЙГУУЛАМЖ, ТӨХӨӨРӨМЖ

Дохио

7.1. Дохио бол хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, галт тэрэгний хөдөлгөөн, сэлгээний ажлыг тодорхой зохион байгуулахад зориулагдана.

7.2. Дохио бол үг дуугүй биелүүлбэл зохих тушаал мөн. Төмөр замын тээврийн ажилтан дохионы шаардлагыг биелүүлэхийн тулд бололцоотой бүх арга хэрэгслийг ашиглаж байх ёстой. Хориглосон заалттай гэрлэн дохио ба семафорыг өнгөрч хэрхэвч үл болно. **Мөн автомат хориглолын үед зүтгүүрийн удирдлага, хяналтын дэлгэц дээрх хориглосон тушаалыг зөрчиж үл болно.** Гэрлэн дохио (анхааруулах, хаах, давтахаас бусад) ба семафорын гэрэл унтарсан, тэдний заалт буруу, ойлгогдохгүй байх, дохионы бусад хэрэгслээр ойлгогдохгүй дохио өгөгдвөл зогсохыг шаардана.

7.3. Онцгойлон заасан нөхцөлд хориглосон заалттай (ойлгогдохгүй заалттай буюу гэрэлгүй) гэрлэн дохио, семафорыг энэхүү дүрэм болон “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”-д тогтоосноор өнгөрч болно.

7.4. Галт тэрэгний ба сэлгээний хөдөлгөөнд дохионы дараах үндсэн өнгийг хэрэглэнэ.

- а.** Тогтоосон хурдтай явахыг зөвшөөрсөн ногоон өнгө
- б.** Явахыг зөвшөөрсөн боловч хурд бууруулахыг шаардсан шар өнгө
- в.** Зогсохыг шаардсан улаан өнгө
- г.** Сэлгээний хөдөлгөөн зөвшөөрсөн цагаан өнгө
- д.** Сэлгээний хөдөлгөөн хориглосон хөх өнгө

7.5. Дохионы өнгийг хэрхэн хэрэглэх, дохионы заалтыг өнгөрөх хурдыг “Төмөр замын дохиоллын журам”, “Галт тэрэгний **хөдөлгөөний** удирдлагын журам”-аар тогтооно.

7.6. Дохиог зөв ойлгож хүлээн авахад саад учруулах улаан, шар, ногоон өнгийн гэрэл, чимэглэл, зурагт хуудас хэрэглэх, үзэгдэх орчинд байрлуулахыг хориглоно.

7.7. Төмөр замын тээвэрт “Төмөр замын дохиоллын журам”-д заасан дохио ба дохионы хэрэгслийг хэрэглэх бөгөөд дохионы линз, гэрэл ойлгогчийн өнгө нь тогтоосон стандарт, Төрийн захиргааны **ТӨВ** байгууллагаас баталсан хэв загварт

тохирсон байна. Замын автомат болон хагас автомат хориглолоор тоноглогдсон шугамд хэсэглэх газрыг шинээр барих ба цахилгаан төвлөрүүлэлт нэвтрүүлэх үед дохионд гэрлэн дохио хэрэглэнэ. Цахилгаан очрын хэрэгсэлтэй хэсэгт тэдгээрийг бүрэн сольж дуусах хүртэл семафорыг хэрэглэнэ.

7.8. Өртөө хоорондын хориглолоор тоноглогдсон шугамд хэсэглэх газрыг шинээр барих ба цахилгаан төвлөрүүлэлт нэвтрүүлэх үед дохионд гэрлэн дохио болон зүтгүүрийн дохио, зүтгүүрийн удирдлага, хяналтын дэлгэц дээрх тушаалыг хэрэглэнэ.

7.9. Оруулах, хаах халхлах, өнгөрүүлэх, анхааруулах гэрлэн дохионы улаан, шар, ногоон гэрэл, оруулах семафорын заалт нь замын шулуун хэсэгт өдөр, шөнийн ямар ч цагт 1000 метрээс доошгүй зайд ойртон ирж байгаа галт тэрэгний зүтгүүрийн жолоодлогын бүхээгнээс тод ялгагдан харагдаж байх ёстой.

7.10. Тахир хэсэгт эдгээр дохио ба анхааруулах гэрлэн дохио 400 метрээс доошгүй зайд тод ялгагдахуйц байна. Харин нугачаа бартаа ихтэй (уул, гүнзгий сэтэрхий) газарт байгаа дээрх гэрлэн дохионы заалт нь 400 метрээс ойр боловч 200 метрээс багагүй зайд **харагдаж байх ёстой.**

7.11. Анхааруулах зээрэнхийгүй оруулах семафорын заалт өдөр, шөнийн цагт тухайн хэсэгт тогтоосон дээд зэргийн хурдтай галт тэрэг албаны бүрэн тоормос хийж зогсохоор тооцоолсон тоормосны замаас багагүй боловч 1000 метрээс доошгүй зайд галт тэрэгний зүтгүүрийн бүхээгээс тод ялгагдаж **байх ёстой.**

7.12. Гол замын гаргах ба замналын гэрлэн дохионы заалт өдөр, шөнийн цагт 400 метрээс доошгүй зайд, хажуугийн замын гаргах ба замналын гэрлэн дохио, урих дохио, сэлгээний гэрлэн дохионы заалт 200 метрээс доошгүй зайд ялгагдаж байх ёстой.

7.13. Бүх оруулах гэрлэн дохионы өмнө анхааруулах гэрлэн дохио тавина. Хэрэв галт тэрэг дээд зэргийн хурдтай явж, албаны бүрэн тоормослолт хийх үед тухайн хэсэгт тооцоолсон тоормосны замын зайд буюу 1000 метрээс доошгүй зайд үндсэн семафор үзэгдэхгүй нөхцөлд оруулах семафорын өмнө анхааруулах зээрэнхийг тавина.

7.14. Анхааруулах гэрлэн дохиог тухайн хэсэгт тогтоосон дээд хурдтай явах галт тэрэг, яаралтай тоормос хийж зогсох тооцоолсон тоормосны замын зайд байрлуулах боловч үндсэн гэрлэн дохио ба семафороос 1000 метрээс доошгүй зайд тавина.

7.15. Ойртох хэсэг зүтгүүрийн автомат дохиоллын замын байгууламжаар тоноглогдсон бол дээд хурдтай галт тэрэгний зүтгүүрийн автомат дохиолол тоормосны системээ ажиллуулах хугацаанд туулсан замыг тооцсон яаралтай тоормос хийх үеийн тоормосны замын уртаас багагүй зайд анхааруулах гэрлэн дохиог байрлуулна.

7.16. Зүтгүүрийн автомат дохиоллыг бие даасан дохиолол холбооны хэрэгсэл болгон ашиглаж байгаа хэсэгт дараалсан хоёр блок-хэсгийн урт нь дээд

хурдтай галт тэрэгний зүтгүүрийн автомат дохиолол тоормосны системээ ажиллуулах хугацаанд туулах замыг тооцсон яаралтай тоормос хийх үеийн тоормосны замын уртаас багагүй байна.

7.17. Радио галт тэрэгний удирдлага, хяналтын дэлгэцийн мэдээллийн дагуу галт тэрэгний тооцсон яаралтай тоормосын замыг суурь бүтэц эзэмшигч баталсан зааврын дагуу тогтооно.

7.18. Анхааруулах зээрэнхий байхгүй оруулах семафорын өмнө мэдэгдэх самбар тавина.

7.19. Гэрлэн дохио, семафорыг галт тэрэгний хөдөлгөөний чиглэлийн баруун гар талд эсвэл тэдгээрээр хаагдаж байгаа замын тэнхлэгийн дээд талд байрлуулна. Гэрлэн дохио, семафорын дохио галт тэргэнд зэргэлдээх замд хамаарах дохио болж харагдахааргүйгээр байрлуулна.

7.20. Гэрлэн дохио, семафор гэмтсэн үед өөрөө хориглосон байдалд шилжих бөгөөд анхааруулах гэрлэн дохио нь тэдэнтэй холбогдсон үндсэн гэрлэн дохио, семафорын хориглосон заалтад тохирсон байдалтай болох ёстой.

7.21. Автомат хориглолоор тоноглогдоогүй хэсэгт оруулах, гаргах, замналын гэрлэн дохио, семафорын хэвийн заалт бол хориглосон заалт юм.

7.22. Оруулах гэрлэн дохио, семафорыг сөргүү **суман шилжүүлэг шороос** буюу дагуу суман шилжүүлгийн хязгаарын шонгоос **тооцож** эхний оруулах **суман** шилжүүлгээс 50 метрээс дотогшгүй зайд байрлуулсан байна. 50 метрээс доош боловч сумны шилжүүлгээс 15 метрээс дотогшгүй зайд тавигдсан оруулах гэрлэн дохио, семафорыг шилжүүлж тавихгүй байж болно.

7.23. Гаргах дохиог галт тэрэг явуулах зам тус бүрт тухайн замаас явах галт тэрэгний зүтгүүр зогсох газрын өмнө байрлуулна. Галт тэрэг зогсохгүй өнгөрүүлэх замаас бусад бүлэг замд нэгтгэсэн гэрлэн дохиог тавьж болно. Гаргах, замналын бүлэг гэрлэн дохионд галт тэрэг явуулахыг зөвшөөрсөн замын дугаарыг заасан замнал заагч тавина.

7.24. Өртөө, зөрлөгт галт тэрэг хүлээн авах, явуулах замналд орсон сумууд оруулах, гаргах, замналын дохиотой харилцан хамааралтай байна.

7.25. Хоорондын замаас салаалсан сум нь гол замаар тавигдсан хэвийн байдалдаа автомат хориглолтой үед хамгийн ойрын өнгөрүүлэх дохиог нээх, хагас автомат хориглол буюу цахилгаан очрын системээр тоноглогдсон бол хамгийн ойр орших гаргах дохио нээх, очрыг сугалж авах боломжтой байхаар дээрх хориглолын байгууламжтай холбогдсон байна.

7.26. Хагас автомат хориглолтой өртөө, зөрлөгт галт тэрэг гол ба хүлээн авах, замаар зогсолтгүй өнгөрүүлэх өртөөнд оруулах ба замналын гэрлэн дохионд зогсолтгүй өнгөрүүлэх дохиоллын заалттай байна.

7.27. Байнгын дохио байрлуулах бүдүүвч, өртөөнд сум, дохио, замналын харилцан хамаарлын хүснэгтийг суурь бүтэц эзэмшигч батална. Байнгын дохио тавих газрыг суурь бүтэц эзэмшигчээс томилсон комисс тодорхойлно.

ЗАМЫН АВТОМАТ БА ХАГАС АВТОМАТ ХОРИГЛОЛ

7.28. Хагас автомат хориглолын байгууламж нь тэдгээрээр хязгаарлагдсан өртөө хоорондын ба пост хоорондын замыг чөлөөлөгдөх хүртэл гаргах буюу өнгөрүүлэх гэрлэн дохиог нээх боломж өгөхгүй, үндсэн цахилгаан тэжээлээс нөөц тэжээлд, эсвэл буцаж шилжихэд гэрлэн дохионы заалт өөрчлөгдөхгүй байна.

7.29. Замын хагас автомат хориглолоор тоноглогдсон нэг замтай хоорондын замд өртөөний гаргах дохиог нээсний дараа зэргэлдээ өртөөнөөс уул хоорондын замд эсрэг чиглэлийн галт тэрэг явуулахаар гаргах дохиог нээх боломжгүй, галт тэрэг зэргэлдээ өртөөнд очоогүй байхад тэр чиглэлд дахин гаргах дохио нээх боломжгүй байна.

7.30. Зам бүр нь хоёр чиглэлийн хөдөлгөөнтэй хагас автомат хориглолоор тоноглогдсон хоёр замтай хоорондын замд дохио нь дээрхийн адил харилцан хамааралтай байна.

7.31. Хагас автомат хориглолоор тоноглогдсон үед өртөөний хориглолын байгууламж нь доорх нөхцөлийг бүрдүүлсэн байж болно.

а. Хэрвээ галт тэрэг бодитоор гаргах дохиог өнгөрөөгүй үед хаасан болон тэр чиглэлд явах бусад галт тэргэнд гаргах гэрлэн дохиог дахин нээх

б. Гаргах гэрлэн дохио нээсэн боловч тухайн галт тэрэг хоорондын замыг эзлээгүй тохиолдолд эсрэг чиглэлийн галт тэргийг явуулахдаа нээсэн гаргах дохиог хааж, хоорондын замыг чөлөөлөн, эсрэг чиглэлд гаргах гэрлэн дохионы зөвшөөрсөн заалтаар хагас автомат хориглолын системээр явуулна.

7.32. Замын хагас **автомат**, **хагас** автомат хориглолоор тоноглогдсон хэсэгт байрлагдсан өртөөнд эдгээр байгууламж нь аж ахуйн галт тэргэнд зориулагдсан түлхүүр-очиртой, харин галт тэрэг түлхэж, түлхэгч зүтгүүр нь хоорондын замаас буцаж ирдэг өртөөнд түлхэгч зүтгүүрт зориулсан түлхүүр-очиртой байна.

Хагас автомат хориглолоор тоноглогдсон өртөөдийн хооронд нөөц шугам, сувагтай байна.

7.33. Автомат хориглолоор тоноглогдсон хэсэгт өнгөрүүлэх гэрлэн дохионы хэвийн заалт нь зөвшөөрсөн, замналын ба гаргах гэрлэн дохио хориглосон заалттай байна.

7.34. Зүтгүүрийн автомат дохиоллыг бие даасан дохиолол холбооны хэрэгсэл болгон ашиглаж байгаа хоорондын замд хоёр чиглэлдээ зүтгүүрийн гэрлэн дохионы заалтаар явж болно.

ӨРТӨӨ ХООРОНДЫН ХОРИГЛОЛ

7.35. Өртөө хоорондын хориглолын байгууламж нь радио галт тэрэг явуулж байгаа өртөөний холдох хэсгийг чөлөөлөгдөх хүртэл гаргах гэрлэн дохиог нээх боломж, машинчийн удирдлага хяналтын дэлгэцэнд мэдээлэл өгөгдөхгүй байна. Зүтгүүрийн аюулгүй байдлын систем тоноглогдоогүй галт тэргэнд хоорондын зам чөлөөлөгдөх хүртэл гаргах гэрлэн дохиог нээх боломжгүй байна.

7.36. Өртөө хоорондын хориглолоор тоноглогдсон нэг замтай хоорондын замд өртөөний гаргах дохиог нээсний дараа зэргэлдээ өртөөнөөс уул хоорондын замд эсрэг чиглэлийн галт тэрэг явуулахаар гаргах дохиог нээх боломжгүй, галт тэрэг зэргэлдээ өртөөнд очоогүй байхад тэр чиглэлд дахин гаргах дохио нээх боломжгүй байна.

7.37. Өртөө хоорондын хориглолоор тоноглогдсон хэсэгт байрлагдсан өртөөнд эдгээр байгууламж нь аж ахуйн галт тэргэнд зориулагдсан түлхүүр-очиртой, харин галт тэрэг түлхэж, түлхэгч зүтгүүр нь хоорондын замаас буцаж ирдэг өртөөнд түлхэгч зүтгүүрт зориулсан түлхүүр-очиртой байна. Өртөө хоорондын хориглолоор тоноглогдсон өртөөдийн хооронд нөөц шугам, сувагтай байна.

7.38. Радио галт тэрэгний удирдлага, хяналтын дэлгэцийн мэдээллийн дагуу өртөө хоорондын хориглолоор хоорондын зам эзлэх, чөлөөлөхийг суурь бүтэц эзэмшигч баталсан зааврын дагуу тогтооно.

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАГЧИЙН ТӨВЛӨРҮҮЛЭЛТ

7.39. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн төвлөрүүлэлтийн байгууламж дараах үүргийг гүйцэтгэнэ.

а. Хэд хэдэн өртөө, зөрлөг ба хоорондын замын дохиолол төвлөрүүлэлт хориглолын байгууламж /цахилгаан төвлөрүүлэлтийн сум дохио, автомат хориглолын байгууламж, холбоо дохиоллын бие даасан хэрэгсэл болгон ашиглаж буй зүтгүүрийн автомат дохиолол, зүтгүүрийн удирдлага, хяналтын дэлгэц дээрх тушаал, галт тэрэг бүрэн бүрэлдэхүүнтэй ирснийг автоматаар хянах төхөөрөмж бүхий хоорондын замын хориглол/-ийг нэг газраас удирдах

б. Удирдлагын аппарат дээр суман шилжүүлэг байрлал ба хоорондын зам, блок-хэсэг өртөөний зам, суман шилжүүлэг тусгаарлагдсан хэсгийн эзэлгээтэй эсэхийг хянах, мөн оруулах, гаргах, замналын дохионы заалтыг давтах

в. Хоорондын зам, блок-хэсэг ба өртөөний зам суман шилжүүлэг эзэлгээтэй болон чөлөөтэй байдал, суман шилжүүлэг байдал, гэрлэн дохионы заалтын давтах заалтыг удирдлагын аппарат дээр хянах

г. Галт тэрэг хүлээн авах явуулах сэлгээний ажил гүйцэтгэх үед өртөөг нөөц удирдлагад, сумыг орон нутгийн удирдлагад тус тус шилжүүлэх, буцаан төвлөрүүлэх

д. Галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагийг автоматаар бичих, зохих мэдээллийг галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын автомат системд дамжуулах

е. Блок хэсэг хуурамчаар эзлэгдсэн үед галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч хөдөлгөөний чиглэлийг өөрчлөх боломжтой байх

ё. Галт тэрэг бүрэн бүрэлдэхүүнтэй ирснийг автоматаар хянах төхөөрөмж гэмтэлтэй үед ирэлтийн мэдээ өгөх боломжтой байх

ж. Гармын дохиоллын байгууламжийн ажиллагааг хянах.

ЗҮТГҮҮРИЙН АВТОМАТ ДОХИОЛЛЫН ЗАМЫН БАЙГУУЛАМЖ

7.40. Зүтгүүрийн автомат дохиоллыг бие даасан дохиолол холбооны хэрэгсэл болгон ашиглаж байгаа автомат хориглолоор тоноглогдсон хэсэг дэх өртөөний гол зам, зорчигчийн галт тэрэг хүлээн авах, явуулах зам, зогсолтгүй өнгөрөөх замууд нь зүтгүүрийн автомат дохиоллын замын байгууламжаар тоноглогдсон байна.

7.41. Хагас автомат хориглолтой үед өртөөний ойртох хэсэг, гол зам зүтгүүрийн автомат дохиоллын замын байгууламжаар тоноглогдсон байна. Зарим өртөө, зөрлөгийг зөвхөн суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр зүтгүүрийн автомат дохиоллын замын байгууламжаар тоноглохгүй байж болно.

ЦАХИЛГААН ОЧРЫН СИСТЕМ

7.42. Цахилгаан очрын системийн байгууламж тухайн хоорондын замд хамаарагдах нэгээс илүү очрыг аппаратаас нэгэн зэрэг авч болохооргүй байлгана.

7.43. Ижил серитэй очрын аппаратыг гурваас доошгүй хоорондын зам алгасуулан тавина.

7.44. Зэргэлдээ өртөө хүртэл явдаг түлхэгч зүтгүүртэй галт тэрэгний хөдөлгөөн бүхий хоорондын замд зориулагдсан очрын аппарат нь салдаг очиртой байна.

7.45. Хоорондын замд гол замаас салаалсан суман шилжүүлэгтэй байвал уул гол замын сумыг түгжих Мелентьевын цоожны түлхүүрийг тухайн хоорондын замын аль нэгэн өртөөний түлхүүр-очирт найдвартай бэхлэнэ.

СУМ, ДОХИОНЫ ЦАХИЛГААН ТӨВЛӨРҮҮЛЭЛТ

7.46. Сум, дохионы цахилгаан төвлөрүүлэлт дараах боломжийг хангасан байна.

- Сум ба гэрлэн дохио харилцан түгжигдэх,
- Сум зүсэгдэнгүүт тухайн замналын дохио хаагдаж суман шилжүүлэг хяналт алдагдах,

- Удирдлагын аппарат дээр хүлээн авах, явуулах зам ба **суман шилжүүлэг** эзэлгээтэй болон суман шилжүүлэг байдлыг хянах,
- Сум, дохиог замналын дагууд нэг бүрчлэн удирдах, сэлгээний гэрлэн **дохионы** заалтаар сэлгээний ажлыг явуулах
- Сумыг орон нутгийн удирдлагад шилжүүлэх

7.47. Сум, дохионы цахилгаан төвлөрүүлэлт дараах үйлдэл хийх боломжийг олгохгүй байвал зохино.

- Эзэлгээтэй зам дээр бэлдсэн замналын оруулах гэрлэн дохиог нээх
- Хөдлөх бүрэлдэхүүн дор сум гуйвуулагдах
- Сум зохих байдалд замналын дагуу тавигдаагүй байхад дохио нээх
- Дайсагналтай замналын гэрлэн дохио хаагдаагүй байхад тухайн замналын дохио нээгдэх
- Тухайн замналын дохио нээлттэй байхад замналд орсон сумыг гуйвуулах, дайсагналтай замналын гэрлэн дохиог нээх

7.48. Төвлөрүүлэгдсэн **суман шилжүүлэг** шилжүүлэгч ба түгжигч нь:

- а.** Сум захын байрлалд шахагдсан шорыг жааз зам төмөрт нягт шахсан байх
- б.** Шахагдсан шор ба жааз зам төмрийн хооронд 4 мм ба түүнээс дээш зайтай байхад сум нь түгжигдэхгүй байх
- в.** Нөгөө шорыг жааз зам төмрөөс 125 мм-ээс багагүй зайд хөндийрүүлдэг байх

7.49. Сум, дохионы цахилгаан төвлөрүүлэлт бүхий өртөөнд нийлсэн хоорондын зам замын автомат ба хагас автомат хориглол, **цахилгаан очрын системээр** тоноглогдсон байна.

СУМ, ДОХИОНЫ ТҮЛХҮҮРИЙН ХАМААРАЛ

7.50. Түлхүүрийн хамааралтай байгууламж сум, дохионы хяналтын цоожны тусламжтай сум, дохиог харилцан түгждэг байна.

7.51. Суман шилжүүлэг хяналтын цоож нь:

- а.** Сум зөвхөн түгжээтэй байх үед түлхүүрийг сугалан авч болдог.
 - б.** Шорыг жааз зам төмөрт нягт шахуулсан нөхцөлд цоожноос авсан түлхүүр дээр заасан тэр байдалд сумыг түгждэг.
 - в.** Шахагдсан шор ба жааз төмрийн хооронд 4 мм ба түүнээс илүү завсартай үед сумыг түгжиж болдоггүй байх ёстой.
- Өртөөнд ижил **дугаартай /сери/** хяналтын цоож хэрэглэхийг хориглоно.

7.52. Дохионы хяналтын цоож нь семафор нээлттэй байхад түлхүүрийг сугалан авч болохгүй байх, семафорын татуурга тасрах үед түүний далавч хаалттай байдалд ордог байна.

ӨРТӨӨНИЙ ХОРИГЛОЛ

7.53. Өртөөний хориглол нь дараах шаардлагыг хангана.

а. Өртөөний жижүүр галт тэрэг хүлээн авах, явуулах, сэлгээний замнал суман шилжүүлэг удирдлагын байруудаар /постуудаар/ зөв бэлтгэгдсэнийг хянах.

б. Өөр өөр постоос удирдаж байгаа сум дохио харилцан түгжигдэх.

ГАРМЫН АВТОМАТ ДОХИОЛОЛ, АВТОМАТ ХААЛТ БА СӨХӨГДДӨГ СААД

7.54. Гармын автомат дохиолол нь галт тэрэг гарманд ойртож ирэхээс өмнө авто зам тал руу зогсоох дохио өгөх ба автомат хаалт нь гармаар өнгөрч байгаа тээврийн хэрэгсэл түүнийг бүрэн чөлөөлөх хугацаа өнгөрсний дараа хаагдаж эхэлдэг байна.

7.55. Галт тэрэг гүйцэд явж өнгөртөл гармын гэрлэн дохионы автомат дохиолол ажиллаж, автомат хаалт нь хаалттай хэвээр байна.

7.56. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчимжилт өндөртэй авто зам төмөр замтай нэг түвшинд огтлолцдог гарамд, автомат хаалтаас гадна автомат ажиллагаатай сөхөгддөг саадыг авто зам дээр нэмэлтээр байрлуулж болно.

7.57. Гармын автомат дохиолол нь зэргэлдээ өртөөнөөс галт тэргэнд гаргах дохио нээхэд автоматаар мэдээлдэг байна.

Ялгах довын төвлөрүүлэлт

7.58. Ялгах довын механикжсан төхөөрөмж нь хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган галт тэрэгний **бүрэлдэхүүнийг** тасралтгүй ялгах зориулалттай бөгөөд дохионы зөвшөөрсөн заалтаар вагоныг довоос тооцоот хурдтайгаар задлан тараах ажиллагааг гүйцэтгэнэ.

7.59. Механикжсан ялгах дов дээр **бүрэлдэхүүнийг** буулгаж задлан тараах, ялгалтын замуудад бүлэг вагоныг хуваарилах зориулалттай суман шилжүүлгүүд нь довын цахилгаан буюу автомат **төвлөрүүлэлтэд** холбогдсон байна.

7.60. Довын төвлөрүүлэлт нь дараах нөхцөлийг хангасан байна.

а. Сумыг нэг бүрчлэн удирдах

б. Хөдлөх бүрэлдэхүүнийг буулган тараахад бүх сөргүү сум цахилгаанаар түгжигдсэн байх.

в. Удирдах пультэнд суман шилжүүлэг хяналт ба суман шилжүүлэг хэсгийн эзэлгээтэйг хянах боломжийг хангаж байх.

г. Хөдлөх бүрэлдэхүүн дор сум гуйвуулагдах боломжгүй байх.

д. Довын ажил замналын болон програмын дэглэмд явагдаж бүлэг вагоныг өнхрүүлж байх үед ялгах довын хуваарилах бүсийн сумууд автоматаар удирдагдаж байх

е. Сум эргүүлэх үед суман шилжүүлэг хаших зам төмөр, шорын хооронд юм орж саад үүсэх үед суман шилжүүлэг тусгаарлагч секц рүү бүлэг вагон гишгэхээс өмнө сум нь хяналттай талдаа автоматаар буцаж байх

ё. Довоос вагон буулгах явц сумыг ганцаарчилсан удирдлагад шилжүүлэх боломжтой байх

7.61. Автоматжуулсан ялгах довын байгууламж төхөөрөмж нь механикжуулсан довд /довын автоматжуулсан төвлөрүүлэгтэй/ тавигдах шаардлагаас гадна дор дурдсан нөхцөлийг хангаж байвал зохино.

а. Бүрэлдэхүүнийг довоос буулгах, дов руу түрэх үйл явцыг хянах, удирдах

б. Буулгаж буй вагоны хурдыг автоматаар тохируулах

в. Бүрэлдэхүүнийг довоос тарааж буулгасан үр дүнг хянах боломжтой байх

г. Ялгах өртөөний мэдээлэл-төлөвлөлтийн системтэй мэдээлэл солилцох боломжтой байх

ХОЛБОО

7.62. Төмөр замын бүх хэсэгт галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн, өртөө хоорондын, шугам замын, сумчны ба галт тэрэгний радио холбоотой байна.

7.63. Төмөр замын хэмжээнд галт тэрэгний хөдөлгөөн ба шугам замын, аж ахуйн нэгжийн ажлыг удирдахад зориулагдсан гол замын суурин болон бусад төрлийн утсан ба радио холбоо байна.

7.64. Оптик шилэн кабелийн сүлжээ нь төмөр замын холбооны үндсэн шугам мөн. Уг сүлжээнд холболт хийхийг зөвхөн суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

7.65. Галт тэрэгний радио холбоо нь галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч ба зүтгүүрийн машинч, **өртөөний жижүүр ба зүтгүүрийн машинчийн хооронд** тасралтгүй ажиллах хоёр талын холбоо тогтоох зориулалттай. Галт тэрэгний радио холбоо нь галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тойргийн хязгаар дотор, хоорондын замд яваа зүтгүүрийн машинчдын хооронд, зэргэлдээ өртөөдийн жижүүр машинчдын хооронд холбоо барихад хэрэглэгдэнэ.

7.66. Сэлгээний радио холбоо нь сэлгээний зохицуулагч, өртөөний жижүүр, найруулагчийн бригад зүтгүүрийн машинчийн хооронд хоёр талын холбоог тасралтгүй найдвартай хангаж, өртөөний бүх дэвсгэрт буюу том өртөөнд сэлгээний районы хязгаарт ажиллана.

7.67. Паркийн хоёр талын ажиллагаатай радио холбоо паркийн хэмжээнд тод сонсогдож байх шаардлагыг хангасан байна.

7.68. Эдгээр байгууламж нь бусад байгууллагын ажилд шуугиан чимээний нөлөөгүй, чиглүүлэгдсэн үйлчилгээтэй байна.

7.69. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн ба сумчны холбоогоор галт тэрэгний хөдөлгөөнд холбогдолгүй асуудал ярилцахыг хориглоно. Сумчны холбооны сүлжээнд төвлөрүүлгийн гүйцэтгэх пост, сумчны байр, өртөөний жижүүрийн утаснаас бусад утас залгахыг хориглоно.

7.70. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбооны утсанд зөвхөн өртөөний жижүүр, сэлгээний зохицуулагч оператор, зүтгүүрийн депо, солилцох тасгийн жижүүр, зүтгүүрийн **ээлжийн зохицуулагч**, дохиолол холбооны байгууламжийн засвар үйлчилгээ хариуцсан салбар, аж ахуйн нэгжийн жижүүрийн инженерийн утсыг залгаж болно.

7.71. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн хоорондын зам дахь холбооны утсанд зүтгүүрийн машинч, автодрезины жолооч (галт тэргийг зайлшгүй зогсоход) сэргээн босгох, галын галт тэрэгний дарга, **дохиолол төвлөрүүлэлт хориглол** ба холбооны цахилгаан механикч, замын ажил удирдагчийн зөөврийн утсыг түр залгаж болно.

7.72. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн төвлөрүүлэлт, автомат хориглолоор тоноглогдсон, цахилгаанжсан төмөр замын хэсэгт эрчим хүчний **ээлжийн зохицуулагч** ба өртөө хоорондын холбоо байна.

7.73. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын ба сэлгээний ажлын албан ярианы сувгийг **албан яриа баримтжуулан бичих** төхөөрөмжөөр тоногдсон байна. **Албан яриа баримтжуулан бичих** төхөөрөмж ашиглах журмыг суурь бүтэц эзэмшигч батална.

Мөн сэлгээний хоёроос дээш зүтгүүр ашигладаг өртөөнд илчит тэрэгний радио станцын өөр өөр давтамжтай сувгуудыг хэрхэн ашиглахыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

7.74. Төмөр замын суурь сүлжээ эзэмшигчийн бүрэлдэхүүнд ордоггүй бусад харилцагч байгууллагад холбооны үйлчилгээ үзүүлэх журмыг суурь бүтэц эзэмшигч батална.

МЭДЭЭЛЛИЙН ПРОГРАМ ХАНГАМЖ, СҮЛЖЭЭ, ДҮРС БИЧЛЭГИЙН ТӨХӨӨРӨМЖ

7.75. Компьютер, мэдээллийн төхөөрөмж дараах шаардлагыг хангасан байна.

а. Өгөгдлийг оруулах, дамжуулах, боловсруулах, архивлаж хадгалах, нөөцлөх

б. Мэдээллийн үнэн зөв, найдвартай, шуурхай, тасралтгүй байдлыг хангах.

в. Төмөр замын **байгууллагын** статистик, бүртгэл, тайлан тооцоо, төлөвлөлт, шуурхай ажилтай холбоотой мэдээллийг боловсруулах.

г. Сүлжээний төхөөрөмж ба компьютерийн техник хэрэгслүүд байнгын найдвартай ажиллагааг хангаж байх.

7.76. Төмөр замын тооцоолон бодох, мэдээллийн сүлжээг мэдээллийн өөр сүлжээ, төхөөрөмжтэй холбох асуудлыг суурь бүтэц эзэмшигч Төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн шийдвэрлэнэ.

Дүрс бичлэгийн төхөөрөмжөөр:

- Зүтгүүр
- Өртөөний зам суман шилжүүлэг бэлчир
- Зохицуулалттай төмөр замын гарам
- Зорчигчийн буух, суух тавцан тус тус тоноглогдсон байна.

Дүрс бичлэгийг хадгалах хугацаа 1 сар байна. Дүрс бичлэг ашиглах журмыг суурь бүтэц эзэмшигч батална.

7.77. Дүрс бичлэгийн төхөөрөмж тавих асуудлыг суурь бүтэц эзэмшигч Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журамд нийцүүлэн шийдвэрлэнэ. Дүрс бичлэгийн төхөөрөмж дараах шаардлагыг хангасан байна.

- Дүрсийг тасралтгүй бичих, архивлаж хадгалах, нөөцлөх, тэжээлийн найдвартай, шуурхай, тасралтгүй байдлыг хангах.

ДОХИОЛОЛ БА ХОЛБООНЫ ШУГАМ

7.78. Дохиолол төвлөрүүлэлт хориглолын ба холбооны агаарын шугамын унжилтын доод цэгээс газар хүртэл зай нь хоорондын замд 2.5 метрээс доошгүй, өртөөнд 3.0 метр, автомашины замтай огтолцсон газарт 5.5 метр (ажиллаж байгаа шугамд тэдгээрийг шинэчлэн байгуулах хүртэл 4.5 метр зайг хэвээр байлгахыг зөвшөөрнө) байна.

7.79. ДТХ ба холбооны агаарын шугамтай төмөр зам огтлолцсон газруудад утасны унжилтын доод цэгээс зам төмрийн толгойн түвшин хүртэлх зай 7.5 метрээс багагүй байна.

7.80. ДТХ-ын, холбооны шугам гэмтсэн үед тэдгээрийг дараах дэс дарааллаар сэргээн засна.

а. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбооны утас

б. Замын хагас автомат хориглол, цахилгаан очрын систем, галт тэрэгний өртөө хоорондын ба сумчны холбооны утас

в. Холбооны гол шугамын утас

г. ДТХ ба холбооны бусад утас

7.80. ДТХ, холбооны төхөөрөмж байгууламж, холбооны агаарын шугам нь цахилгаан дамжуулах шугамын нөлөөлөл, аянга болон агаарын (атмосферийн) хэт хүчдлээс хамгаалагдсан байна.

7.81. ДТХ ба Холбооны ОШК газар доогуур татах тохиолдолд шуудууны өргөн 0,3м, гүн нь 0,7м-ээс багагүй байна. Шилэн кабель байрлуулах явцад саад тааралдвал /дулааны шугам, гуу жалга г.м/ тухайн нөхцөл байдалд тааруулан өөрчилж болно. 1000м тутамд нөөц үлдээх ба 1м диаметртэй хуйлж байрлуулна.

7.82. ДТХ, холбоо, эрчим хүчний кабель шугамын трасст инженерийн шугам, сүлжээний хайгуул хийх, барилга байгууламж барих, шугам сүлжээ байгуулахдаа тухайн суурь бүтэц эзэмшигчээс зөвшөөрөл авах, түүнийг шилжүүлэх шаардлагатай бол уг ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.

ДОХИОЛОЛ ТӨВЛӨРҮҮЛЭЛТ ХОРИГЛОЛ БА ХОЛБООНЫ БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНИКИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

7.83. Төрөл бүрийн хамаарал бий болгодог дохиолол төвлөрүүлэлт хориглолын аппарат, галт тэрэгний ба өртөөний радио холбооны аппаратыг хааж ломбодсон байна. Дохиолол холбооны байгууламжийн засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжийн ажилтан уул байгууламжийн үзлэгийн дэвтэрт урьдчилсан бичлэг хийж, өртөөний жижүүрээр гарын үсэг зуруулсны дараа тэдгээрийг нээж болно. Дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны байгууламжийн ломбоны бүрэн бүтэн байдлыг уул аппаратыг ашигладаг ажилтан (өртөөний жижүүр, гармын жижүүр, сумчид, зүтгүүрийн машинч зэрэг) хариуцна.

7.84. Дохиолол холбооны байгууламжийн засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжид техникийн норм, стандартад тохирсон Дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны, бусад бүх байгууламжийн зураг, бүдүүвч байна. Хийсэн нэмэлт, өөрчлөлтийг эдгээр баримт бичигт цаг тухайд нь тусгаж баталгаажуулна.

7.85. Дохиолол төвлөрүүлэлт хориглолын байгууламжийн хамааралд 5-аас дээшгүй хоногийн хугацаанд түр өөрчлөлт оруулах бол суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Харин 5-аас дээш хоногийн хугацаанд өөрчлөлт оруулах бол суурь бүтэц эзэмшигч нь Төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

7.86. Өртөөний Дохиолол төвлөрүүлэлт хориглолын байгууламж, хэрэгслийг шинэчлэн тоноглох, зөөх, засварлах турших, солих, тэдгээрийн тогтоосон хамаарлыг алдагдуулах, түр зогсооход хүргэсэн болон бусад ажлыг өртөөний жижүүрийн зөвшөөрөлгүй, ажил удирдагч үзлэгийн дэвтэрт энэ тухай бичихгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

7.87. Дохионы хэрэгсэл, сум заагчийн гэрэлтүүлэг галт тэрэгнээс дохионы заалт тод үзэгдэх боломжийг хангасан байна. Дор дурдсан дохионы хэрэгслийг цаг тухайд нь тасралтгүй гэрэлтүүлэх явдлыг дараах нэгж хариуцна.

а. Гэрлэн дохио ба замнал заагчийг дохиолол холбооны байгууламжийн засвар үйлчилгээ хариуцсан нэгж

б. Семафор, сумны заагчийг тухайн өртөө

в. Зүтгүүр, вагон, зам, бусад аж ахуйн дохионы хэрэгслийг тус нэгж

г. Өртөөний зам дахь дохионы хэрэгсэл, гэрэлтүүлэх байгууламжийг эрчим хүч, хангамжийн байгууламж хариуцсан нэгж

7.88. Дохиолол холбооны байгууламжийн засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжийн ажилтан гэрлэн дохио, семафор, замнал заагчийн дохионы байнгын хэвийн үзэгдэлтийг хангаж байх үүрэгтэй.

7.89. Гэрлэн дохио ба семафорын дохионы үзэгдэлтийг цахилгаан механикч гэрлэн дохионы лампыг сольсны дараа болон 15 хоног тутам, инженер сард, дохиолол холбооны байгууламжийн засвар үйлчилгээ хариуцсан нэгжийн дарга 3 сард тус тус нэгээс доошгүй удаа зүтгүүр ба зам дээрээс тогтмол шалгана.

7.90. Радио холбооны ажиллагааг дохиолол холбооны байгууламжийн засвар үйлчилгээ хариуцсан нэгж, зүтгүүрийн депогийн удирдлага хамтран улиралд нэгээс доошгүй удаа зүтгүүрээс шалгана. Галт тэрэгний радио холбооны ажиллагааг дохиолол холбооны байгууламжийн засвар үйлчилгээ хариуцсан нэгжийн баталсан графикийн дагуу вагон-лаборатороор тогтмол шалгуулж илэрсэн **зөрчлийг** засуулж байна.

7.91. Дохиолол төвлөрүүлэлт хориглол, холбоо, **радиогийн** байгууламж, хэрэгслийг шинэчлэн тоноглох, зөөх, засварлах, турших, солих болон тэдгээрийн ажиллагааг түр зогсооход хүргэсэн бусад ажлыг ажил удирдагч томилон дохиолол холбооны байгууламжийн засвар үйлчилгээ хариуцсан нэгж мөрдөж байгаа журмын дагуу хийлгэнэ.

7.92. Дохиолол төвлөрүүлэлт хориоглол, зам, эрчим хүчний байгууламж болон хөдлөх бүрэлдэхүүн, өөрөө явагч хөдлөх нэгж нь зам төмрийн цахилгаан хэлхээний байнгын найдвартай ажиллагааг хангаж байна.

7.93. Дараах **нэгж** зам төмөр хэлхээний тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах элементүүдийн арчлалтыг хариуцна.

а. Замын реле, кабель, трансформаторын (хувьсгуурын) хайрцаг, бутлег, мөн зам төмрийн хэлхээний шунтын мэдрэмтгий чанарыг **шалгаж** тохируулахыг дохиолол холбооны байгууламжийн засвар үйлчилгээ хариуцсан нэгж

б. Тусгаарлагч уулзвар, сумны болон уулзварын холбоос, ус зайлуулагч, дэр модны худаг ба балластыг гүйдэл алдалтын эсэргүүцлийн тогтоосон нормын дагуу арчлахыг замын засвар үйлчилгээ хариуцсан нэгж

в. Шунтын мэдрэмтгий чанар хангагдахгүй нөхцөлд ажиллах журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

7.94. Хагас автомат хориглолыг тэжээх зай хурааггуурын нөөц эх үүсвэрийг байнгын бэлэн байлгаж, хувьсах гүйдлийн тэжээлийг тасалсан үед зураг төслөөр тогтоосон хугацаанд ДТХ-ын гармын дохиололын тасралтгүй ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.95. Дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны байгууламжийг хариуцсан ажилтан тэдгээрийг эзэмшиж, ашиглах талаар шалгалт өгсөн байна. Эдгээр байгууламжийг ашиглахад ажилтнаа сургах, тогтоосон хугацаанд мэдлэгийг нь шалгаж байх үүргийг тухайн ажилтныг шууд удирддаг дарга хариуцна.

7.96. Микропроцессорын төвлөрүүлэлт, электрон тоног төхөөрөмж бүхий ерөөнүүдэд хөргөх төхөөрөмж байрлуулж, нарны шууд тусгалаас хамгаална. Тус ерөөнүүдийн температурыг тоног төхөөрөмжийн гэрчилгээн дээр заасны дагуу тохируулбал зохино.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН ЦАХИЛГААН, УС ХАНГАМЖИЙН ТӨХӨӨРӨМЖ, БАЙГУУЛАМЖ

8.1. Төмөр замын цахилгаан хангамжийн байгууламж нь:

а. Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагаа, тасралтгүй үйл ажиллагааг хангана.

б. Дохиолол төвлөрүүлэлт хориглол, холбооны байгууламжийг хоёр эх үүсвэрээс тэжээх, үндсэн тэжээлээс бэлтгэл тэжээлд автоматаар шилжүүлэх боломжтой байлгана.

в. Дохиолол төвлөрүүлэлт хориглол, холбооны байгууламж нь үндсэн ба бэлтгэл тэжээлээс гадна нөөц эх үүсвэр, тасралтгүй тэжээлийн үүсгүүртэй байна. Үндсэн болон бэлтгэл тэжээл тасалдсан үед нөөц эх үүсвэр нь автоматаар шилжих боломжтой байна.

г. Төмөр замын бүх хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангана.

д. Цахилгаан эрчим хүчээр хэрэглэгчийг найдвартай хангахын тулд цахилгаан хангамжийн тоног төхөөрөмжийн ажлын хэвийн байдалд тогтмол хяналт тавьж, тэдгээрийн параметруудийг цахилгаан лаборатори болон бусад зориулалтын багаж хэрэгслэлийн тусламжтайгаар хэмжиж, төлөвлөсөн хугацаандаа зохих засвар, үйлчилгээг хийж байх ёстой.

8.2. Дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны байгууламж стандартаар тогтоосон хэвийн хүчдэлтэй байна. Хэвийн хүчдлийн өөрчлөлт нь **хүчний оруулалтын самбар дээр** буурах тал руу 10 хувиас, ихсэх тал руу 5 хувиас хэтрэхгүй байна.

8.3. Цахилгаан хангамжийн байгууламж, богино холбооны гүйдэл, хэт хүчдэл болон тогтоосон нормоос хэт ачаалахаас хамгаалагдсан байна.

8.4. Төмөр замын цахилгаан хангамжийн шугам, тэжээлийн ба секцлэлийн бүдүүвчийг суурь бүтэц эзэмшигч батална.

8.5. Цахилгаан дамжуулах шугамын хуурай салгуурын дамжуулгыг цоожилсон байна. Дамжуулга бүрт салгуурын нэр бүхий бичиг зүүнэ. Тэжээлийн шугамын секцийн салгуурыг зөвхөн эрчим хүчний **ээлжийн** зохицуулагчийн тушаалаар сэлгэн залгана.

8.6. Цахилгаан байгууламжид төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажил гүйцэтгэхэд аюулгүй ажиллагааг хангах, салгуурын түгжээтэй дамжуулгын түлхүүрийг хадгалах, салгуурыг сэлгэн залгах журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

8.7. Эрчим хүчний шугамын хүчдлийг салгах ажлыг эрчим хүчний зохицуулагчийн тушаалаар зөвхөн мэргэжлийн ажилтан гүйцэтгэнэ. Хүчдэлгүй эрчим хүчний шугамын залгуур, салгуурыг эрчим хүчний **ээлжийн** зохицуулагчийн

тушаалаар Дохиолол төвлөрүүлэлт хориглолын цахилгаан механикч сэлгэн залгаж болно.

8.8. Төмөр замын дагууд Дохиолол төвлөрүүлэлт хориглол, холбооны ба цахилгаан дамжуулах шугамыг барихдаа тулгуурыг төмөр замын зам төмрийн тэнхлэгээс тулгуурын өндөр дээр 3 метрийг нэмснээс дотогшгүй зайд байрлуулна. Замын тэнхлэгээс паркийн гэрэлтүүлгийн шугамын тулгуурын дотор тал хүртэлх зай нь 3100 мм-ээс доошгүй байна.

8.9. Одоо ашиглаж байгаа хэсэгт өөрчлөх хүртэл, шинээр барих шугамд онцгой бартаатай нөхцөлд замын тэнхлэгээс өртөөн дэх тулгуурын дотор тал хүртэлх зай нь 2450 мм-ээс доошгүй байж болно. Цахилгаан дамжуулах шугамын тулгуур ба байнгын дохионы тулгуур, дохионы тэмдгийн харилцан байрлал нь дохио ба тэмдгийн үзэгдэлтийг сайн хангасан байна.

8.10. 1000в-оос дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугамын утасны унжилтын доод цэгээс газрын гадаргуу хүртэлх зай нь утас хамгийн их унжсан үед дор дурдсанаас багагүй байна.

- | | |
|---|--------|
| - Хоорондын замд | 6 метр |
| - Маш их бартаатай газарт | 5 метр |
| - Автомашины замтай огтлолцсон газар өртөө, суурин газарт | 7 метр |

8.11. Төмөр зам дээгүүр хөндлөн гарсан цахилгаан дамжуулах агаарын шугамын утасны унжилтын доод цэгээс зам төмрийн толгойн дээд түвшин хүртэлх зай 7,5 метрээс багагүй байна.

8.12. Огтлолцолын алгасалтыг хязгаарласан тулгуур нь хүчитгэсэн анкер хийцтэй байх бөгөөд огтлолцолын утас нь залгаасгүй, давхар бэхэлгээтэй байна.

8.13. Өртөө, зөрлөгийн зорчигчийн тавцан, парк, дов, сумны бэлчир, гүүр, хамгаалалттай гарам тогтоосон хэмжээний гэрэлтүүлэгтэй байна.

- | | |
|--|--------|
| - Зорчигчдын тавцан | 4 люкс |
| - Ялгалтын дов | 5 люкс |
| - Зохицуулалттай гарам | 2 люкс |
| - Хүлээн авах, явуулах зам, сумны бэлчир | 1 люкс |
| - Гүүр | 1 люкс |

Гэрэлтүүлэг нь цагаан гэрэлтэй байна.

8.14. Ус хангамжийн газрын **байршил**, ус хангамжийн эх үүсвэр болон ус боловсруулах төхөөрөмж, шугам сүлжээ, барилга байгууламжийн техникийн **тоноглол** нь **галт тэрэгний хөдөлгөөн** хамгийн их болох үед зохих тоо чанарын үзүүлэлттэй усаар зүтгүүр, галт тэрэг, өртөөдийг тасралтгүй хангахын зэрэгцээ бусад аж ахуй, гал унтраах, ундны усны хэрэгцээг хангаж **чадахуйц** байна.

8.15. Төмөр зам доогуур тавигдсан ус дамжуулах шугам нь **хамгаалалтын гэртэй** байна.

8.16. Зам төмөр элсэнд хучигддаг хэсэгт ойжуулалт, элснээс хамгаалах ногоон зурвас байгуулах ажлыг усаар хангана.

8.17. Ариутгах татуургын байгууламж төмөр замын үйлдвэр, орон сууцны хорооллоос гарсан бохир усыг татан зайлуулж, технологийн дагуу цэвэрлэнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

БАЙГУУЛАМЖ, ТӨХӨӨРӨМЖИЙН ҮЗЛЭГ, ЗАСВАР

9.1. Төмөр замын барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн үзлэгийг тэдгээрийг шууд хариуцдаг ажилтан, мөн эдгээр барилга, байгууламж, тоног төхөөрөмж мэдэлд нь байдаг салбар ба нэгжийн дарга, удирдах ажилтан тогтоосон дүрэм, журам, заавар, хуваарийн дагуу хийж тээврийн тасралтгүй хэвийн ажиллагаа, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй **байдлыг** хангуулна.

9.2. Үзлэгийн дүн, илэрсэн гэмтлийг арилгах шаардагдах арга хэмжээ авах тухай хугацаатай үүрэг даалгаврыг тусгай дэвтэрт бичиж байна.

9.3. Суурь бүтэц эзэмшигч, тасгийн дарга, салбар хариуцсан удирдлагууд **харьяалагдах** салбар, нэгжийн байгууламж, төхөөрөмжийн бүрэн бүтэн найдвартай ажиллагаа, ажлын технологийн мөрдөлт, галт тэрэгний хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй **байдал, эрүүл ахуйн шаардлагыг** хэрхэн хангаж байгаад суурь бүтэц эзэмшигчийн тогтоосон хуваарийн дагуу үзлэг шалгалт хийнэ.

БАЙГУУЛАМЖ, ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР

9.4. Төхөөрөмж, байгууламжид засвар, үйлчилгээ хийхдээ хөдөлгөөний аюулгүй **байдлыг** хангахын хамт галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг зөрчихгүй байвал зохино. Барилга, засварын их хэмжээний ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан галт тэрэгний хөдөлгөөний зурмагт “цонх” гаргаж, хурд хязгаарлагдах явдлыг харгалзан үзнэ.

9.5. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгагдаагүй зам, дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны байгууламж, бусад төхөөрөмжийн засварын ажлыг галт тэрэгний хөдөлгөөн багатай үед хоорондын зам хаахгүйгээр гүйцэтгэнэ.

9.6. Хэрэв тэдгээр ажлыг гүйцэтгэх явдал нь галт тэрэгний хөдөлгөөнийг тасалдуулахад хүргэхээр байвал суурь бүтэц эзэмшигч уг ажлыг эхлэх ба дуусах цагийг хөдөлгөөн хариуцсан салбарын удирдлага, ажил удирдагчтай хамтран тогтооно.

9.7. Ажил удирдагч нь хөдөлгөөн тасалдуулах ажил гүйцэтгэх, уг ажлыг хийхийн тулд хөдөлгөөний зурмагт “цонх” гаргасан үед галт тэрэгний зохицуулагчтай байнгын утсан харилцаа тогтоосон байна.

9.8. Хоорондын зам, өртөөн дээр гарсан аливаа саад нь хөдөлгөөнд аюул учруулах, галт тэрэгний хөдөлгөөнийг зогсоох буюу хурд бууруулах шаардлагатай

бол уг саадтай газрыг галт тэрэг, сэлгээний бүрэлдэхүүн ирэх эсэхийг харгалзахгүйгээр хоёр талаас нь дохиогоор хааж хамгаалсан байна.

Дараах зүйлийг хориглоно.

а. Хөдөлгөөнд аюул бүхий саадтай буюу ажил гүйцэтгэх газрыг дохиогоор хааж хамгаалахаас өмнө ажил эхлүүлэхийг,

б. Саадыг арилгах ажлыг бүрэн дуусаагүй, замын байдал хэвийн, овор хэмжээний шаардлага хангагдсан эсэхийг шалгахаас өмнө уул ажил хийж буй газар буюу саадыг хааж хамгаалсан дохиог буулган авахыг,

9.9. Саадтай газар болон саадыг арилгах ажил хийх газрыг хорио хамгаалалтаар хашиж, хамгаалахыг **Төрийн захиргааны төв байгууллагын баталсан төмөр замын дохиоллын харилцааг зохицуусан журмаар** тогтооно.

9.10. Зам дээр ажил гүйцэтгэх газрыг хааж хамгаалсан зөөврийн дохио тавих ба хамгаалахын тулд ажил удирдагч бригадын ажилтан дотроос зохих шалгалт өгсөн хүнийг дохиочноор томилно. Дохиочин нь төмөр замын тээврийн бусад ажилтнаас ялгагдах өнгийн малгай өмссөн байна.

9.11. Зам дээр **болон** бага радиустай тахир хэсэг, сэтэрхий, дохионы үзэгдэлт муутай замд засварын ажил гүйцэтгэх үед галт тэрэгний хөдөлгөөний болон **ажилтнуудын** аюулгүй **байдлыг** хангахын тулд ажил удирдагчийг тухайн хэсгийн галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч, дохиочидтой харьцах, радио холбоо, утсан холбоогоор хангана.

9.12. Холбоогоор хангах шаардлагатай ажлуудыг суурь бүтэц эзэмшигчийн баталсан **журмаар** тогтооно.

а. Замын машин механизмыг хэрэглэж ажлыг өргөн фронтоор гүйцэтгэж байгаа замын их, дунд, өргөлтийн засварт

б. Зам төмрийг тууш солих, ашиглагдаж байгаа замуудад суман шилжүүлгийг солих, шинээр тавихад

в. Гүүрийн ба замын сараалжийг авах, тавих, гүүрийн нислэгийн хэсгийг өргөх, хоолой барих, төмөр замаар гарах гарц байгуулах зэрэг галт тэрэгний хөдөлгөөнийг удаан хугацаагаар зогсоох ба хурдыг хязгаарлах ажлыг гүйцэтгэхэд

г. 150 мм-ээс дээш зузаантай ивүүр тавьж овойлттой замыг засах зэрэг болно.

9.13. Дохиолол холбооны байгууламжийн засвар үйлчилгээ хариуцсан нэгжийн ажилтан нь ажил удирдагч, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчтай харьцах утсан холбоог ажил эхлэхээс 1 цагийн өмнө бэлэн болгож, **“ЦОНХ”-д** гүйцэтгэх ажил дуусч хоорондын замыг галт тэрэгний хөдөлгөөнд нээх хүртэл тэндээ байх үүрэгтэй.

9.14. Ажил удирдагч нь утсан холбоогоор хангагдах хүртлээ дохиочидтой радио станц, үзэгдэх ба дуун дохиогоор түр харьцана. Үзэгдэлт муутай үед үндсэн дохиог дамжуулагч завсарын дохиочинг гаргасан байна.

9.15. Өртөөний зам дээр зогсоох буюу хурд бууруулах дохиогоор хааж хамгаалах шаардлагатай ажлыг **үзлэгийн дэвтэрт** ажил удирдагчийн урьдчилан

бичсэн бичлэггүйгээр, мөн өртөөний жижүүрийн зөвшөөрөлгүйгээр хийж гүйцэтгэхийг хориглоно.

9.16. Ажил удирдагч ажил дуусмагц уг байгууламжид хийх ажил дууссан тухай **үзлэгийн дэвтэрт** бичлэг хийх ба түүнийг үндэслэн өртөөний жижүүр хэвийн ажиллагаанд оруулна.

9.17. Ажил гүйцэтгэхийн тулд хоорондын замыг галт тэрэгний хөдөлгөөнд хаах явдлыг зөвхөн суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Хоорондын зам хаах явдал нь бусад төмөр замын хөдөлгөөний зурмагт нөлөөлөхөөр бол суурь бүтэц эзэмшигч нь Төрийн захиргааны **төв** байгууллагатай зөвшилцөнө.

9.18. Хоорондын замыг галт тэрэгний хөдөлгөөнд хаах ба нээх явдлыг ажил эхлэхийн өмнө буюу ажил дуусмагц галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар гүйцэтгэнэ.

9.19. Ажил удирдагч нь хоорондын замыг галт тэрэгний хөдөлгөөнд хаасан тухай галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчаас (бичгэн мэдэгдэл, утсаар буюу цахилгаанаар ирүүлсэн) тушаал хүлээн авч уг ажлын газрыг дохиогоор хааж хамгаалахаас өмнө ажилд орохыг хориглоно.

9.20. Уул ажлыг ямар байгууллага гүйцэтгэснийг үл харгалзан замын буюу хиймэл төхөөрөмжийн ажил дууссан ба галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй, тасралтгүй ажиллагаанд саадгүй болсон тухай замын байгууламжийн засвар үйлчилгээ хариуцсан нэгжийн дарга буюу түүний эрх олгосноор албан тушаалын хувьд замын мастераас доошгүй албан тушаалтнаас бичгэн мэдэгдэл, утсан буюу цахилгаан мэдээг авсны дараа хоорондын замыг нээнэ.

9.21. Дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны ашиглагдаж байгаа байгууламжийн ажиллагааг болон цахилгаан хангамжийг сэргээх явдлыг **инженер**, Дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны байгууламжийг найдвартай ажиллагаагаар хангах **ээлжийн зохицуулагч** буюу эрчим хүчний **ээлжийн зохицуулагчаас** мэдэгдэл авсны дараа гүйцэтгэнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ

ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН

10.1. Ерөнхий шаардлага

10.1.1. Хөдлөх бүрэлдэхүүн нь **харьяалал** болон өмчийн төрөл хэлбэрээс үл хамаарч тээврийн тасралтгүй, аюулгүй **байдалд** тавигдах шаардлагыг хангаж бүрэн бүтэн, гэмтэлгүй байх ёстой. Хөдлөх бүрэлдэхүүнд тогтоогдсон стандарт, норм, технологийн дагуу засвар, үйлчилгээ хийх нь **эзэмшигчийн**, ашиглалтын үед гэмтэлгүй байлгах нь энэхүү ажлыг хариуцсан **ажилтны** гол үүрэг болно.

10.1.2. Вагоныг бүрдүүлэгч бүх хэсэг нь бат бөх, тогтвор сайтай байхаас гадна ашиглалтын үеийн техникийн байдал нь **үйлдвэрлэгчээс** тогтоосон хамгийн

их хурдаар галт тэрэг явах үед аюул осолгүй, зөөлөн жигд хөдөлгөөнийг хангаж байвал зохино.

10.1.3. Хөдлөх бүрэлдэхүүн нь хөдлөх **бүрэлдэхүүний** оврын стандартын шаардлагыг хангасан байна. Хөдлөх **бүрэлдэхүүн** нь Төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу **гэрчилгээжүүлэлтэд** хамрагдсан байна.

10.1.4. Хөдлөх бүрэлдэхүүний нэгж бүр стандартын шаардлага хангасан ялгах өнгө, тэмдэгтэй байхаас гадна бичилт хийгдсэн байна. Тухайлбал: Монгол Улсын сүлд (ачааны вагоноос бусад), замын нэр тэмдэг, дугаар, үйлдвэрлэсэн газар, он сар өдрийг заасан үйлдвэрлэгчийн пайз, тогтоосон төрлийн засварыг хийсэн газар он, сар, өдөр, өөрийн жинг (зүтгүүрээс бусдад) заасан бичигтэй байна.

10.1.5. Хөдлөх бүрэлдэхүүн, түүний **эд ангид тавигдах дугаарлалт, тэмдэг тэмдэглэгээнт стандартын шаардлагыг хангасан байна.**

10.1.6. Зүтгүүр дээр бүтээцийн хурд, сери, дугаар данслагдсан депогийн нэр, нөөцийн сав ба хянах хэрэгсэлд үзлэг магадлагаа хийсэн тухай пайз бичилт, зорчигчийн вагон дээр суудлын (орны) тоо, ачааны вагонд эзэлхүүн, даацыг заасан бичилт хийгдсэн байна.

10.1.7.. Хөдлөх бүрэлдэхүүн бүрд техникийн ба ашиглалтын шинж байдлыг тодорхойлсон техникийн паспорт байх бөгөөд түүнд засвар хийсэн байгууллага тэмдэглэл хөтөлж баталгаажуулна.

10.1.8. **Зүтгүүрийн** машинчийн сонор сэрэмж шалгах төхөөрөмж, тоормосны гол хоолойн даралт, хөдөлгөөний хурд цагийг зааж бичдэг хурд хэмжигч эсвэл ба радио станцаар тоноглогдсон байна. Аялалын зүтгүүр радио холбооноос гадна тоормосны гол хоолой тасарсныг дохиолох төхөөрөмж, галын дохиоллоор тоноглогдсон байна.

10.1.9. Хөдлөх бүрэлдэхүүний бүтцэд Төрийн захиргааны **төв** байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно.

10.1.10. Тусгай хэрэгцээний хөдлөх бүрэлдэхүүний болон замаас авагддаг хөдөлгөөнт нэгжүүдэд тавих техникийн шаардлага, тэдгээрийг арчлах, ашиглах журмыг суурь бүтэц эзэмшигч батална.

10.1.11. Дагнасан болон нийтийн хэрэглээний төмөр замаас нийлсэн замтай өртөөнд бусад төмөр замын байгууллагын хөдлөх бүрэлдэхүүн ажиллах, явах журмыг Төрийн захиргааны **төв** байгууллага тогтооно.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХОС ДУГУЙ

11.1. Хос дугуй нь Төрийн захиргааны **төв** байгууллагаас баталсан үзлэг хийх, магадлах, засварлах, угсрах зааврын шаардлагыг хангасан байна. Хос дугуйн голын зааварт заагдсан хэсэг дээр хос дугуйг угсарсан, бүрэн магадлагаа

хийсэн газар, он, сар, өдрийг тод харагдахуйц тэмдэглэхээс гадна угсралтын ажлыг хүлээн авсан болохыг нотолсон тэмдэглэгээг мөн тавина.

11.2. Хөдлөх бүрэлдэхүүнд байгаа хос дугуйд тогтоосон журмын дагуу үзлэг, энгийн ба бүрэн магадлагаа хийхийн дээр тэдгээрийг хөдлөх бүрэлдэхүүнд угсрах үед мэдээллийг бүртгэлийн дэвтэр, **паспортод** бичиж тэмдэглэсэн байна.

1520 ММ ЦАРИГТАЙ ЗАМД АШИГЛАГДАХ ХОС ДУГУЙ

11.3. Ачаалагдаагүй хос дугуйн дотор талын гадаргуунуудын хоорондын зай нь 1440 мм **байна**. 120-140 км/цаг-ийн хурдтай явах зүтгүүр ба вагоны хос дугуйн дотор талын ирмэгүүдийн хоорондох зайн ихсэлт 3 мм-ээс, багасалт нь 1 мм-ээс, 120 км/цаг хүртэл хурдтай явах зүтгүүр, вагоны хос дугуйн дотор талын ирмэгүүдийн хоорондох зайн ихсэлт, багасалт 3 мм-ээс тус тус ихгүй байна.

11.4. Хос дугуйн гол, мөөр, зээрэнцэг, бул, дэлэнд ан цав, дэлэнд нь хурц ирмэг, шамралт, ховхролт, эмтрэлт үүссэн байж болохгүй. Зам ба хөдлөх бүрэлдэхүүний хоорондын харилцан үйлчлэлийг алдагдуулж болох дараахь элэгдэл, гэмтэлтэй хос дугуйтай хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглалтад оруулах, галт тэргэнд явуулахыг хориглоно.

а. 120-140 км/цаг-ийн хурдтай явах үед дугуйн өнхрөх гадаргуугийн элэгдэлт зүтгүүр, зорчигчийн вагонд 5 мм-ээс их, зүтгүүрийн дугуйн дэлний оройгоос 20 мм, зорчигчийн вагоны дугуйн дэлний оройгоос 18 мм-ийн зайд хэмжихэд дэлний зузаан нь 33 мм-ээс их буюу 28 мм-ээс бага байвал:

б. 120 км/цаг хүртэл хурдтай явах үед дугуйн өнхрөх гадаргуугийн жигд элэгдэл зүтгүүр ба алсын харилцааны галт тэрэгний зорчигчийн вагонд 7 мм-ээс дээш, орон нутгийн ба хот дүүргийн харилцааны галт тэрэгний зорчигчийн вагонд 8 мм-ээс дээш, хөргүүртэй болон ачааны вагонд 9 мм-ээс дээш байвал, зүтгүүрийн дугуйн дэлний оройгоос 20 мм, зорчигчийн вагоны дугуйн дэлний оройгоос 18 мм-ийн зайд хэмжихэд дугуйн дэлний зузаан нь 33 мм-ээс их 25 мм-ээс бага, мөн ачааны вагоны дугуйн дэлний оройгоос 18 мм-ийн зайд хэмжихэд дугуйн дэлний зузаан нь 33 мм-ээс их 24 мм-ээс бага байвал

в. Тусгай загвараар хэмжихэд дэл нь 18 мм-ээс илүү босоо элэгдсэн байвал

г. Зүтгүүр, вагоны дугуйн өнхрөх гадаргууд 1 мм-ээс дээш чирэгтэй байвал.

11.5. Замд явж байхдаа вагоны дугуйд 1 мм-ээс их боловч 2 мм-ээс илүүгүй чирэг гарсныг илрүүлбэл уг вагоныг (зорчигчийн галт тэрэг бол тогтоосон хурдтай боловч 100 км/цагаас дээшгүй хурдтай, ачааны галт тэрэг бол 70 км/цагаас дээшгүй хурдтай) галт тэрэгнээс салгалгүйгээр хос дугуй солих хэрэгсэл бүхий ойролцоо орших техник үйлчилгээний газарт хүргэхийг зөвшөөрнө.

11.6. Чиргийн хэмжээ нь вагонд 2-6 мм, зүтгүүрт 1-2 мм хүртэл байвал галт тэргийг ойрын өртөө хүртэл 15 км/-цагаас ихгүй хурдтай явуулна. Хос дугуйн чиргийн хэмжээ нь вагонд 6-12 мм, зүтгүүрт 2-4 мм хүртэл байвал галт тэргийг 10 км/цаг-аас ихгүй хурдтай явуулж ойролцоо өртөөнд хос дугуйг солино.

Хэрэв хос дугуйн чиргийн хэмжээ нь вагонд 12 мм-ээс их байвал ивүүр тавьж хос дугуйг эргэхгүй болгон ойролцоо өртөө хүртэл 10 км/цаг-аас ихгүй хурдтай явуулна.

11.7. Зүтгүүрт 4 мм-ээс их байвал зүтгүүрийг галт тэрэгнээс салган гэмтэлтэй хос дугуйн татах мотор, тоормосны **цилиндрийг** салгаж дугуйг өргөж бэхлээд 10 км/цаг-аас илүүгүй хурдтай ойролцоо өртөөнд хүргэж солино.

Харин 2-оос дээш хос дугуйд 4 мм-ээс их чирэг гарсан бол газар дээр нь хос дугуйг гагнуураар шавж зохих боловсруулалт хийж цааш дугуй солих өртөө хүртэл явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

11.8. Ачааны вагоныг зорчигчийн галт тэргэнд залгахад уул вагоны хос дугуйн арчлалтын норм хэмжээ нь зорчигчийн галт тэргэнд тавигдах шаардлага хангасан байна.

1435 ММ ЦАРИГТАЙ ЗАМД АШИГЛАГДАХ ХОС ДУГУЙ

11.9. 1435 мм царигтай замд ашиглагдах хос дугуй нь дараах шаардлага хангасан байна.

а. Зорчигчийн вагонд:

- Ачаалагдаагүй хос дугуйн дотор талын ирмэгүүдийн /гадаргуунуудын/ хоорондын зай 1353 мм байх бөгөөд ихсэлт нь 3 мм-ээс, багасалт нь 1 мм-ээс ихгүй

- Цул ба жийрэг мөөртэй хос дугуйн мөөрийн өргөн 136 мм-ээс ихгүй, 127 мм-ээс багагүй

- Дэлний оройгоос 15 мм зайд хэмжихэд дэлний зузаан 34 мм-ээс ихгүй, 23 мм-ээс багагүй байна.

- Хос дугуйн өнхрөх гадаргуун жигд элэгдэл 6 мм-ээс ихгүй байна.

б. Ачааны вагонд:

- Ачаалагдаагүй хос дугуйн дотор талын гадаргуунуудын хоорондын зай 1353 мм байх бөгөөд ихсэлт нь 3 мм-ээс, багасалт нь 1 мм-ээс ихгүй

- Цул ба жийрэг мөөртэй хос дугуйн мөөрийн өргөн 136 мм-ээс ихгүй, 127 мм-ээс багагүй

- Дэлний оройгоос 15 мм зайд хэмжихэд дэлний зузаан 34 мм-ээс ихгүй, 22 мм-ээс багагүй

- Хос дугуйн өнхрөх гадаргуун жигд элэгдэл 7 мм-ээс ихгүй байна.

в. Зүтгүүрт:

1435 мм царигтай замд ашиглагдах зүтгүүрийн хос дугуйн дотор талын гадаргуунуудын хоорондын зай 1360 мм, түүний ихсэлт, багасалт нь 3 мм-ээс ихгүй байна. Хос дугуйн мөөрийн өргөн 140 мм-ээс ихгүй байна.

Дэлний оройгоос 20 мм зайд хэмжихэд дэлний зузаан 34 мм-ээс ихгүй, 25 мм-ээс багагүй байна. Хос дугуйн өнхрөх **гадаргын** элэгдэл 7 мм-ээс ихгүй байна.

Зүтгүүр, зорчигчийн болон ачааны вагоны хос дугуйн гадаргууд гарсан чирэг, шаваас хос дугуйн гэмтэл өргөн царигийн вагоныхтай ижил байна.

11.10. Дор дурдсан аль нэгэн гэмтэл бүхий хос дугуйтай хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглалтад оруулах буюу явуулахыг хориглоно.

а. Зүтгүүрт:

- Дугуйн жийрэг мөөр төв дээрээ буюу гол нь бул дотроо тус тус суларсан
- Гол дээр 25 мм-ээс урт тууш цав гарсан буюу хуурсан
- Зүтгүүрийн дугуйн гол дээр 4 мм-ээс дээш, мотовозын гол дээр 2.5 мм-ээс дээш холгогдсон
- Жийрэг мөөр дээр цав гарсан
- Жийрэг мөөрийн өнхрөх гадаргууд далд цэврүүтсэн буюу хортонтсон, хурц ирмэгт шамралт үүссэн

б. Вагонд:

- Голын хүзүү буюу булын өмнөх хэсэг үрэгдэж, зурагдсан
- Гол дээр 2.5 мм-ээс гүнзгий холгогдсон
- Цул дугуйн аль нэг хэсэгт цавтсан
- Дугуйн өнхрөх гадаргууд холтралт, ховхролт нь зорчигчийн вагонд гүн нь 10 мм, урт нь 25 мм, ачааны вагонд гүн нь 10 мм, урт нь 50 мм-ээс их болсон
- Дугуйн дэл зам төмрийн толгойн дотор гадаргуутай харьцах ажлын талстад шамралт үүссэн
- Дугуйн дэл хурц элэгдэлтэй
- Дугуйн мөөрийн зузаан нь дугуйн дотор ирмэгээс 70 мм-ийн зайд хэмжихэд зорчигчийн вагонд 25 мм, ачааны галт тэргэнд аялдаг ачааны вагонд 20 мм-ээс тус тус бага болсон.
- Дугуйн мөөр буюу жийрэг мөөрийн өнхрөх гадаргуу дээр металл түрэгдэж шавсан гэмтэл, зорчигчийн вагоны хос дугуйд 0.5 мм-ээс ачааны вагонд 1 мм-ээс өндөр болсон зэрэг болно.

11.11. Завсрын өртөөн дээр дурдсан хэмжээнээс их боловч 2 мм-ээс илүүгүй шаваас бүхий дугуйтай вагон илрүүлбэл тийм вагон явуулах журам нь хос дугуйд нь чирэг гарсан **вагонтой** адил байна.

11.12. 2 мм-ээс илүү шаваастай байвал шаваасыг 2 мм хүртэл багасгасны дараа вагоныг хоорондын замаас татаж авах журам нь чирэгтэй **вагонтой** адил байна.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТООРМОСНЫ ТОНОГЛОЛ, АВТО УГСРААНЫ ХЭРЭГСЭЛ

12.1. Хөдлөх бүрэлдэхүүн нь автомат тоормосоор тоноглогдсон байна.

12.2. Автомат тоормос нь ажиллуулахад хялбар, ашиглалтын ямар ч нөхцөлд найдвартай, зөөлөн жигд ажилладаг байхаас гадна тоормосын гол хоолой салах буюу тасрах, яаралтай тоормослох краныг нээх үед галт тэргийг яаралтай зогсоох үүрэгтэй.

12.3. Төрийн захиргааны төв байгууллагын баталсан "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний автомат тоормосыг ашиглах заавар"-ын дагуу хөдлөх бүрэлдэхүүний автомат тоормосын системд засвар, үйлчилгээ хийнэ.

12.4. Хөдлөх бүрэлдэхүүний автомат тоормос нь яаралтай тоормос **хийхэд тогтоосон** тоормосны замаас ихгүй зайд галт тэргийг зогсоож чадахуйц тоормосны шахалтаар хангагдсан байна.

12.5. Ачааны маягийн автомат тоормос нь вагоны ачаалалт, галт тэрэгний урт, замын аясаас шалтгаалан тоормослох янз бүрийн дэглэм хэрэглэх боломжийг хангаж байна. Зорчигчийн вагон гонхондоо (тамбур) ба хонгил (коридор) дотроо яаралтай тоормослох крантай байх бөгөөд тэдгээр нь ломботой байна.

12.6. Зүтгүүр, зорчигчийн вагон, дрезин **ажиллагаатай** гар тоормостой байна. Ачааны вагоны **паркийн** тодорхой хэсэг нь бүрэн ажиллагаатай **яаралтай** зогсоох кран ба гар тоормосоор тоноглогдсон дамжих тавцантай байх ба энэхүү хувь хэмжээг суурь бүтэц эзэмшигч тогтооно. Хөдлөх бүрэлдэхүүний гар тоормосны арчилгааг тогтмол хийж, тоормосны шахалтыг тогтоосон хэмжээнд байлгана.

12.7. Тоормосны хөшүүргэн дамжуулгын хэсгүүд нь бэхэлгээнээсээ салах буюу гэмтэх, оврын хэмжээнээс илүү гарах, зам дээр унаж чирэгдэхээс хамгаалсан хэрэгсэлтэй байна.

12.8. Хөдлөх бүрэлдэхүүн авто угсраагаар тоноглогдсон байх бөгөөд авто угсраа нь тогтоосон зааврын дагуу засвар үйлчилгээ хийгдсэн байна.

12.9. Авто угсрааны тэнхлэгийн өндөр зам төмрийн толгойн дээд талын түвшингээс дээш зүтгүүр, зорчигчийн ба ачааны хоосон вагонд 1080 мм-ээс ихгүй, зүтгүүр болон хүн суулгасан зорчигчийн вагонд 980 мм-ээс багагүй, ачаатай ачааны вагонд 950 мм-ээс багагүй байна.

12.10. 1435 мм царигтай замд ашиглагддаг вагоны авто угсрааны тэнхлэгийн өндөр ачааны вагонд 890 мм-ээс ихгүй, хоосон вагонд 835 мм-ээс багагүй, ачаатай вагонд 815 мм-ээс багагүй байна.

12.11. Зорчигчийн вагонд автомат угсрааны тэнхлэгийн өндөр зам төмрийн толгойн дээд талын түвшингээс 890 мм-ээс ихгүй, 830 мм-ээс багагүй байна.

12.12. Авто угсрааны тууш тэнхлэгийн хоорондох өндрийн зөрүү дараах хэмжээнээс ихгүй байна.

1520 мм царигтай замд:

- Орон нутгийн зорчигчийн болон ачааны галт тэргэнд 100 мм
- Ачааны галт тэрэгний зүтгүүр ба **эхний вагоны** хооронд 110 мм
- 120 км/цаг хүртэл хурдтай явах олон улсын зорчигчийн галт тэргэнд 70 мм
- 121-140 км/цаг хүртэл хурдтай явах олон улсын зорчигчийн галт тэргэнд 50 мм
- Зорчигчийн галт тэрэгний зүтгүүр ба эхний вагоны хооронд 100 мм

Урт ачааг 2-3 тавцан вагон дээр дамнуулан ачсан тохиолдолд тавцан вагоны автомат угсрааны тэнхлэгийн өндрийн зөрүү нь 80 мм-ээс ихгүй байна.

1435 мм царигтай замд:

- Зорчигчийн галт тэргэнд 60 мм
- Ачааны галт тэргэнд 75 мм

12.13. Авто угсрааны тууш тэнхлэгийн хоорондох өндрийн зөрүү нормоос хэтэрсэн тохиолдолд найруулагчийн бригад вагонуудыг сэлгэн тавьж тохируулна. Автомат угсрааны тууш тэнхлэгийн өндрийн зөрүүг цоожны өндрийн зөрүүгээр тодорхойлно.

12.14. Зүтгүүр, ачааны ба зорчигчийн вагон, бусад хөдлөх бүрэлдэхүүний автомат угсрааны тэнхлэгийн өндрийг тохируулах явцад төвлөрүүлэх дүүжин дээр хавчуулга **ивээс тавих хориглоно.**

12.15. Зорчигчийн вагоны **авто** угсраа босоо шилжилтийн хязгаарлагчаар тоноглогдсон байна.

12.16. Техникийн үйлчилгээ хийсэн вагон үзэгч автомат угсрааны техникийн бүрэн бүтэн байдал, галт тэрэгний бүрэлдэхүүнд зөв холболт хийсэн эсэхийг хариуцна.

12.17. Вагон үзэгчгүй өртөөнд сэлгээний удирдагч галт тэргэнд вагоныг залгах, найруулах үед зөв холбосон эсэхийг хариуцна.

12.18. Зүтгүүрийг галт тэрэгний эхний вагонтой зөв холбосон эсэхийг зүтгүүрийн машинч хариуцна.

12.19. Галт тэрэгний зүтгүүрийг бүрэлдэхүүнээс салгах ба холбох (тоормосны зөөлөн хоолойг салгах, залгах, төгсгөлийн краныг нээх, хаах) ажлыг машинч, туслах машинч гүйцэтгэнэ.

12.20. Сэлгээний зүтгүүр ба эхний вагон зөв холбогдсон эсэхийг сэлгээний удирдагч хариуцна.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ АРЧЛАЛТ, АЧАА ТЭЭВЭР, ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСВАР

13.1. Хөдөлгөөний аюулгүй **байдалд** хөнөөл учруулж болох гэмтэлтэй хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглалтад оруулах, тээвэрлэж байгаа ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж чадахгүй вагоныг галт тэргэнд холбож явуулахыг хориглоно.

13.2. Халаалт, цахилгаан, тоноглол, агааржуулагч, дохиолох хэрэгсэл гэмтэлтэй буюу зорчигч тээвэрлэх хэвийн нөхцөлийг алдагдуулж болох бусад гэмтэл бүхий зорчигчийн вагоныг галт тэргэнд холбон явуулахыг хориглоно.

13.3. **Харьяалал** болон өмчийн төрөл хэлбэрээс үл хамаарч хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд тавих шаардлага, техникийн үйлчилгээ, засварын журмыг Төрийн захиргааны **төв** байгууллага тогтооно.

13.4. Хөдлөх бүрэлдэхүүний техникийн үйлчилгээ, засварын төрөл, засвар хоорондын **гүйлт болон хугацааны** норм, засварт тавих журмыг Төрийн захиргааны **төв** байгууллага тогтооно. Хөдлөх бүрэлдэхүүний техникийн үйлчилгээ ба засварын технологийн үлгэрчилсэн горимыг суурь бүтэц эзэмшигч батална.

13.5. Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөний аюулгүй **байдал**, хийсэн техникийн үйлчилгээ, засварын чанарыг гардан гүйцэтгэсэн ажилтан, депо, засварын болон техник үйлчилгээний газар, вагоныг тээвэрлэлтэд бэлтгэх газрын мастер, дарга хариуцна.

ЗҮТГҮҮРИЙН ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСВАР

13.6. Зүтгүүрийн техникийн байдлыг ашиглалтын үед зүтгүүрийн бригад, депо болон техник үйлчилгээний газарт засварын төрөлжсөн бригад шалгахаас гадна шаардлагатай засвар үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.

13.7. Зүтгүүрийн техникийн байдлыг ашиглалтын үед зүтгүүрийн бригад, депо болон техник үйлчилгээний газарт засварын төрөлжсөн бригад шалгахаас гадна шаардлагатай засвар үйлчилгээг хийж гүйцэтгэнэ. Зүтгүүр бүрийн засвар хоорондын гүйлтийн болон хугацааны нормыг хатуу мөрдөж төлөвлөгөөт засварын гүйлт, хугацааг хэтрүүлэхгүйгээр төлөвлөгөөт засвар хийж гүйцэтгэнэ. Төлөвлөгөөт засвар дээр илчит тэргийг засварын технологийн дагуу засварлаж, хэрэглэгдэх сэлбэг материалыг бүрэн хэрэглэж, засварын нормоор тогтоосон хугацаанд гаргана.

13.8. Зүтгүүрийн засвар үйлчилгээ хариуцсан нэгжийн мастер, хүлээн авагч, инженер, дарга болон зүтгүүрийн асуудал эрхэлсэн салбарын дарга, байцаагч техникийн үйлчилгээ болон засварын чанарт байнга хяналт тавина.

13.9. Зүтгүүрт засвар, үйлчилгээ хийсний дараа эрх бүхий ажилтан хөдөлгөөнд тэнцэх эсэхийг шалгаагүй, зөвшөөрөөгүй зүтгүүрийг ашиглалтад өгч болохгүй.

13.10. Техникийн үйлчилгээний үед дор дурдсан зүйлийг шалгана.

а. Зангилаа, эд ангийн байдал, элэгдэл нь хөдөлгөөний аюулгүй **байдлыг** хангахуйц тогтоосон хэмжээнд тохирч байгаа эсэх

б. Тоормосны тоноглол, **авто** угсрааны хэрэгсэл, хянах, хэмжих, хамгаалах, дохионы багаж хэрэгслийн ажиллагааны бүрэн бүтэн байдал

13.11. Дор дурдсан гэмтэл бүхий зүтгүүрийг **хөдөлгөөнд ашиглахыг** хориглоно.

а. Авто угсрааны хэрэгсэл гэмтсэн

б. Мал зайлуулагч гэмтсэн буюу байхгүй

в. Элс өгөх систем гэмтэлтэй буюу элсээр зэхэгдээгүй

г. Дуун дохио өгөх **тоноглол** гэмтсэн

д. Тэргэнцрийн пүрш хугарсан буюу гэмтсэн

- е.** Нумын хом, зүүлт, ээмэг, хуудсанд цав гарсан, хугарсан
- ё.** Гүүшингийн холхивч, их бие гэмтсэн буюу цав гарсан
- ж.** Тоормосын хөшүүргэн дамжуулга, түүнийг унахаас хамгаалах хэрэгсэл гэмтсэн буюу байхгүй
- з.** Араат дамжуулгын хайрцаг /тос гоожихоор/, шүд гэмтсэн буюу цав үүссэн
- и.** - Татах цахилгаан хөдөлгүүр, түүнийг хөргөх сэнс, мотор голын холхивч гэмтсэн
- й.** - Зай хураагуур гэмтсэн
- к.** Хурд хэмжигч, машинчийн сонор сэрэмж шалгах төхөөрөмж гэмтсэн
- л.** Зүтгүүрийн радио холбооны төхөөрөмж гэмтсэн
- м.** Хийн шахуурга авто ба гар тоормос гэмтсэн
- н.** Зүтгүүрийн бүтээцэд хийгдсэн гал унтраах хэрэгсэл гэмтсэн
- о.** Дизель хөдөлгүүр цохио чимээ үүссэн, хөргөх секц, сэнс гэмтсэн
- е.** Богино холбооны гүйдлийн реле ба дизелийн ослоос хамгаалах хэрэгсэл гэмтсэн
- р.** Зүтгүүрийн автомат дохиоллын систем гэмтсэн

13.12. Зүтгүүр дээр тавигдсан **хэмжих хэрэгсэл** урьдчилан сэргийлэх хавхлага ломботой байна. **Зүтгүүрийн хянах хэмжих болон** цахилгаан хамгаалалтын хэрэгсэл, урьдчилан сэргийлэх хавхлага, **хийн нөөц** савыг тогтоосон хугацаанд үзэж магадлана.

13.13. Зүтгүүрийн автомат **зогсоогуур, радио** холбооны байгууламжийг хяналтын цэгт тогтмол үзэж, ажиллагааг шалгаж, тохируулж байна. Хяналтын цэгийн байрлал ба үзлэгийн хугацааг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

13.14. Зүтгүүрт жилд хоёр удаа зуны ба өвлийн тээвэрт бэлтгэхэд зориулсан бэлтгэл ажил, комиссын үзлэг хийнэ.

13.15. Зүтгүүрт үйлчилгээ хийх, зүтгүүрийн бригад, сэлгээний илчит тэргийг ганц машинчаар ажиллуулах журмыг суурь бүтэц эзэмшигчийн тушаалаар тогтооно.

13.16. Орон нутгийн нөхцөлийг харгалзан суурь бүтэц эзэмшигч хөдөлгөөний аюулгүй **байдлыг** хангахуйц **зүтгүүрийн** техникийн үйлчилгээ, сэлгээний ажил хийх журмыг тогтооно.

13.17. Асаалттай зүтгүүрийг түүний үйлчилгээний дүрмийн мэдлэгтэй бөгөөд зогсоох чадвартай ажилтны хяналтгүйгээр депогийн зам дээр хөдөлгөх, машинч ба туслахын хяналтгүйгээр өртөөний бусад зам дээр орхихыг хориглоно.

ВАГОНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЗАСВАР

13.18. Вагоны техникийн үйлчилгээ, засварыг тээвэрлэлтэд вагон бэлтгэх газар, техник үйлчилгээний газар, вагон депо болон заводад гүйцэтгэнэ.

13.19. Техникийн үйлчилгээний үед дараах зүйлийг шалгана.

- а.** Зангилаа, эд ангийн байдал ба элэгдэл тогтоосон хэмжээнд тохирч байгаа эсэх
- б.** Тоормосны тоноглол, **авто** угсрааны хэрэгслийн ажиллагаа, бүрэн бүтэн байдал
- в.** Тэвш нь тээвэрлэх ачааны бүрэн байдлыг хангаж чадахуйц **бүрэн** бүтэн эсэх
- г.** Дамжих тавцан, тусгай гишгүүр, бариул **бүрэн** бүтэн эсэх
- д.** Хөдлөх бүрэлдэхүүний эд анги, тоноглол, зам дээр унахаас урьдчилан хамгаалах **хэрэгсэл** бүрэн бүтэн эсэх.

13.20. Вагоныг техникийн үзлэгт оруулж, тэнцэх эсэхийг нь шалгасан тухай тусгай дэвтэрт бичихгүйгээр ачаа ачих, зорчигч тээвэрлэхээр өгөхийг хориглоно.

13.21. Тээвэрлэлтэд вагон бэлтгэх буюу техник үйлчилгээний газаргүй өртөөнд ачилтад өгөх хоосон вагоныг ачих өртөөний ойролцоо байрласан техник үйлчилгээний буюу тээвэрлэлтэд вагон бэлтгэх газарт үзлэгт оруулж тээвэрлэлтэд бэлтгүүлнэ.

13.22. Вагоныг техникийн үзлэгт оруулах, тээвэрлэлтэд тэнцэх тухай мэдэгдэл өгөх журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

13.23. Галт **тэрэгийг найруулах**, задлах өртөөнд, харин замд яваа үед бол галт тэрэгний хөдөлгөөний зурмагт заасан өртөөнд техникийн үзлэгт оруулж байна. Эдгээр өртөөнд вагоны салгалттай ба салгалтгүй урсгал засварын ажлыг зохион байгуулна.

13.24. Тээвэрлэлтэд вагон бэлтгэх буюу техник үйлчилгээний газаргүй өртөөнд вагоныг галт тэргэнд залгахын өмнө вагон үзэгч үзлэг хийж, техник үйлчилгээний газартай ойролцоох өртөөнд явуулахад бэлтгэсэн байна.

13.25. Галт тэргийг техникийн үзлэгт оруулах, бэлэн болсон тухай мэдэгдэх журам, тээвэрлэлтэд вагон бэлтгэх буюу техник үйлчилгээний газаргүй өртөөнд вагоныг ачилтад өгөх, галт тэргэнд холбохын өмнө техникийн үзлэг үйлчилгээ хийх журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

13.26. Тээвэрлэлтэд вагон бэлтгэх буюу техник үйлчилгээний газрын ажилтан вагоны техникийн үйлчилгээ, засварыг технологийн горим, галт тэрэгний хөдөлгөөний зурмагт зохицуулан цаг тухайд **гүйцэтгэж** байна.

13.27. Суурь бүтэц эзэмшигчээс тогтоосон баталгаат хэсгийн хэмжээнд галт тэргэнээс вагон салгахгүй явуулах, хөдөлгөөний аюулгүй **байдлыг** хангах **үйл ажиллагааг** тээвэрлэлтэд вагон бэлтгэх **болон** техник үйлчилгээний **газар** хариуцна.

ГАЛТ ТЭРЭГ БА ВАГОНД АЧАА ТЭЭВРИЙН ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЭХ АВТОМАТ ТӨХӨӨРӨМЖ

13.28. Галт тэрэг ба вагонд ачаа, тээврийн зөрчил илрүүлэх автомат систем, оврын **мэдрэгчтэй** хаалга, вагон жин, **дүрс бичлэг** хяналтын төхөөрөмж зэрэг нь дараах шаардлагыг хангасан байна.

а. Ачилтын техникийн нөхцөл даац хэтрэлтийн зөрчилтэй вагон галт тэргэнд байгаа мэдээллийг ачаа тээврийн үзлэгийн **газрын** операторт дамжуулах.

б. Ачаа тээврийн зөрчлийн тухай мэдээллийг цаасан болон **цахим** хэлбэрээр гаргах, хадгалах.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг

14.1. Хөдөлгөөний зурмаг нь галт тэрэгний хөдөлгөөний зохион байгуулалтын үндэс бөгөөд бүх салбар, нэгжийн үйл ажиллагааг хооронд нь уялдуулан нэгтгэж төмөр замын ажлын хэмжээг тодорхойлно. **Суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн дагуу батална.**

14.2. Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн дагуу галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв батална.

14.3. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг дараах шаардлагыг хангасан байна.

- а.** Зорчигч, ачаа, ачаан тээш тээвэрлэлтийн хэрэгцээг хангах
- б.** Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангах
- в.** Өртөөний боловсруулах болон хэсгийн тээх, нэвтрүүлэх чадварыг үр дүнтэй ашиглах
- г.** Хөдлөх бүрэлдэхүүнийг оновчтой, үр бүтээлтэй ашиглах
- д.** Зүтгүүрийн бригадын тасралтгүй ажиллах тогтоосон цагийг нарийн мөрдөх
- е.** Зам, хиймэл төхөөрөмж, ДТХ, холбооны болон цахилгаан эрчим хүчний байгууламжид засвар, үйлчилгээ хийх боломжийг олгох.

14.4. Зорчигчийн галт тэрэгний цагийн хуваарийг бүх нийтийн сонорт зарлан мэдэгдэнэ. Галт тэрэгний хөдөлгөөнд шууд холбоотой ажилтныг галт тэрэгний хөдөлгөөний цагийн хуваариар хангана.

14.5. Галт тэрэгний хөдөлгөөний цагийн хуваарийг товлох, цуцлахыг дараах байгууллага, албан тушаалтан гүйцэтгэнэ.

а. Олон улсын харилцааны зорчигчийн галт тэргийг хөрш орнуудын төмөр замын удирдах байгууллагатай зөвшилцсөнөөр

б. Орон нутгийн ба хот, дүүргийн зорчигчийн галт тэрэг, тээшийн галт тэрэг, ачаа-зорчигчийн галт тэргийг суурь бүтэц эзэмшигч

в. Ачааны хурдасгасан ба ачааны галт тэргийг суурь бүтэц эзэмшигчээс эрх олгосон этгээд

г. Цэргийн галт тэргийг Төрийн захиргааны төв болон эрх бүхий байгууллагын зөвшилцөж баталсан журмаар

д. Сэргээн босгох, галын галт тэрэг, цас цэвэрлэгч, вагонгүй зүтгүүр, замаас авагддаггүй дрезин, аж ахуйн галт тэрэг болон хөдөлгөөний зурмагт тусгагдаагүй бусад галт тэрэгний явах журмыг галт тэрэгний хөдөлгөөний ахлах зохицуулагч

14.6. Галт тэрэг бүрд зурмагаар тогтоосон дугаар олгоно. Нэг чиглэлийн галт тэргүүдэд тэгш дугаар, эсрэг чиглэлийн галт тэргүүдэд сондгой дугаар олгоно.

14.7. Галт тэргэнд дараах дэс дараалал тогтооно:

а. Дараалал харгалзахгүй галт тэрэг

- Хөдөлгөөнийг хэвийн болгон сэргээх, гал түймэр унтраахад зориулан товлосон сэргээн босгох, галын галт тэрэг, цас цэвэрлэгч, вагонгүй ганц зүтгүүр, замаас авагддаггүй дрезин, автоматрис хамаарна.

б. Дараалал баримтлах галт тэрэг

- Бүх төрлийн зорчигчийн

- Цэргийн, ачаа-зорчигчийн, тээшийн болон чингэлгийн галт тэрэг, ачааны хурдасгасан (хялбар гэмтэх ачаа, суурь бүтэц эзэмшигчээс мал, амьтан тээвэрлэхэд зориулсан)

- Ачааны (нэвт өнгөрөх, хэсгийн түүвэр, зөөврийн, дамжуулах ба аж ахуйн галт тэрэг, вагонгүй зүтгүүр)

в. Онцгой шаардлагаар товлдог, тэр үедээ ээлж дарааллыг нь тогтоодог галт тэрэг

14.8. Галт тэрэгний хөдөлгөөнийг хоногийн 24 цагийн тооллоор Улаанбаатарын цагийг баримтлан зохицуулна. Төмөр замын нийт сүлжээний хэмжээнд цагийн заалт адил байна.

14.9. Хөдөлгөөнтэй шууд холбоотой ажлын байр болон галт тэрэгний буудлын гадна, дотор талд зорчигчдод зориулан технологийн зориулалттай цаг байрлуулна. Түүнийг ашиглах, засвар үйлчилгээ хийх асуудлыг суурь бүтэц эзэмшигчийн баталсан журмаар тогтооно.

14.10. Суурь бүтэц эзэмшигч тээврийг оновчтой зохион байгуулахын тулд хоногийн төлөвлөгөөт зурмагийг зохиож мөрдөнө. Хоногийн төлөвлөгөөт зурмаг зохиож, баталж мөрдөх журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

ХЭСЭГЛЭХ ГАЗАР

15.1. Галт тэрэгний хөдөлгөөнийг хэсэглэх газраар зохицуулна. Хэсэглэх газарт өртөө, зөрлөг, замын пост хамаарна. Хэсэглэх газрыг барьж байгуулан хөдөлгөөнийг хэсэгчлэн зааг гаргаж галт тэрэгний хөдөлгөөнийг явуулна. Галт тэрэгний хөдөлгөөнийг хэсэглэх газраар зааглаж зохион байгуулна.

15.2. Оруулах **гэрлэн** дохио, **оруулах семафор** нь өртөөний зааг мөн.

15.3. Хэсэглэх газар, зорчигчийн буух, суух газар нь өөрийн оноосон нэртэй буюу дугаартай байна. Нэрийг өртөөний болон зорчигчийн байшин (постын барилга)-гийн нүүрэнд, галт тэрэг ирэх хоёр талд тус тус байрлуулсан байна.

15.4. Замыг хоорондын гол зам, галт тэрэг хүлээж авах, явуулах, ялгах, сэлгээний ажил гүйцэтгэх, ачаа, ачаан тээш хүлээн авах, олгох, зорчигчдод үйлчлэх зориулалт бүхий өртөөний зам, нийтэд үйлчлэх зориулалттай нийтийн хэрэгцээний салбар зам, дагнасан хэрэглээний **салбар** зам гэж тус тус ангилна.

15.5. Өртөөний зам, суман шилжүүлэг, өртөөний төвлөрүүлэлтийн байр, сумчны байр бүр өөрийн дугаартай байна.

15.6. Нэг парктай өртөөний дэвсгэрт байгаа зам, суман шилжүүлэг, байрт адил дугаар тогтоохыг хориглоно. Хэд хэдэн тусгай парк бүхий өртөөнд нэг паркийн замууд адил дугаартай байж болохгүй.

15.7. Өртөөний зам, суман шилжүүлгийг дугаарлах аргыг **суурь бүтэц эзэмшигч** тогтооно.

АРВАН ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ӨРТӨӨНИЙ АЖЛЫН **ТЕХНИК** ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Ерөнхий шаардлага

16.1. Өртөөний **байгууламж, төхөөрөмжийг** ашиглах аргыг техник захирамжийн актаар тогтооно. Өртөөнд галт тэргийг осол аюулгүй, саадгүй хүлээн авах, явуулах, өнгөрүүлэх, сэлгээний ажлын ба хөдөлмөрийн аюулгүй **байдал, эрүүл ахуйн шаардлагыг** хангаж байхаар техник захирамжийн актыг зохионо.

16.2. Техник захирамжийн актыг төмөр замын **байгууллагын бүх ажилтан** (галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой) заавал биелүүлнэ.

16.3. Өртөөний дарга нь тухайн техник захирамжийн актыг төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, техник захирамжийн акт зохиох журам, суурь бүтэц эзэмшигчийн баталсан бусад заавар, журмыг үндэслэн холбогдох нэгжийн саналыг авч боловсруулна.

16.4. Техник захирамжийн актад өртөөний масштабчилсан бүдүүвч, замын хэвгий, галт тэрэг хүлээн авах, явуулах, сэлгээний ажил хийх, дохиолол төвлөрүүлэлт хориглолын ба холбооны байгууламжийг ашиглах, ялгах дов дээр ажиллах, салбар замыг үйлчлэх журам, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм, салбар замын хүснэгтийг хавсаргана.

16.5. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг, өртөөний замын ба дохиолол төвлөрүүлэлт хориглол, холбооны байгууламжид нэмэлт, өөрчлөлт оруулсан тухай бүрд техник захирамжийн актыг шинэчлэх буюу засварлаж байна.

16.6. Техник захирамжийн актан нэмэлт, өөрчлөлт оруулахдаа техник захирамжийн актыг баталсан албан тушаалтнаар баталгаажуулна.

16.7. Өртөөний дарга гарын үсэг зурж баталсан техник захирамжийн актын хуулбарыг өртөөний жижүүр, сэлгээний **хөдөлгөөн зохицуулагч**, паркийн ба ялгах довын жижүүр, төвлөрүүлэлтийн гүйцэтгэх байр, сумчны байр, зүтгүүрийн депогийн жижүүр, вагон үзэгчийн ажлын байранд байлгана.

Хуулбарт зохих ажилтанд шаардагдах мэдээ баримтыг тусгасан байна.

Өртөөний техник захирамжийн актыг зохиох заавар, **түүний маягт нь стандартын шаардлагад** нийцсэн байна. **(ТЗА-д тавигдах ерөнхий шаардлагыг стандартаар, суурь бүтэц эзэмшигч нар тухайн төмөр замын ТЗА-ыг боловсруулж баталж мөрдөнө)**

СУМАН ШИЛЖҮҮЛГИЙН АШИГЛАЛТ

16.8. Гол болон хүлээн авах, явуулах зам дээр байрласан сум, хамгаалах сум хэвийн байдалд тавигдсан байна.

Сумны хэвийн байдал:

- Нэг замт шугамын өртөөний гол зам дээрх оруулах сумууд өртөөний хоёр талаас өөр өөр замд оруулахаар тавигдсан байна.

- Хоёр замт шугамын өртөөний гол зам дахь оруулах сумууд зохих гол замаар оруулахаар тавигдсан байна.

- Хамгаалах ба барих мухар зам руу оруулах **сумаас** бусад, хоорондын зам ба өртөөний гол зам дээрх бүх сум зохих замаар явуулахаар тавигдсан байна.

- Хамгаалах ба барих мухар зам руу оруулах сум нь мухар зам руу оруулахаар тавигдсан байна.

Суман шилжүүлэг хэвийн байдлыг сум, дохио, замналын харилцан хамаарлын хүснэгтэд нэмэх тэмдгээр заана. Төвлөрүүлээгүй сумтай өртөөнд тэдгээрийн хэвийн байдлыг өртөөний техник захирамжийн акт болон түүний хуулбарт заана.

Сэргээн босгох, галын галт тэрэг, тэсрэх дэлбэрэх ачаатай вагон зогсооход зориулан гаргасан өртөөний зам руу оруулах замналын хамааралд ороогүй суман шилжүүлэг хэвийн байдлыг өртөөний дарга тогтооно.

Тогтоосон хэвийн байдлыг цахилгаан төвлөрүүлэлтийн сумнуудын цахилгаан шилжүүлэгчийн таган дээр болон төвлөрүүлэгдээгүй суман шилжүүлгийн, шилжүүлэгчийн суурин дээр тэмдэглэнэ. Дор дурдсан үед сумнуудыг өөр байдалд шилжүүлж болно.

- Галт тэрэг хүлээн авах, явуулах замнал бэлтгэхэд

- Сэлгээний ажил хийх үед
 - Замыг хөдлөх бүрэлдэхүүнээр эзлүүлэх үед
 - Саадтай газар ба өртөөний зам дээр ажил хийх газрыг хааж хамгаалах шаардлагатай үед
 - Сум цэвэрлэх, шалгах, засварлах үед
- Цахилгаан төвлөрүүлэлтээр тоноглогдсон өртөөнд доорх сумуудаас бусад сумыг хэвийн байдалд тавих шаардлагагүй болно. Үүнд:
- Хамгаалах ба барих мухар зам руу орох сум
 - Автомат төхөөрөмжөөр тоноглогдож хэвийн байдалдаа өөрөө шилждэг хаягч сум
 - Автомат төхөөрөмжөөр тоноглогдоогүй боловч өртөөний жижүүр хэвийн байдалд нь шилжүүлдэг хаягч сум

16.9. Хоорондын замд тавигдсан суман шилжүүлгийг аль нэгэн зэргэлдээ өртөөнд харьяалуулах буюу салаалсан газарт нь шаардлагатай үед пост байгуулна. Эдгээр суман шилжүүлгэнд техникийн үйлчилгээ хийх, гэрэлтүүлэх, хамгаалах, сумны түлхүүр хадгалах журмыг суурь бүтэц эзэмшигчийн тушаалаар тогтооно.

16.10. Сум дохиог удирдах байранд өөрийн удирдаж байгаа сум дохионы шилжүүлэлт, хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хариуцсан зөвхөн нэг ажилтан байна. Тухайлбал: өртөөний төвлөрүүлэлтийн байранд өртөөний жижүүр, сумчны байранд сумчин, механикжуулсан ялгах довын төвлөрүүлэлтийн байранд оператор, довын жижүүр буюу сэлгээний зохицуулагч.

Зарим өртөөнд сумчны хоёр байрыг нэг сумчинд, мөн зарим сум ба сумчны байрыг өртөөний жижүүрт шууд хариуцуулж болно. Ийм өртөөдийн жагсаалтыг суурь бүтэц эзэмшигчийн тушаалаар тогтооно.

16.11. Өртөөний төвлөрүүлэлтийн байранд шаардлагатай үед оператор буюу туслах жижүүрийг томилон ажиллуулж болно.

16.12. Галт тэрэг хүлээн авах, явуулахын өмнө уул хүлээн авах, явуулах замналд орсон сум, хамгаалалтын сумнуудыг түгжээтэй байлгана.

16.13. Галт тэрэг хүлээн авах, явуулах замналд түгжигдсэн боловч түлхүүрийн хамаарлаар тоноглогдоогүй сумны түлхүүр өртөөний жижүүр буюу сумчинд, харин түлхүүрийн хамаарлаар тоноглогдсон үед сумчны байрны гүйцэтгэх аппарат буюу өртөөний жижүүрийн удирдлагын аппаратад хадгалагдана.

16.14. Түлхүүрийн хамаарлаар тоноглогдоогүй, хамгийн хариуцлагатай бөгөөд түгжээтэй дараах суман шилжүүлэг түлхүүр нь өртөөний жижүүрт хадгалагдана.

- а. Сэргээн босгох, галын галт тэрэг зогсоох зам руу оруулах сум
- б. Өртөө, хоорондын замд нийлсэн постоор үйлчлүүлэгдээгүй салбар замын сум
- в. Барих ба хамгаалах мухар замын болон хаях сум
- г. Аюултай ачаатай вагон зогсоох зориулалттай зам руу оруулах түгждэг сум

д/ Түлхүүрийн хамаарлаар тоноглогдсон боловч тухайн нөхцөлд зүүдэг цоожоор цоожилсон байвал зохих сум.

е/ Нэг буюу бүлэг вагонд эзлүүлсэн өртөөний хүлээн авах явуулах замуудын сум.

16.15. Хэсэглэх газарт галт тэрэг хүлээн авах, явуулах, замнал бэлтгэх, түгжих, сэлгээний ажлын үед сумыг замналд **шилжүүлэхийг өртөөний** техник захирамжийн актад зааснаар гүйцэтгэнэ.

16.16. Галт тэрэг хүлээн авах, явуулах замнал бэлтгэх үед төвлөрүүлсэн сумыг өртөөний жижүүр шилжүүлнэ. Галт тэрэг хүлээн авах, явуулах үед төвлөрүүлээгүй сумыг өртөөний жижүүрийн **захирамжаар** сумчин эсвэл сумыг хариуцдаг өртөөний **ажилтан** шилжүүлж түгжинэ. Замнал бэлтгэх үед өөр бусад **хүмүүс** сум шилжүүлэхийг хориглоно. Сэлгээний хөдөлгөөний үед сум шилжүүлэх **үйлдлийг** сэлгээний ажил удирдагчийн захирамжаар сумчин гүйцэтгэнэ. Цахилгаан төвлөрүүлэлтээр тоноглогдсон өртөөдөд сэлгээний хөдөлгөөний үед сум шилжүүлэх явдлыг өртөөний жижүүр гүйцэтгэнэ. Сумыг төвийн удирдлагаас орон нутгийн удирдлагад шилжүүлэх, мөн түүнчлэн сумчид үйлчилдэггүй, төвлөрүүлэгдээгүй суман дээгүүр сэлгээ хийх үед сумуудыг зөвхөн найруулагчийн бригад шилжүүлнэ.

16.17. Сум шилжүүлэх, замнал бэлтгэх тухай өртөөний жижүүрийн захирамжийг сумчин зөв ойлгосноо давтана.

Захирамжийг биелүүлмэгц сумчин энэ тухайгаа уг захирамж өгсөн ажилтанд нэн даруй илтгэнэ. Өгөгдсөн замналд орсон сумны байдлыг хянах боломж олгодог удирдлагын аппарат бүхий өртөөнд өртөөний жижүүр түүний захирамжийг зөв биелүүлсэн эсэхийг удирдлагын хэрэгслийн заалтаар магадлана.

16.18. Сум гэмтэлтэй (шор нягт шахагдаагүй, цоож цуурга гэмтсэн) үед сумчин өртөөний жижүүрт нэн даруй мэдэгдэнэ. Гэмтэл нь хөдөлгөөний аюулгүй ажиллагаанд хохирол учруулахаар байвал сумчин тэр сумаар өнгөрөх хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг зогсоож, зогсох дохиогоор хааж хамгаалан, энэ тухайгаа өртөөний жижүүрт **нэн даруй** мэдэгдэнэ.

16.19. Суман шилжүүлэг дээр засварын ажил хийх шаардлага гарсан үед сумчин зөвхөн өртөөний жижүүрийн зөвшөөрлөөр **зам, дохиолол холбооны нэгжийн** ажилтныг засварын ажилд оруулж болно.

Засвар дуусмагц сумчин уул суман шилжүүлгийн байдал хөдөлгөөний аюулгүй **байдлыг** хангасан эсэхийг магадлаж энэ тухайгаа өртөөний жижүүрт илтгэнэ.

16.20. Өртөөний болон бусад байгууллагын эзэмшлийн замд нийлсэн суман шилжүүлэг өртөөний даргын мэдэлд байна.

16.21. Бусад байгууллагын эзэмшлийн замын суман шилжүүлэг тухайн эзэмшигчийн мэдэлд байна.

16.22. Өртөөний болон байгууллагын дарга нь өөрийн эзэмшилд байгаа суман шилжүүлгийн хэвийн ажиллагаа, цэвэрлэгээ, сум заагчийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

16.23. Суман шилжүүлгийн техникийн байдалд хяналт тавих, цэвэрлэх, үйлчилгээ хийх ажлыг дараах ажилтан гүйцэтгэнэ:

а. Төвлөрүүлэгдээгүй суман шилжүүлгийг тэдгээрийг үйлчилдэг сумчид (өртөөний ажилчид)

б. Төвлөрүүлэгдсэн суман шилжүүлгийг замын аж ахуйн нэгжийн ажилтан

16.24. Төвлөрүүлэгдсэн, сумчны мэдэлд байдаггүй төвлөрүүлэгдээгүй зарим суман шилжүүлгийн техникийн байдлыг хянах, үйлчилгээ хийх журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

16.25. Сумчны гүйцэтгэх үүрэг:

а. Жижүүр хүлээн авахдаа зам дээрх вагон хязгаарын шонгоос гадагш гараагүй, сум цэвэрлэгдсэн бүрэн бүтэн, сумчны дохионы хэрэгсэл, багаж бүрэн **эсэхийг** жижүүр хүлээлгэн өгч байгаа сумчныг байлцуулан магадлах.

б. Сумыг техник захирамжийн актын хуулбарт заасан хэвийн байдалд түгжээтэй байлгах, галт тэрэг хүлээн авах, явуулах, өнгөрүүлэх үед зөвхөн өртөөний жижүүрийн захирамжаар заасан байдалд шилжүүлж байх.

в. Суман шилжүүлгийн бүрэн бүтэн байдал, тасралтгүй ажиллагааг хангаж, цэвэр байлгаж, суларсан эрэг, шургийг сайтар чангалж тосолж, хадаасыг гүйцэд хадаж байх. Сум тоонолжийг цэвэрлэх, эрэг, шураг, хадаас чангалах ажлыг шорын өмнөх жааз зам төмрийн уулзвараас (хашилт зам төмрийг оруулан) **тоонолжийн** арын уулзвар хүртэл гүйцэтгэнэ.

г. Техник захирамжийн актанд зааснаар гэрэлтүүлэгтэй байлгах сум заагчийг шөнийн цагт мөн үзэгдэлт муутай өдрийн цагт гэрэлтүүлж байх.

д. Галт тэрэг хүлээн авах, явуулах үед өртөөний техник захирамжийн актын хуулбарт заасан газар зохих дохиотой угтаж авах.

е. Галт тэрэг өнгөрөх үед бүрэн бүрэлдэхүүнтэй, тогтоосон дохиотой явж байгаа эсэхийг анхааралтай ажиглаж, үдэж өгөх.

ё. Илрүүлсэн гэмтэл, хэвийн биш зүйлийн тухай өртөөний жижүүрт нэн даруй мэдэгдэх бөгөөд харин хөдөлгөөний аюулгүй **байдал** болон хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахаар байвал галт тэрэг, сэлгээний бүрэлдэхүүнийг зогсоох арга хэмжээг яаралтай авах.

ж. Сэлгээ хийх үед дохиог анхааралтай ажиглаж, сэлгээний ажлыг түргэн, осол, аюулгүй хийх, дохионы заалтыг чанд биелүүлэх.

з. Сумчны байранд байрлуулсан техник захирамжийн актын хуулбарын заалтыг мэдэж, баримталж ажиллах.

16.26. Сумчинд дараах зүйлийг хатуу хориглоно:

а. Өртөөний техник захирамжийн актанд заасан гэрэлтэй байвал зохих сум заагчуудыг шөнийн цагт болон үзэгдэлт муутай өдрийн цаг гэрэлтүүлэггүй байлгах.

б. Ажлын шаардлага гараагүй нөхцөлд сумны хэвийн байдлыг алдагдуулах.

- в. Өртөөний техник захирамжийн актанд заасан түгжээтэй байвал зохих сумыг түгжээгүй байлгах.
- г. Ажлын байранд тогтоосон дохиогүй байх
- д. Жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ өртөөний жижүүрийн зөвшөөрөлгүйгээр ажлын байраа орхиж явах.
- е. Суманд **гадны** хүн хүргэх

СЭЛГЭЭНИЙ АЖИЛ

16.27. Өртөөний замд сэлгээний ажлыг зөвхөн нэг ажилтны, тухайлбал, өртөөний жижүүр, сэлгээний зохицуулагч паркийн буюу постын жижүүрийн захирамжаар гүйцэтгэнэ.

16.28. Сэлгээний ажлыг гүйцэтгэх, энэ талаар захирамж өгөх ажил үүргийн хуваарилалтыг өртөөний техник захирамжийн актаар тогтооно.

16.29. Өртөөний болон ялгах довд сэлгээ хийх, сэлгээний хурд, хөдлөх бүрэлдэхүүн бэхлэх, онцгой нөхцөлд тээвэрлэх ачаатай вагоныг сэлгэх талаар “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”-д тодорхой тусгасан байна.

16.30. Сэлгээ хийж байгаа зүтгүүрийн хөдөлгөөнийг зөвхөн нэг ажилтан буюу галт тэрэгний найруулагч удирдана. Найруулагчийн хяналтын дор туслах найруулагч сэлгээний хөдөлгөөнийг удирдаж болно.

16.31. Галт тэрэгний найруулагчийн үүрэг:

а. Энэ дүрэм, галт тэрэг найруулах төлөвлөгөө, бусад дүрэм, журмын шаардлагад нийцүүлэн галт тэргийг найруулах.

б. Хийх сэлгээний ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэх аргыг сэлгээний ажилд оролцогч бүх ажилтанд танилцуулсны үндсэн дээр тэдгээрийн үйл ажиллагааг оновчтой зохицуулан хуваарилах.

в. Сэлгээний ажлын даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх.

г. Сэлгээний ажил гүйцэтгэж буй ажилтны болон хөдөлгөөний аюулгүй байдал, ачаа ба хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн байдлыг хангасан байхаар сэлгээний ажлыг зохион байгуулна. Хүн суулгасан, хэтрүү овортой болон тэсрэх ачаатай вагонтай үед сэлгээг маш болгоомжтой гүйцэтгэнэ.

16.32. Олон замтай, сэлгээний ажил ихтэй өртөөнд замуудыг сэлгээний бүс болгон хувааж, тэдэнд сэлгээний зүтгүүр ба бригад бэхлэн ажиллуулна. Завсрын өртөөнд сэлгээний ажлыг “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”-д заасны дагуу гүйцэтгэнэ.

16.33. Сэлгээ хийх үеийн зүтгүүрийн бригадын үүрэг:

а. Сэлгээний ажлын даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх .

б. Өгөгдөж байгаа дохиог анхааралтай ажиглаж, хөдөлгөөний тухай дохионы заалтыг тухай бүр биелүүлэх.

в. Зам дээр байгаа хүмүүс, сумны байдал, хөдлөх бүрэлдэхүүний байрлалыг анхааралтай ажиглах, сонор сэрэмжтэй байх.

г. Сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах

д. Сэлгээний хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн байдлыг хянах

е. Сэлгээний ажлын үед дан зүтгүүрээр хөдөлгөөн хийх тохиолдолд явах чиглэлд зүтгүүрийн удирдлагыг шилжүүлж, **бүхээгийг** заавал сольж байна.

ё. **Зогсох дохио гэнэт өгөгдөх буюу саад гэнэт тохиолдох үед яаралтай тоормослох бүх арга хэрэгслийг ашиглан сэлгээний бүрэлдэхүүнийг тухайн газарт тогтоосон тоормосны замаас илүүгүй зайд зогсооно.**

ГАЛТ ТЭРЭГ НАЙРУУЛАХ

16.34. Галт тэргийг энэхүү дүрэм, хөдөлгөөний зурмаг, галт тэрэг найруулах төлөвлөгөөнд бүрэн нийцүүлэн найруулна.

16.35. Галт тэрэгний жин, уртын нормыг чиглэл, хэсэглэл тус бүрд хөдөлгөөний зурмаг, галт тэрэг найруулах төлөвлөгөөгөөр тогтооно. Мөн жин, уртын норм нь зүтгүүрийн төрөл, тухайн хэсгийн замын аяс, өртөөний хүлээн авах явуулах замын ашигтай уртад тохирч байна.

16.36. Галт тэргэнд хөдлөх бүрэлдэхүүн холбох үед **түүний жин, уртыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.** Галт тэрэгний уртыг тодорхойлоход **томьёолсон** вагоны уртыг **14 метрээр тооцно.**

16.37. Галт тэрэгний урт нь тухайн галт тэрэг аялах **хэсгийн өртөө**, зөрлөгийн хүлээн авах, явуулах замын ашигтай уртаас хэтрэх ёсгүй. Хэсгээр урт бүрэлдэхүүнтэй, хүнд жинтэй галт тэрэг өнгөрүүлэх журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

16.38. Доорх вагонуудыг галт тэргэнд холбохыг хориглоно.

а. Техникийн хувьд хөдөлгөөний аюулгүй **байдал**, ачааны бүрэн бүтэн байдалд хохирол учруулахаар гэмтэлтэй, галт тэрэгнээс салгах мэдэгдэл өгсөн вагон

б. Даацаас хэтэрсэн ачаатай вагон

в. Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачаа ачих, бэхлэх техникийн **нөхцөлийг зөрчиж ачсан**

г. Ачаа хазгай ачсан, нум хэт сууснаас арал ба тэвш нь явах ангидаа **хавирах нөхцөл үүссэн**, дээврийн бүрээс хуурч болохоор гэмтэлтэй.

д. Замаас гарч байсан буюу сүйрэл, осолд орсон галт тэргэнд байсан вагоныг үзлэг хийж, хөдөлгөөнд тэнцэх эсэхийг тогтоох хүртэл,

е. Тусгай баримт бичигтэй яваа (өөрийн гол дээр явах ачааны адил) вагоноос бусад тогтоосон төрлийн засвар хийсэн тухай хэв тэмдэггүй вагон

ё. Хэрхэн явуулах тухай тусгай заалт өгөгдөөгүй, хэтрүү овортой ачаа ачсан тавцант вагон, транспортер, хагас вагон.

ж. Тусгай зааварт зааснаас бусад үед хашлага нь хаагдаж түгжигдээгүй тавцант вагон, хаалга нээлхийг хааж түгжээгүй битүү хоосон вагон, ачих буулгах дээд, доод хэрэгслийн нээлхийн таг онгорхой цистерн, хоппер, үр тариа ба цемент тээвэрлэх вагон, бусад хөдлөх бүрэлдэхүүн.

з. Онгорхой хаалга нээлхийтэй буюу түгжих механизм гэмтсэн, нэг дэх шүдэнд тээглүүлж хаасан хагас вагон

и. Тухайн вагонд ачихыг хориглосон ачаатай

к. Бункерийг нь бэхлээгүй бункерт хагас вагон, хос дугуйн өнхрөх гадаргууг хар тосноос цэвэрлээгүй хар тос тээвэрлэх вагон

16.39. Дор дурдсан вагоныг зорчигчийн галт тэргэнд холбохыг хориглоно.

а. Тэсрэх ачаатай, шахсан, шингэрүүлсэн хийтэй болон бусад аюултай ачаатай, хялбархан шатдаг болон муухай үнэр гаргадаг ачаатай вагон

б. Үечилсэн засвар буюу техникийн нэгдсэн байцаалтын хугацаа хэтэрсэн

16.40. Онцгой шаардлагатай үед тавцант вагон, цистернээс өөр төрлийн ачааны вагоныг зорчигчийн (зорчигчийн хурдан галт тэрэгнээс бусад) галт тэргэнд холбох явдлыг суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

Зорчигчийн галт тэргэнд залгах ачааны вагоны тоо нь 4 голоос хэтрэх ёсгүй бөгөөд зөвхөн галт тэрэгний эхэнд тавина. Хот дүүргийн зорчигчийн галт тэргэнд 12 голоос илүүгүй тооны ачааны вагон (мөн сүүний цистерн) залгахыг зөвшөөрнө.

Холбож байгаа ачааны вагоны техникийн байдал ба бүтэц нь зорчигчийн галт тэрэгний тогтоосон хурдтай, осол аюулгүй явах нөхцөлийг хангасан байна.

16.41. Ачаа-зорчигчийн галт тэргэнд вагонуудыг тогтоосон журмаар байрлуулах бөгөөд зорчигчийн вагоныг эхэнд нь холбоно.

16.42. Ачаа-зорчигчийн галт тэрэгний урт ба жинг суурь бүтэц эзэмшигчийн тушаалаар тогтооно. Ачаа-зорчигчийн галт тэргэнд тэсрэх ачаатай, шахсан, шингэрүүлсэн хийтэй, бусад аюултай болон муухай үнэр гаргах ачаатай вагон, шингэрүүлсэн хийнээс суларсан хоосон цистерн холбохыг хориглоно.

16.43. Зорчигчийн бүх галт тэрэгний эхний ба сүүлийн вагоны голын гадна хаалгыг түгжиж цоожилон, дамжих тавцанг босгож бүх вагоны хажуу хаалгуудыг цоожилсон байна.

16.44. Ачааны галт тэргийг найруулахад вагоныг голын тоо ба жингийн хувьд ялгахгүйгээр найруулна. Түүвэр галт тэргэнд вагоныг очих өртөөгөөр нь бүлэглэн холбох бөгөөд харин түүвэр-түгээх вагоныг нэг бүлэг болгон тавина.

16.45. Албан хэрэгцээний болон ачаа хүргэгчтэй вагоноос бусад хүн суулгасан зорчигчийн ба ачааны вагоныг галт тэргэнд нэг бүлэг болгон холбоно. Харин эдгээр вагонууд нь огцом түлхэх, зогсоход гулсаж болох зам төмөр, дам нуруу, гуалин үүнтэй төстэй бусад төрлийн ачаатай задгай хөдлөх бүрэлдэхүүн, зүтгүүр, галт тэрэгний сүүлээс нэгээс доошгүй вагоноор халхлагдсан байна.

16.46. Цэргийн галт тэргэнд тэсрэх ачаатай вагон холбохыг Аюултай ачаа тээвэрлэх журам, Төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон тусгай журмаар зохицуулна.

16.47. Тэсрэх ачаатай вагон шингэрүүлсэн хийтэй цистерн зарим аюултай ачаа бүхий битүү вагон, амархан шатах ачаатай вагон шингэрүүлсэн хийнээс суларсан хоосон цистернийг галт тэргэнд холбох үед дараах халхавч хийнэ.

а. Галт тэрэгний зүтгүүрийн ард 4-өөс доошгүй голоор

б. Тэсрэх аюултай ачаа бүхий вагоныг галт тэрэгний сүүлээс 4-өөс доошгүй голын өмнө.

Ачааны галт тэргэн дэх хүн суулгасан вагон дараах халхавчтай байна.

а. Тэсрэх аюултай ачаатай вагоноос, мөн түүнчлэн шингэрүүлсэн хийнээс суларсан хоосон цистернээс 12-оос доошгүй голоор.

б. Хүчил, нэгдүгээр зэргийн хялбархан гал авалцах шингэн, зарим бусад аюултай ачаатай цистерн, аюултай ачаа бүхий битүү вагон болон хялбархан шатдаг ачаатай вагоноос 4-өөс доошгүй голоор.

Ачаа хүргэгчтэй (багтай) ганц вагон зөвхөн пийшинтэй бол уул вагон зохих халхавчтай байна.

16.48. Зорчигчийн, хүмүүс суулгасан ба ачааны вагон, тэсрэх аюултай, хялбархан шатдаг ачаатай вагон, шингэрүүлсэн хийнээс суларсан хоосон цистернийг галт тэргэнд холбох, салгах сэлгээний ажлын үед жирийн ачаатай вагон эсвэл хоосон вагоныг халхавч болгон ашиглана.

16.49. Галт тэргэнд залгах, сэлгээ хийх үед халхавч шаардах тэсрэх аюултай, хялбархан шатдаг ачаа болон “аюултай ачааны жагсаалт”-д орсон ачаатай вагон, хэтрүү овортой ачаа бүхий вагон, тусгай хөдлөх бүрэлдэхүүнийг галт тэргэнд байрлуулахыг суурь бүтэц эзэмшигчийн баталсан журмаар зохицуулна.

16.50. Гар тоормостой вагоныг түүвэр, хүмүүсийн, тэсрэх аюултай, хэтрүү овор бүхий ачаатай галт тэргэнд байрлуулахад галт тэрэгний эхний хэсэгт (голын тоогоор) нэгээс доошгүй, харин сүүлчийн хэсэгт гар тоормостой хоёроос доошгүй вагон тавьсан байна.

16.51. Шаардлагатай үед ачааны галт тэргэнд сүүлчийн автомат тоормостой вагоны араас бүрэлдэхүүний дунд хэсэгт явахад тохирохгүй боловч явах анги, авто угсраа нь бүрэн бүтэн дөрвөөс илүүгүй голтой албаны вагон, тоормосгүй вагон тавихыг зөвшөөрнө. Тийм вагоныг вагоны мэргэжлийн ажилтан дагалдан хүргэнэ.

ГАЛТ ТЭРЭГНИЙ ТООРМОС ЗАЛГАХ ТУХАЙ

16.52. Галт тэрэг бүрт байх тоормосны хангамж нь галт тэрэгний жин, хурд, хэсгийн хэмжээний баримтлах уруудуурт тохирч байна.

16.53. Хэсгийн хэмжээгээр баримтлах хэвгий, галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тогтоосон хурдыг тус бүр суурь бүтэц эзэмшигчийн тушаалаар тогтоож мөрдөнө.

16.54. Зорчигчийн галт тэрэгний автомат тоормосны сүлжээнд зорчигчийн маягийн бүх вагон, мөн түүнчлэн зорчигчийн дэглэмээр тоормослох ачааны маягийн автомат тоормос бүхий вагонуудыг холбоно.

16.55. Ачааны галт тэрэгний автомат тоормосны сүлжээнд дараах вагоноос бусад ачааны маягийн автомат тоормостой бүх вагоны тоормосыг залгавал зохино.

а. Хос дугуйд 0,5-1,0 мм чирэгтэй.

- б. Нэг загварын биш тоормостой.
- в. Автомат тоормос нь гэмтсэний улмаас засварт явуулж байгаа
- г. Аюултай ачаа ачсан тоормосын ширмэн шахавчтай вагон
- д. Замд явах үед нь автомат тоормосыг салгах шаардлагатайгаар гэмтсэн.

16.56. Ачааны, ачаа зорчигчийн галт тэргэнд ачааны болон зорчигчийн маягийн автомат тоормосыг хослуулан хэрэглэж болно.

16.57. Бүх төрлийн галт тэрэгний зүтгүүрийн автомат тоормосыг тоормосын сүлжээнд залгасан байна. Зүтгүүрийн автомат тоормос ачааны болон зорчигчийн дэглэмтэй байвал бүрэлдэхүүнд байгаа автомат тоормосны зонхилох маягт тохирох дэглэмд шилжүүлэн залгана.

16.58. Ачааны галт тэргэнд нэг бүлэг болгон тавьсан нэвт дамжуулах хоолойтой буюу салгагдсан тоормостой вагоны тоо 8 голоос, харин галт тэрэгний сүүлд автомат тоормостой сүүлчийн хоёр вагоны өмнө 4 голоос тус тус хэтрэхгүй байна. Галт тэрэгний сүүлд байгаа хоёр вагоны автомат тоормос нь ажилтай байна.

16.59. Ачааны болон ачаа зорчигчийн галт тэрэгний автомат тоормос эвдэрсний улмаас хоорондын замд зогсвол түүнийг байранд нь зогсоож байхын тулд бүрэлдэхүүний (зүтгүүргүй) жингийн 100 тонн тутамд 1.0 тоормосны гол ногдохоор бодож, гар тоормосоор хангана.

16.60. Хоорондын замд зорчигчийн галт тэрэгний автомат тоормос эвдэрсэн тохиолдолд ойролцоох өртөө хүртэл гар тоормостой 15 км/цагаас дээшгүй хурдтай явж болно.

16.61. Галт тэрэгний гар тоормосыг машинчийн өгсөн дохиогоор ажиллуулах үүргийг галт тэргэнд үйлчилж яваа ажилтан (үйлчлэгч ба бусад ажилтан) гүйцэтгэнэ. Хоорондын замд ачааны галт тэрэгний автомат тоормос эвдэрвэл цааш явахыг хориглоно.

16.62. Автомат тоормосны ажиллагааг сэргээх боломжгүй тохиолдолд галт тэргэнд байгаа тоормосны хангамжийг тооцон замын хэвгийгээс хамаарч хурдыг тогтоон дараагийн өртөө хүртэл явахыг суурь бүтэц эзэмшигчийн тушаалаар явахыг зөвшөөрнө.

16.63. Галт тэргийг аялалд гаргахын өмнө буюу аялалын үед уг галт тэрэгний автомат тоормосын ажиллагааг шалгаж туршилт хийнэ.

16.64. Галт тэрэгний бүх вагоны тоормосын гол хоолойн байдал, тоормосын ажиллагааг шалгах бүрэн туршилтыг дараах тохиолдолд хийнэ.

- а. Найруулсан өртөөн дээр галт тэргийг явуулахын өмнө
- б. Зүтгүүр сольсны дараа
- в. Сунгуу уруудуурт хоорондын замын өмнөх өртөөнд зурмагийн дагуу зогсолттой бол

г. 0.018 ба түүнээс огцом сунгуу уруудууртай хэсгийн өмнө бүрэн туршилтыг 10 минутын барилттайгаар хийнэ. Ийм өртөөдийн жагсаалт, тоормос турших журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

16.65. Галт тэрэгний тоормосын байдлыг сүүлийн хоёр вагоны тоормосын ажиллагаагаар шалгадаг тоормосын товчилсон туршилтыг дараах тохиолдолд хийнэ:

а. Өртөөний хийн шахуургын суурин төхөөрөмж буюу зүтгүүрээр тоормосын бүрэн туршилтыг урьдчилан хийсэн галт тэргэнд зүтгүүр холбож явуулахын өмнө.

б. Зүтгүүрийг галт тэрэгнээс салгахгүйгээр бригад солигдох үед

в. Галт тэрэгний вагоны хооронд ямар нэгэн шалтгаанаар зөөлөн холбоос салсан буюу төгсгөлийн кран хаагдаж, нээгдсэний дараа

г. Суудлын галт тэрэг 20 минутаас дээш хугацаагаар зогссоны дараа явахын өмнө

д. Ачааны галт тэрэг 30 минутаас дээш хугацаагаар зогссон үед гол хоолойн нягтыг шалгахад ВУ-45 маяганд бичигдсэн хэмжээнээс 20 хувиас их өөрчлөгдсөн үед

е. Зүтгүүрийн гол хоолойн тасралтыг дохиологч 418 тоот төхөөрөмжөөр тоногловсон галт тэрэг зогсож байхад дохиолол ажиллаж ТМ гэрэл ассан.

ё. Ерөнхий савны даралт $5,5 \text{ кг/см}^2$ -аас доош бага болсон.

ж. Зорчигчийн галт тэрэгний тоормосын удирдлага нэг бүхээгээс нөгөө бүхээг, нэг зүтгүүрээс нөгөө зүтгүүрт шилжүүлэгдсэний дараа

Вагон үзэгчгүй өртөөнд доорх тохиолдолд галт тэрэгний бүрэлдэхүүний эхний 5 вагоны тоормосны ажиллагаагаар тоормосын товчилсон туршилтыг хийж болно.

а. Ачааны галт тэрэгний зүтгүүрийн тоормосын удирдлага нэг бүхээгээс нөгөө бүхээг, нэг зүтгүүрээс нөгөө зүтгүүрт шилжүүлэгдсэний дараа

б. Түлхэгч зүтгүүр салсан

в. Ачааны галт тэрэг 30 минутаас дээш хугацаагаар зогссон үед гол хоолойн нягтыг шалгахад ВУ-45 маяганд бичигдсэн хэмжээнээс өөрчлөлт нь 20 хувиас бага бол

ГАЛТ ТЭРГИЙГ ТОНОГЛОХ БА ҮЙЛЧЛЭХ

16.66. Зорчигчийн, ачаа-зорчигчийн, цэргийн ба хүмүүсийн галт тэргийг зөөврийн телефон утас, радио холбоо, гал унтраах болон эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хэрэгсэл, техникийн сэлбэг, бусад тоноглолоор хангана.

16.67. Тэсрэх аюултай ачаатай вагоноос бүрдсэн галт тэргийг гал унтраах хэрэгсэл, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хэрэгсэл, машинчтай холбоо барих радио станцаар тоноглоно.

Галт тэргийг гал унтраах болон эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хэрэгсэл, радио станцаар хангах нормыг Төрийн захиргааны төв байгууллага батална.

16.68. Холбогдох стандартын дагуу зүтгүүрийг гал унтраах болон хөдлөх бүрэлдэхүүнийг зам дээр өргөж гаргах хэрэгсэл, шаардагдах дохионы хэрэгсэл, багаж, бусад эд зүйлсээр хангасан байна. Галт тэрэгний зүтгүүрийг радио станцаар тоногловсон байна.

16.69. Автомат тоормос эвдэрсэн үед хоорондын замд хөдлөх бүрэлдэхүүнийг бэхлэх тооцоот ивүүрээр зүтгүүрийг хангах, 0.012-оос огцом хэвгийтэй хэсэгт автомат тоормос эвдэрсэн үед хоорондын замд ачааны ба ачаа-зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнийг бэхлэх журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

16.70. Галт тэргэнд зүтгүүрийн болон галт тэрэгний бригад үйлчилнэ. Галт тэрэгний зэрэглэл ба хэсэгт ажиллах нөхцөлөөс хамаарч галт тэрэгний бригадын бүрэлдэхүүн, галт тэрэгт үйлчлэх журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

16.71. Хоорондын замд аж ахуйн галт тэрэгний хөдөлгөөнийг ажил удирдагч буюу түүний томилсон ажилтан удирдана. Эдгээр ажилтны үүргийг Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журмаар тодорхойлно. Эргэлтийн депотой өртөөнд зүтгүүрийн болон галт тэрэгний бригад амрах зориулалттай тусгай байр байна.

ГАЛТ ТЭРГЭНД ЗҮТГҮҮР ХОЛБОХ

16.72. Ажиллаж байгаа илчит тэргийг галт тэрэгний эхэнд холбож урд бүхээгнээс машинч жолоодно.

16.73. Жолоодлогын нэг бүхээгтэй илчит тэргийг хөдөлгөөний явах чиглэлийн дагуу галт тэрэгний эхэнд холбоно. Аялах хэсгийн хэмжээнд ажиллагаатай хос зүтгүүртэй явах галт тэрэгний эхэнд хүч ихтэй хийн шахуурга бүхий зүтгүүр холбоно.

16.74. Хэсэг **хагасалж** явах ажиллагаатай зүтгүүрийг галт тэргэнд холбох журам, хөдөлгөөний аюулгүй **байдлыг** хангаж аялах нөхцөлийг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

16.75. Галт тэрэгний илчит тэргээр сэлгээний хөдөлгөөн хийх үед машинч, туслах машинч нар зүтгүүрийн хөдөлгөөний чиглэлийн дагуу эхний секцэд байрлана.

16.76. Дан зүтгүүр чөлөөтэй замаар эсвэл вагонтой талаараа урагш түрж явах тухай өртөөний техник захирамжийн актанд тусгайлан заагаагүй бол хөдөлгөөний чиглэлийн эхний бүхээгнээс зүтгүүрийг жолоодно. **Хоёр секцтэй болон хоёр бүхээгтэй зүтгүүрийг сэлгээнд ашиглах үед бригадын байрлах газрыг өртөөний техник захирамжийн актаар тогтооно.**

16.77. Жолоодлогын нэг бүхээгтэй зүтгүүрийг зөвхөн дараах үед ухрааж болно:

- Хот дүүргийн, аж ахуйн, галын, дамжуулах болон зөөврийн, сэргээн босгох галт тэрэгтэй явах үед
- Салбар болон холбох замаар явах үед
- Сэлгээний ажил хийх үед
- Хос зүтгүүрийн хоёрдох зүтгүүр болж явах үед
- Зүтгүүр эргэх байгууламж эвдэрхий буюу байхгүй өртөөнөөс галт тэрэг явуулах үед
- Галт тэрэг түлхсэний дараа явуулсан өртөөнд буцаж ирэх үед

- Галт тэргийг хоорондын замаас туслах зүтгүүрээр татаж авах үед
- Вагонгүйгээр явах үед

16.78. Хоёр секцтэй зүтгүүрийн нэг секцийг ашиглаж байгаа тохиолдолд жолоодлогын бүхээггүй талаар ухрахыг хориглоно.

16.79. Ганцаар яваа зүтгүүрт вагон үзэгчгүй өртөөнөөс 40 голоос дээшгүй тооны вагон залгаж болно. Автомат тоормостой бүх вагоныг автомат тоормосны сүлжээнд залгасан байна. Энэ галт тэрэгний тоормозыг турших ажилагааг зүтгүүрийн бригад гүйцэтгэнэ.

16.80. Галт тэрэгний түүчээ зүтгүүрийн араас холбох ажиллуулаагүй зүтгүүрийн тоог суурь бүтэц эзэмшигч тогтооно.

АРВАН ДОЛОО ДУГААР БҮЛЭГ

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН

Ерөнхий шаардлага

17.1. Хэсгийн хэмжээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зөвхөн нэг ажилтан, тухайлбал галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн биелэлтийг хариуцах үүрэг бүхий галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч удирдана. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалыг хэсгийн хэмжээнд галт тэрэгний хөдөлгөөнд шууд холбоотой ажилтан үг дуугүй биелүүлнэ.

17.2. Хэсгийн хэмжээнд галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчаас бусад ажилтан галт тэрэгний хөдөлгөөний талаар шуурхай үүрэг даалгавар өгөхийг хориглоно.

17.3. Галт тэрэгний хөдөлгөөнийг зөвхөн нэг ажилтан удирдана.

17.4. Хэсэгт-галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч, Өртөөнд-өртөөний жижүүр, постонд-постын жижүүр, хоорондын зам дахь аж ахуйн галт тэргэнд ажил удирдагч, хоёроос дээш тооны зүтгүүр бүхий галт тэргэнд түүчээ зүтгүүрийн машинч удирдана.

17.5. Томоохон өртөөдөд өртөө, суман шилжүүлэг удирдлагын байрны буюу паркийн хэд хэдэн жижүүр байж болно. Ийм өртөөдөд жижүүрүүдийн удирдлагын зааг хэсэг болон жижүүр тус бүрийн галт тэрэгний хөдөлгөөнтэй холбогдсон үүргийг өртөөний техник захирамжийн актад заана. Жижүүр нь өөрийн хэсэгт галт тэрэгний хөдөлгөөнийг ганцаараа удирдах ба тухайн хэсэгт галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой болон бусад бүх засвар, үйлчилгээний ажилтан албан хаагчид түүнд захирагдана.

17.6. Галт тэрэг хүлээн авах, явуулах зам ашиглах журмыг өртөөний техник захирамжийн актаар тогтооно.

17.7. Зорчигчийн, ачаа-зорчигчийн, хүмүүсийн галт тэргийг зорчигчийн байгууламж бүхий зам дээр хүлээн авах ба зогсолтгүй шууд явах галт тэргийг **техник захирамжийн актад** заасан замаар өнгөрүүлнэ.

17.8. Өртөөний жижүүр галт тэргийг цаг тухайд нь хүлээн авч байхын тулд чөлөөтэй замыг бэлэн байлгана. Өртөөний жижүүр галт тэргийг онцлох шаардлагагүйгээр хориглосон заалттай оруулах **гэрлэн** дохионы дэргэд саатуулбал хариуцлага хүлээнэ.

17.9. Галт тэрэгний хөдөлгөөний зохицуулагчийн зөвшөөрөлгүйгээр ачилт, **буулгалтад** тавих болон засварын ажилд өгөхөөр галт тэрэгнээс салгасан нэг буюу бүлэг вагоныг хүлээн авах, явуулах замд тавьж зам эзлүүлэхийг хориглоно.

17.10. Завсарын өртөө, зөрлөгт хүлээн авах, явуулах, салбар замд ачилт буулгалтанд тавьсан болон галт тэрэгнээс техникийн шалтгаанаар салгагдсан вагоныг галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журманд зааснаар тооцоот ивүүрээр бэхлэнэ.

17.11. Барих мухар замыг хөдлөх бүрэлдэхүүнээр, хамгаалах мухар замыг зорчигчийн, хүн суулгасан, тэсрэх ба бусад аюултай ачаатай ачааны вагоноор эзлүүлэхийг хориглоно.

ГАЛТ ТЭРЭГ ХҮЛЭЭН АВАХ

17.12. Өртөөний дарга хөдөлгөөний аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, галт тэрэг саатуулахгүй байхаар өртөөний жижүүрийн ажлыг зохион байгуулна. Өртөөний жижүүрийн байрыг бусдаас тусгаарласан байна.

17.13. Өртөөний жижүүрийн байранд зөвхөн өртөөний дарга, өртөөний жижүүртэй хамт ажилладаг буюу өөрийн албан үүргийг хамтран гүйцэтгэдэг ажилтан, өртөөний жижүүрийн ажиллагаа болон удирдлагын багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хянадаг ажилтан нар орох эрхтэй.

17.14. Өртөөнд галт тэрэг хүлээн авахдаа өртөөний техник захирамжийн **актад** заасан чөлөөтэй зам дээр нээлттэй оруулах дохиогоор гүйцэтгэнэ.

17.15. Өртөөнд түлхэгч зүтгүүрийг хүлээн авахын тулд замын тодорхой хэсгийг тогтоож болно. Тодорхой хэсэг гэдэг нь өртөө, зөрлөгийн хоёр оруулах **гэрлэн** дохионы дотор талын эхний сумны өмнөх хэсгийг хэлнэ.

17.16. Замын тодорхой хэсэгт галт тэрэг хүлээн авахдаа билет газарчаар хүлээн авна.

17.17. Шаардлагатай үед сэргээн босгох, галын галт тэрэг, туслах зүтгүүр, вагонгүй зүтгүүр, цас цэвэрлэгч, замаас авагддаггүй дрезин, замын машин ба хаалттай хоорондын замд ажил хийсэн аж ахуйн галт тэрэгийг өртөөний замын тодорхой хэсэгт хүлээн авч болно. Цаашид эдгээр галт тэргийг өртөөний жижүүрийн захирамжаар “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”-д нийцүүлэн өртөөний замд оруулна.

17.18. Өртөөний жижүүр өөрөө буюу түүний захирамжаар техник захирамжийн актад заасан өөр ажилтан оруулах дохио нээхийн өмнө дараах зүйлийг шалгана.

а. Галт тэрэг хүлээн авах зам чөлөөтэй **эсэх**

б. Галт тэрэг хүлээн авах замналыг ашиглаж хийгдэж байгаа сэлгээ зогссон **эсэх**

в. Замналд орсон бүх суман шилжүүлэг замналд тавигдаж түгжигдсэн **эсэх**

17.19. Зам суман шилжүүлэг цахилгаан төвлөрүүлэлтээр тоноглогдсон өртөөнд ирж байгаа галт тэрэгний эхний хос дугуй оруулах дохионы тусгаарлагдсан хэсэг өнгөрмөгц оруулах дохио автоматаар хаагдана.

17.20. Зам суман шилжүүлэг цахилгаан төвлөрүүлэлтээр тоноглогдоогүй өртөө, зөрлөгт ирж байгаа галт тэрэгний бүрэлдэхүүн оруулах дохиог бүрэн өнгөрсний дараа өртөөний жижүүрийн захирамжаар сумчин оруулах дохиог хаана.

17.21. Оруулах дохионы үндсэн гэрэл унтарсан буюу хориглосон заалттай үед галт тэргийг урих дохиогоор, билет газарчаар, өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар хүлээн авна. Энэ үед галт тэрэгний машинч нь 20 км/цагаас илүүгүй хурдтай, сонор сэрэмжтэй, зогсоход бэлэн явж, сэрэмжлэх дохиог үе үе өгч байна. Оруулах дохионы үндсэн гэрэл унтарсан үед галт тэргийг өртөөнд хүлээн авахыг “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”-аар зохицуулна.

17.22. Завсрын өртөө, зөрлөгт эсрэг чиглэлээс нэгэн зэрэг ирэх хоёр галт тэргийг хооронд нь хамгаалах мухар замгүй өртөөнд оруулах (өртөө рүү ойртох) аль нэг талын зам нь тоормосын замын туршид 0.006-аас огцом уруудууртай байвал хоёр галт тэрэг зэрэг хүлээж авахыг хориглоно.

17.23. Галт тэргийг нэгэн зэрэг хүлээн авахыг зөвшөөрсөн өртөөдийн жагсаалтыг суурь бүтэц эзэмшигч батална.

17.24. Галт тэргийг нэгэн зэрэг хүлээн авдаггүй өртөөнд галт тэрэг хоёр талаас нэгэн зэрэг ирэх зайлшгүй тохиолдолд хориглосон заалттай оруулах **гэрлэн** дохионы гадна зогсох ба байрнаас хөдлөх нөхцөл нь тааламжгүй талын галт тэргийг эхэлж хүлээн авна. Ямар ч тохиолдолд хойноос нь өөр галт тэрэг мөрдөж яваа галт тэргийг түрүүнд нь хүлээн авна.

17.25. Өртөөнд ирэх галт тэргийг гаргах **гэрлэн** дохио, гаргах **гэрлэн** дохио байхгүй газарт бол хүлээн авах замын хязгаарын шонгийн хооронд зогсооно.

17.26. Хэрэв галт тэрэгний сүүлчийн вагон хязгаарын шонгийн гадна үлдэж байвал энэ тухай сумчин өртөөний жижүүрт нэн даруй мэдэгдэх бөгөөд өртөөний жижүүр галт тэргийг хүлээн авах замын ашигтай уртын заагт багтааж тавих арга хэмжээг авна.

17.27. Цахилгаан төвлөрүүлэлттэй өртөөнд хүлээн авах замын ашигтай уртын хязгаарт галт тэрэг зогсоосон эсэхийг өртөөний жижүүр хянах самбарын заалтаар хянана.

17.28. Хэрэв галт тэргийг хүлээн авах замын ашигтай уртын заагт багтаан тавих боломжгүй бол өртөөний жижүүр зэргэлдээ замаар хөдлөх бүрэлдэхүүн явах үед хөдөлгөөний аюулгүй **байдлыг** хангах арга хэмжээ авна.

17.29. Өртөө, зөрлөгт ирэх галт тэрэг бүрийг өртөөний жижүүр угтан авч галт тэрэг бүрэн бүрэлдэхүүнтэй, сүүлийн дохиотой ирсэн, өнгөрснийг өөрийн биеэр буюу хөдөлгөөний ажилтан, зөрж байгаа галт тэрэгний машинч нарын илтгэлээр тус тус магадлах үйл ажиллагааг техник захирамжийн актаар тогтооно.

17.30. Өртөөний жижүүр галт тэргийг угтахгүй байж болох өртөөдийн жагсаалт, тэдгээр өртөөнд галт тэрэг хүлээн авах үед хөдөлгөөний аюулгүй **байдлыг** хангах нөхцөлийг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

17.31. Өртөөний жижүүр галт тэрэг бүрийн жинхэнэ ирсэн буюу явж өнгөрсөн цаг, түүний дугаарыг галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт тэмдэглэж, галт тэрэг явуулсан зэргэлдээ өртөөний жижүүрт, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид нэн даруй мэдэгдэнэ.

ГАЛТ ТЭРЭГ ЯВУУЛАХ

17.32. Өртөөний жижүүрт галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч, очих өртөөний жижүүрийн зөвшөөрөлгүйгээр галт тэрэг явуулахыг хориглоно.

17.33. Галт тэрэг явуулахын өмнө өртөөний жижүүр дараах үүргийг гүйцэтгэнэ:

- а.** Хоорондын зам чөлөөтэй эсэхийг магадлах
- б.** Галт тэрэг явуулах замнал руу гарч сэлгээ хийхийг зогсоох
- в.** Галт тэрэг явуулах замнал бэлтгэх
- г.** Гаргах гэрлэн дохио нээх буюу машинчид хоорондын зам эзлэх зөвшөөрөл олгох.

17.34. Галт тэрэг явуулах замнал бэлтгэх талаар өртөөний жижүүр, сумчны ажиллах зарчмыг галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журмаар тогтооно.

17.35. Явах галт тэрэгний машинчид хоорондын зам эзлэх зөвшөөрөл нь гаргах гэрлэн дохионы зөвшөөрсөн заалт байна. Харин гаргах гэрлэн дохио гэмтэлтэй эсвэл байхгүй замаас галт тэргийг явуулах зөвшөөрөл нь тогтоосон маягт бүхий бичгэн зөвшөөрөл, бүртгэлт тушаал буюу очир болно.

17.36. Хоорондын зам хэвийн эзлэгдсэн, замнал зөв тухай жижүүрийн илтгэлийг үндэслэн гаргах гэрлэн дохио нээгдээгүй тохиолдолд бүртгэлт тушаалаар галт тэргийг явуулна.

17.37. Өртөөний жижүүрт галт тэрэг явуулах замнал бэлэн болсон, сум түгжигдсэн, явуулах замналын суман дээр сэлгээ хийхийг зогсоосон, бүрэлдэхүүний техникийн үйлчилгээ, ачаа тээврийн үзлэг дууссан болохыг магадлахгүйгээр гаргах **гэрлэн** дохио нээх, хоорондын зам эзлэх өөр зөвшөөрөл олгохыг хориглоно.

17.38. Галт тэрэг найруулсан болон галт тэрэгний **бүрэлдэхүүнд** вагон холбох, салгах ажил хийсэн өртөөнөөс галт тэрэг явуулахдаа өртөөний жижүүр гаргах гэрлэн дохиог нээх буюу зүтгүүрийн машинчид хоорондын зам эзлэх зөвшөөрөл олгохын өмнө сүүлчийн вагонд галт тэрэгний сүүлийн дохио байгаа эсэхийг магадлана.

17.39. Гаргах гэрлэн дохиог өртөөний жижүүр өөрөө нээнэ. Явах галт тэрэгний эхний хос дугуй гаргах гэрлэн дохиог өнгөрсний дараа автоматаар хаагдана.

17.40. Өртөөний гаргах гэрлэн дохио хориглосон заалттай байхад галт тэрэг явах үед хоорондын зам эзлэх зөвшөөрөл авсан ч радио холбоогоор өртөөний жижүүрээс өгсөн захирамжгүйгээр эсвэл түүний даалгавраар паркийн жижүүр, туслах жижүүр, оператор, сумчны дохиогүйгээр галт тэрэг хөдөлгөхийг түүчээ зүтгүүрийн машинчид хориглоно.

17.41. Зүтгүүрийн машинч, туслах машинч, галт тэрэг хөдөлгөхийн өмнө ба хөдөлж байхад галт тэрэгнээс, өртөөний болон техник үйлчилгээний газрын ажилтнаас огсоох дохио өгч байгааг магадлана. Зорчигчийн ба ачаа зорчигчийн галт тэрэгний машинчид хөдөлгөөний цагийн хуваариар тогтоосон цагаас өмнө явахыг хориглоно.

17.42. Зүтгүүрийн бригад, галт тэрэгний дарга, зорчигчийн галт тэрэгний вагоны үйлчлэгч аюулгүй явахад саад болох зүйл илрүүлбэл галт тэргийг зогсоох арга хэмжээ нэн даруй авна.

17.43. Гаргах гэрлэн дохио хориглосон заалттай үед галт тэрэг явуулахын өмнө өртөөний жижүүр /туслах жижүүр, оператор, сумчин/ нь хоорондын зам эзлэх зөвшөөрлийг машинчид олгож галт тэргэнд явах дохио өгнө.

Машинч нь хоорондын зам эзлэхээр авсан зөвшөөрөл зөв болохыг магадлах үүрэгтэй.

17.44. Галт тэрэгний радио холбоо ажиллагаагүй болсон үед бүртгэл тушаалыг машинчийн бригад даамжуулахдаа техник захирамжийн актад заагдсан ажилтнаар өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалын дэвтрийг танилцуулж гарын үсгээр баталгаажуулна.

17.45. Зогсоох кран ажиллуулснаас буюу аяндаа тоормослогдсоноос зорчигчийн галт тэрэг хоорондын замд зогсох үед үйлчлэгч өөрийн вагоныг шалгаж, шаардлагатай бол зүтгүүрийн зүгт зогсоох дохио нэн даруй өгнө.

17.46. Вагоны бүх үйлчлэгч зогсоох дохиог авсны дараа зорчигчийн галт тэрэгний хөдөлгөөнийг, харин бусад галт тэргийг туслах машинчийн илтгэсний дагуу аяллыг үргэлжлүүлнэ.

17.47. Галт тэрэг зогсох үед туслах машинч галт тэргийг үзэж, галт тэрэгний бүрэлдэхүүн бүрэн эсэхийг сүүлчийн вагоны дугаар, галт тэрэгний сүүлийн дохиог шалгана.

17.48. Хөдөлгөөний зурмагт заагдаагүй бусад шалгаанаар хоорондын замд зогссон үед (хүмүүс буулгах буюу суулгах, ачаа ачих буюу буулгахад) галт тэргийг хөдөлгөөнд оруулахыг Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журманд зааснаар гүйцэтгэнэ.

17.49. Өртөөний жижүүр, туслах жижүүр нь өртөөнөөс явуулж байгаа болон, өртөөгөөр зогсолтгүй өнгөрч байгаа галт тэрэг бүрийг үдэж түүний хэвийн байдал, галт тэрэгний дохио тоо ёсоор зөв зааж буй эсэхийг магадлана. Өртөөний жижүүр галт тэрэг бүрэн **бүрэлдэхүүнтэй** бөгөөд сүүлийн дохиотой явсан тухай өөрийн биеэр буюу техник захирамжийн актад заасан ажилтны илтгэлээр заавал магадлана.

17.50. Өртөөний жижүүр галт тэргийг үдэхгүй байж болох өртөөний жагсаалт, эдгээр өртөөнөөс галт тэрэг явуулахад хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах **журмыг** суурь бүтэц эзэмшигч тогтоож мөрдүүлнэ.

17.51. Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй **байдалд** саад учруулж болох гэмтэл илрүүлэх, галт тэрэг тогтоосон дохиогүй өнгөрөх үед галт тэрэг үдэгч ажилтан түүнийг зогсоох арга хэмжээ авна. Өртөөнөөс явж байгаа галт тэрэгний сүүлчийн вагоны дугаар сүүлийн дохиотой эсэх тухай радио холбоогоор машинчид мэдээлнэ.

17.52. Галт тэрэг зөв найруулсан эсэхийг өртөөний ажилтан нар хариуцна.

17.53. Өртөөний ажилтан нар галт тэрэг явуулахын өмнө галт тэрэг найруулах төлөвлөгөөний дагуу зөв найруулсан, задгай хөдлөх бүрэлдэхүүн дээрх ачааг зөв ачиж бэхэлсэн, галт тэрэг тогтоосон дохио, шаардагдах багаж **хэрэгслээр** бүрэн тоноглогдсон болохыг мөрдөгдөж буй дүрэм, журам, зааварт нийцүүлэн шалгана.

17.54. Ачаа, ачаа-зорчигчийн галт тэрэгний сүүлийн дохиог тавих, авах **журмыг суурь бүтэц эзэгшигчийн журмаар тогтооно.**

17.55. Галт тэрэг явуулахын өмнө найруулсан өртөө нь ачааны болон ачаа-зорчигчийн бүх галт тэрэгний биечлэн бүртгэх хуудас, ачааны баримт бичгийг битүүмжилж түүчээ зүтгүүрийн машинчид хүлээлгэн өгнө.

17.56. Галт тэрэгнээс вагон салгах, холбох үед өртөөний ажилтан галт тэрэгний биечлэн бүртгэх хуудсанд зохих өөрчлөлт оруулна. Зорчигчийн бүх галт тэрэгний биечлэн бүртгэх хуудсыг галт тэрэгний даргад өгнө.

17. 57. Өртөөний жижүүр галт тэрэг жинхэнэ явсан буюу өнгөрсөн цаг, түүний дугаар, бүрэлдэхүүнийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай мэдээ баримтыг галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт тэмдэглэж, зэргэлдээ өртөөний жижүүрт болон галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид нэн даруй мэдэгдэнэ.

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ ДОХИОЛОЛ, ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ

17.58. Галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах дохиолол холбооны үндсэн хэрэгсэл нь автомат хориглол, өртөө хоорондын хориглол, хагас автомат хориглол, цахилгаан очирын систем мөн.

17.59. Автомат хориглолын үед:

а. Автомат хориглолоор тоноглогдсон нэг замтай хоорондын замын галт тэрэгний хөдөлгөөн нь хоёр чиглэлд байхаар зохицуулагдана.

б. Автомат хориглолын төхөөрөмжөөр тоноглогдсон хоорондын замд зүтгүүрийн автомат дохиолол нь бие даасан дохионы хэрэгсэл байна.

в. Автомат хориглолоор тоноглогдсон хос замтай хоорондын замд нэг чиглэлийн хөдөлгөөнийг зохион байгуулна. Гэвч шаардлагатай үед тухайн замаар хоёр чиглэлийн хөдөлгөөн зохион байгуулж болно. Хоёр чиглэлийн хөдөлгөөн зохион байгуулж байгаа үед эсрэг чиглэлд зүтгүүрийн автомат дохиоллыг ашиглана.

17.60. Автомат хориглолын дохиоллын үед:

а. Галт тэрэг блок-хэсгийг эзлэх зөвшөөрөл нь гаргах буюу өнгөрүүлэх гэрлэн дохионы зөвшөөрсөн заалт болно.

б. Сунгуу өгсүүрт байрласан өнгөрүүлэх гэрлэн дохионд (оруулах дохионы өмнөхөөс бусад) “Д” үсгийн хэлбэрт гэрэл ойлгогчтой таних тэмдэг бүхий самбарыг суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр байрлуулна. Ийм дохионы тэмдэг нь ачааны галт тэрэг гэрлэн дохионы улаан гэрлийн заалтыг зогсолтгүйгээр өнгөрөх зөвшөөрөл болдог. Энэ үед машинч онцгой сонор сэрэмжтэй явж хориглосон заалттай гэрлэн дохиог 20 км/цагаас ихгүй хурдтай өнгөрөх ба цаашдын хөдөлгөөнд ямар нэг саад учрахад яаралтай зогсоход бэлэн явна.

в. Улаан заалттай өнгөрүүлэх гэрлэн дохио, унтарсан буюу үл ойлгогдох заалттай гэрлэн дохионы өмнө зогссон галт тэрэгний машинч өмнөх блок-хэсэг галт тэргээр эзэлгээтэйг мэдэж байх эсвэл түүн дээр галт тэрэг харагдаж байвал уг блок-хэсэг чөлөөлөгдөх хүртэл явахыг хориглоно.

г. Хэрэв машинчид өмнөх блок-хэсэгт галт тэрэг байгаа нь мэдэгдэхгүй бол зогссоны дараа заавал автомат тоормосоо суллах ба гэрлэн дохионы зөвшөөрсөн заалт асахгүй бол дараагийн гэрлэн дохио хүртэл онцгой сонор сэрэмжтэй 20 км/цагаас ихгүй хурдтай цаашдын хөдөлгөөнд ямар нэгэн саад учрахад яаралтай зогсоход бэлэн явна. Дараагийн өнгөрөх гэрлэн дохио мөн адил байх тохиолдолд зогссоны дараа дээрх дарааллаар хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ.

д. Хориглосон заалттай хоорондын замын өнгөрүүлэх гэрлэн дохиог тогтоосон дарааллын дагуу өнгөрсний дараа зүтгүүрийн гэрлэн дохио зөвшөөрсөн заалттай болсон тохиолдолд машинч зүтгүүрийн гэрлэн дохионы заалтыг удирдлага болгон 40 км/цагаас ихгүй хурдтай дараагийн гэрлэн дохио хүртэл явж болно.

е. Зүтгүүрийн гэрлэн дохио нь зөвшөөрсөн заалттай байхад түүний заалтыг удирдлага болгон хоорондын замын гэрэл унтарсан өнгөрүүлэх гэрлэн дохиог зогсолтгүйгээр өнгөрөхийг зөвшөөрнө.

ё. Галт тэрэгний хөдөлгөөний үед машинч, туслах машинч гэрлэн дохионы заалтыг хатуу мөрдөнө. Харин зүтгүүрийн автомат дохиоллын системтэй бол

өнгөрүүлэх гэрлэн дохио ба зүтгүүрийн гэрлэн дохионы заалтыг нэгэн адил мөрдөнө.

17.61. Хагас автомат хориглолтой үед:

а. Галт тэргэнд хоорондын зам эзлүүлэх зөвшөөрөл нь гаргах буюу өнгөрүүлэх гэрлэн дохионы зөвшөөрсөн заалт юм.

б. Нэг замтай хэсэгт гаргах гэрлэн дохио нээхийн тулд галт тэрэг очих зэргэлдээ өртөөний жижүүрээс зөвшөөрлийн **хориг дохиог хориглолын** аппаратаар урьдчилан авна.

17.62. Хагас автомат хориглол нь үндсэн ба нөөц суваг, шугамаар тоноглогдсон байна. Үндсэн суваг, шугам гэмтэлтэй үед системийг нөөц шугамаар ажилуулахыг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн хяналтын дор өртөөний жижүүр гүйцэтгэнэ.

17.63. Цахилгаан очрын системтэй үед:

а. Галт тэргэнд хоорондын зам эзлүүлэх зөвшөөрөл нь уг хоорондын замд хамаарагдах очир болно.

б. Очрын холбоогоор зөвхөн галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах талаар ярих ба очир сугалан авах, буцааж хийх, түүнийг олгох, хүлээн авах явдлыг зөвхөн өртөөний жижүүр гүйцэтгэнэ.

в. Очрыг **аппаратад** буцааж хийх, машинчид гардуулж өгөхийг зөвхөн өртөөний жижүүр буюу түүний зөвшөөрснөөр сумчин гүйцэтгэнэ.

17.64. Цахилгаан очрын системтэй үед дараах зүйлийг хориглоно:

а. Галт тэргийг зогсолтгүй өнгөрүүлэх буюу цагийн хуваариар 5 минутаас дээшгүй зогсохоос бусад тохиолдолд галт тэрэг явахад бэлэн болохоос өмнө очир сугалж авах зөвшөөрөл хүсэх

б. Ашиглаж байгаа очрыг аппаратад буцааж хийхгүй хадгалах

в. Ирсэн галт тэрэгнээс хүлээн авсан очрыг очрын аппаратад хийхгүйгээр хоорондын замд явуулах галт тэрэгний машинчид гардуулан өгөх

г) Очрыг зэргэлдээ хоорондын зам руу алгасуулан авч явах

д. Очрын системийн ажиллагаа зогссон үед галт тэрэгний хөдөлгөөнийг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар утсан холбооны хэрэгслээр зохицуулна.

17.65. Утсан холбооны харилцаанд шилжсэн үед галт тэргэнд хоорондын зам эзлүүлэх зөвшөөрөл нь зүтгүүрийн машинчид олгох замын утсан мэдээ болно. Өртөөний жижүүр нь замын утсан мэдээ олгохын өмнө галт тэрэг явуулах тухай зэргэлдээ өртөөний жижүүрээс зөвшөөрөл авна.

17.66. Дохиолол холбооны тогтоосон бүх хэрэгслийн ажиллагаа тасарсан үед галт тэрэгний хөдөлгөөнийг бичгэн мэдэгдлийн тусламжтайгаар зохицуулна. Дохиолол холбооны тогтоосон бүх хэрэгслийн ажиллагаа тасарсан үед галт

тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулахыг галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журмаар гүйцэтгэнэ.

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ЖУРАМ

17.67. Төмөр замын хэмжээнд зорчигчийн ба ачааны галт тэрэгний хөдөлгөөний зөвшөөрөгдөх хамгийн их хурдыг суурь бүтэц эзэмшигч тогтооно. Хэсэг тус бүрт галт тэрэгний хөдөлгөөний хурдыг галт тэрэгний хөдөлгөөний зурмагаар тогтооно.

17.68. Нэг шар (үл анивчих) гэрэлтэй гэрлэн дохио нь хориглосон заалттай дараагийн дохионы өмнө албан тоормослолт хэрэглэн зогсож чадахуйц хурдтай өнгөрөхийг зөвшөөрнө. Суман шилжүүлгээр хажуугийн зам руу галт тэрэг явах үеийн хурдыг ашиглалтын нөхцөлийг харгалзан суурь бүтэц эзэмшигч тогтооно.

17.69. Вагонтой талаараа урагш явах галт тэрэгний хөдөлгөөний хурд 25 км/цагаас, зүтгүүр ба замын машиндаа радио холбоотой аж ахуйн галт тэрэг болон замын машин, сэргээн босгох, галын галт тэрэгний бүтцээс хамаарч 40 км/цагаас ихгүй байж болно.

17.70. Хурд бууруулахыг шаардсан газраар өнгөрөх хурд ямар ч тохиолдолд анхаарамж буюу суурь бүтэц эзэмшигчийн тогтоосон хэмжээнд тохирч байх бөгөөд харин тусгайлан заасан зүйл байхгүй бол 25 км/цагаас ихгүй байж болно. Цагт 15 км/цагаас бага хурдтай өнгөрөх анхаарамж өгөгдсөн осолтой газрын эхэнд галт тэргийг замын засвар, арчлалт үйлчилгээ хариуцсан **нэгжээс** томилогдсон ажилтан угтан авч осолтой газрын төгсгөл хүртэл үдэн гаргана.

17.71. Зүтгүүрийн бригад дээр дурдсан осолтой газраар өнгөрөхдөө замын ажилтнаас өгөх дохиог анхааралтай ажиглаж өгсөн дохионы шаардлагыг биелүүлж явна.

17.72. Мухрын өртөөнд ирэх бүх галт тэрэгний хурд нь хүлээн авах замын эхэнд 15 км/цагаас ихгүй байна.

17.73. Галт тэрэг явах үед зүтгүүрийн болон галт тэрэгний бригадын онцгой сонор сэрэмжтэй байхыг хангаж, ажил хийж байгаа тухай тэдэнд анхааруулах шаардлагатай үед галт тэрэгний машинчид анхаарамж олгоно. Анхаарамжийг дараах үед олгоно.

а. Зам, гармын дохиолол, хиймэл төхөөрөмж байгууламж гэмтсэн, хурд бууруулах буюу замд зогсох шаардлагатай барилгын болон засварын ажил хийх үед

б. Шинэ төрлийн дохиолол холбооны хэрэгслийг нэвтрүүлэх, байнгын дохиог шинээр **ашиглалтад** оруулах, хуучин байсныг нь зөөх буюу хураан авах, гэрлэн дохиог хааж болохооргүй гэмтсэн үед

в. Ачилтын овор хэмжээнээс хэтэрч илүү гарсан ачаатай, хагас ачаатай цистерн-вагонтой галт тэргийг явуулахад уг галт тэрэгний хурдыг бууруулах буюу онцгой нөхцөл баримтлах шаардлагатай үед

г. Тухайн хэсэгт тогтоосон хурдтай явж чадахгүй хөдлөх бүрэлдэхүүнийг галт тэргэнд холбосон үед

д. Замаас авагддаг хөдлөх нэгжийг үзэгдэлт муутай нөхцөлд ажиллуулах, замын тэргэнцэр, замын **вагонцроор** ажил хийх болон нэг зам төмрөөр явах, хоёр дугуйт тэргэнцэрээр хүнд ачаа тээвэрлэх үед

е. Зүтгүүрийн автомат дохиоллын замын ба дамжуулах төхөөрөмж гэмтэлтэй үед

ё. Хос замтай хоорондын замд цас цэвэрлэгч машин, чиг залагч чигжигч машин, зам тавигч кран, төмөр замын кран, чигжээс цэвэрлэгч машин болон бусад машин ажиллах үед.

ж. Зам зуурт хурд бууруулах буюу галт тэрэг зогсох шаардлагатай мөн түүнчлэн галт тэрэгний явах онцлог нөхцөл байдлын тухай зүтгүүрийн бригад галт тэрэгний бригадад анхааруулах шаардлагатай болсон бусад тохиолдолд анхаарамж олгоно. Галт тэргэнд анхаарамж олгохыг галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журамд заагдсанаар гүйцэтгэнэ.

17.74. Дараах тохиолдолд галт тэрэг вагонтой талаараа урагш явж болно:

а. Салбар замаар явах, тэндээс буцах үед

б. Аж ахуйн, сэргээн босгох, галын галт тэрэгний хөдөлгөөний үед

17.75. Эдгээр тохиолдолд зам чөлөөтэй эсэхийг ажиглаж, хөдөлгөөний аюулгүй байдалд буюу хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулж болох үед галт тэргийг зогсоох арга хэмжээ авах үүрэгтэй ажилтан эхний вагонд явна.

17.76. Аж ахуйн галт тэрэг вагонтой талаараа урагшаа яваа тохиолдолд эхний вагонд байрласан дохиочин зүтгүүрийн машинчидтай радио холбоогоор харьцах боломжтой үед 40 км/цагаас ихгүй хурдтай явахыг зөвшөөрөх ба радио холбоогүй бол хурд 25 км/цагаас ихгүй байна.

ЗҮТГҮҮРИЙН МАШИНЧААС ГАЛТ ТЭРЭГ ЖОЛООДОХ ЖУРАМ

17.77. Машинч зүтгүүр хүлээн авахдаа дараах үүрэгтэй.

а. Зүтгүүрийн бүтээц, засвар үйлчилгээний дүрэм, өөрийн явах хэсгийн замын аяс, зам дагуух байнгын дохио, дохионы заагч болон тэмдэг, тэдгээрийн зориулалтыг сайн мэдэж, галт тэрэгний хөдөлгөөний цагийн хуваарийг биедээ авсан байх.

б. Аялалд явах зүтгүүр, хөдлөх нэгжийг хүлээн авахдаа тэдгээрийн бүрэн бүтэн байдал нэн ялангуяа явах анги, тоормосны ба элсний систем, радио холбоо, машинчийн сонор сэрэмж дээшлүүлэх болон дуун дохио өгөх төхөөрөмж найдвартай ажиллаж байгааг шалгах, зүтгүүрийн техникийн байдлын дэвтрийн бичлэгийг үндэслэж зүтгүүрийн автомат дохиолол, аюулгүй **байдлын** төхөөрөмжийн хэвийн ажиллагааг магадлах, мөн түүнчлэн зүтгүүрт байвал зохих дохионы хэрэгслийн иж бүрдэл, гал унтраах хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгах.

в. Хөдөлгөөний зурмагийг баримтлан галт тэргийг аюулгүй жолоодож явах.

17.78. Зүтгүүрийг галт тэрэгний бүрэлдэхүүнд залгасны дараа машинч нь:

а. Зүтгүүрийг **бүрэлдэхүүний** эхний вагонтой зөв холбосон, тэдгээрийн агаарын зөөлөн хоолойг зөв залгасан, төгсгөлийн краныг нээсэн эсэхийг магадлах, авто угсрааны зөрүүг шалгах.

б. Тоормосны гол хоолойг шахсан хийгээр цэнэглэж, даралтын уналт нь тогтоосон норм хэмжээнээс хэтрэхгүй болохыг магадалж, галт тэрэгний бүрэлдэхүүний автомат тоормосыг зааврын дагуу турших.

в. Галт тэргийг тоормосоор хангасан байдлын тухай баримтыг авч түүнд заасан сүүлчийн вагоны дугаарыг **биечилсэн хуудаатай** тулган үзэх, галт тэрэгний тоормосны нэгдсэн шахалт нь тогтоосон замын **хэсэгт** тохирч байгаа эсэхийг магадлах.

г. Ачааны буюу ачаа-зорчигчийн галт тэрэг, хүмүүс суулгасан вагон, онцгой болгоомж шаардсан зарим төрлийн ачаатай вагон, задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачсан ачаатай вагон байгаа эсэх, мөн зорчигчийн ба шуудан тээшийн галт тэргэнд ачаа, ачаан тээштэй ачааны вагон байгаа эсэхийг **биечилсэн** хуудасны дагуу танилцах.

д. Өртөөнөөс явахын өмнө сонор сэрэмж шалгах, зогсоох автомат төхөөрөмжийг шалгах.

17.79. Галт тэрэг жолоодож яваа машинч, туслах машинчийн үүрэг:

а. Зам чөлөөтэй эсэх, дохио, дохионы заагч болон тэмдгийг ажиглаж, тэдгээрийн шаардлагыг биелүүлж гэрлэн дохио, семафороор өгч байгаа дохио галт тэрэгний бригад, өртөө, замын ажилтнаас өгөх зогсоох, хурд бууруулах дохиог ажиглаж бие биедээ давталцаж байх

б. Галт тэрэгний бүрэлдэхүүний бүрэн гүйцэд эсэхийг харж шалгаж байх.

в. Зүтгүүр, түүний хөдөлгүүрийн тасралтгүй хэвийн, аюулгүй ажиллагааг хянах хэрэгслийн заалтыг ажиглаж байх

г. Түлш тосыг хэмнэлттэй зарцуулан зүтгүүрийн хүчин чадлыг аль болох бүрэн дүүрэн ашиглах

д. Өртөөнд орох ба өнгөрөхдөө өгөгдөж байгаа дохиог ажиглаж, замнал зөв, зам чөлөөтэй болохыг хянаж, өртөөний ажилтны өгөх дохио, зэргэлдээ замаар хийгдэж байгаа галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнийг ажиглаж, хөдөлгөөний аюулгүй **байдалд эрсдэл** учруулж болох бусад тохиолдолд зогсоох арга хэмжээг нэн даруй авч байх

е. Өртөөнд галт тэргийг зогсоох шаардлагатай үед хүлээн авах замын гаргах **гэрлэн** дохиог (гаргах **гэрлэн** дохио байхгүй бол хязгаарын шон) өнгөрүүлэхгүйгээр галт тэргийг зогсоох

ж. Өртөөнд галт тэргийг зогсоосны дараа бүрэлдэхүүнд ямар нэгэн гэмтэл илрүүлбэл энэ тухай өртөөний жижүүрт нэн даруй мэдэгдэх

з. Замд явж байхдаа дохионы хэрэгсэл, зам болон бусад **байгууламж, төхөөрөмж**, зэргэлдээ замын галт тэргэнд эвдрэл гэмтэл илрүүлбэл энэ тухай ойролцоо өртөөний жижүүрт буюу галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэх.

и. Өртөө, зөрлөгт галт тэрэг зөрөх, гүйцэж түрүүлэхэд машинч нар галт тэрэг тус бүрийн бүрэлдэхүүний бүрэн бүтэн байдалд харилцан хяналт тавьж, галт тэрэгний сүүлчийн вагоны дугаар, сүүлийн дохио, тоормосны гол хоолой сойсон эсэх тухай радио станцаар харилцан мэдээлэх

17.80. Галт тэрэг жолоодож явахдаа дараах үйлдлийг гүйцэтгэнэ:

а. Тоормосны хэрэгслийг ажиллуулахад ямагт бэлэн байлгаж зам зууртаа тэдгээрийг шалгаж, ерөнхий сав, гол хоолойн даралтыг хэмжээг тогтоосон нормоос доош бууруулахгүй байх.

б. Байнгын дохио хориглосон заалттай байх буюу бусад дохионы заалт хурд бууруулахыг шаардсан байвал албаны тоормос хийж, хориглосон заалттай дохио өнгөрүүлэхгүйгээр галт тэргийг зогсоох ба харин хурд бууруулах дохиотой бол тухайн дохиогоор тогтоосноос илүүгүй хурдтай өнгөрч байх.

в. Зогсох дохио гэнэт өгөгдөх буюу саад гэнэт тохиолдох үед яаралтай тоормослох бүх арга хэрэгслийг ашиглан галт тэргийг тухайн газарт тогтоосон тоормосны замаас илүүгүй зайд зогсоох.

г. Дохионы үзэгдэлтийг эрс муутгасан өтгөн манан, аадар бороо, цасан ба шороон шуургатай үед галт тэргийг маш сонор сэрэмжтэй жолоодож, шаардлага тохиолдвол хөдөлгөөний аюулгүй **байдлыг** бүрэн хангасан байхаар хурдаа бууруулсан байх.

17.81. Замд явах үед зүтгүүрийн бригадад дараах зүйлийг хориглоно.

а. Энэхүү дүрэм, суурь бүтэц эзэмшигчийн тушаал, олгогдсон анхаарамж, дохионы заалтаар тогтоосон хурдыг хэтрүүлэх

б. Зүтгүүрийг жолоодож, дохионы заалт, замын байдлыг харж явах үедээ өөр зүйлд анхаарал хандуулах

в. Хэсэглэх газарт ойртон ирэх үед түрүүчийн секцийн бүхээгийг туслах машинч орхин явах

г. Сонор сэрэмж шалгах, аюулгүй байдлыг хангуулах зориулалттай хэвийн ажиллаж байгаа төхөөрөмжийг салгах, унтраах

д. **Зүтгүүр, буюу өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүнд засах боломжгүй гэмтэл доголдол гарснаар галт тэргийг жолоодох бололцоогүй болсон үед хоорондын замд гарах**

17.82. Галт тэрэг хос зүтгүүр буюу түлхэгч зүтгүүртэй явах үед галт тэрэгний хөдөлгөөнийг түүчээ зүтгүүрийн машинч удирдана. Хоёр дахь ба түлхэгч зүтгүүрийн машинч нар түүчээ зүтгүүрийн машинчийн бүх заавар болон дохионд захирагдаж, тэдгээрийг давтаж байх үүрэгтэй.

17.83. Галт тэргийг осол аюулгүй жолоодох, хоорондын замд галт тэрэгний явах цагийг мөрдөж биелүүлэхийг түүчээ ба хоёр дахь болон түлхэгч зүтгүүрийн машинч нар нэгэн адил бүрэн хариуцна.

17.84. Түлхэгч зүтгүүрийн ажиллах журмыг түлхэх газар бүрт зориуан суурь бүтэц эзэмшигчээс баталсан журмаар тогтооно.

17.85. Найруулагчийн бригад буюу суурь бүтэц эзэмшигчээс тогтоосон журмаар олгосон зөвшөөрөл бүхий 3-аас илүүгүй ажилтан зүтгүүрийн бүхээгт сууж явахыг зөвшөөрнө.

17.86. Зүтгүүрийн бригадын бүрэлдэхүүнд ороогүй бусад хүн зүтгүүрийн бүхээгт зорчихыг хориглоно.

17.87. Зүтгүүрийг бүхээгт зүтгүүрийн бригадаас гадна суурь бүтэц эзэмшигчээс тогтоосон журмаар олгосон зөвшөөрөл бүхий 3-аас илүүгүй ажилтан зорчихыг зөвшөөрнө. Зөвшөөрөлгүй хүнийг зүтгүүрийн бүхээгт оруулахыг хориглоно.

ГАЛТ ТЭРЭГ ХООРОНДЫН ЗАМД ЗААВАЛ ЗОГСОХ ШААРДЛАГА ГАРСАН ҮЕД АЖИЛЛАХ ЖУРАМ

17.88. Галт тэргийг хоорондын замд заавал зогсоох шаардлага гарсан үед машинч нь:

а. Хэрэв яаралтай зогсоох шаардлагагүй бол галт тэргийг аль болохоор тэгш талбайд замын шулуун хэсэгт зогсоох.

б. Галт тэрэгний автомат тоормос, зүтгүүрийн туслах тоормосыг ажиллуулах;

в. Хоорондын замыг хязгаарлах өртөөдийн жижүүрт зогссон тухайгаа радио холбоогоор мэдэгдэж энэ тухай галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид нэн даруй илтгүүлэх.

г. Хэрэв семафор, гэрлэн дохио хаагдсанаас бусад шалтгаанаар галт тэрэг саатаж зогссон бол нэн даруй зогссон шалтгааныг тогтоох, цааш явах бололцоотой эсэхийг тодорхойлох арга хэмжээ авах

д. Хэрэв галт тэрэг, ганцаараа яваа зүтгүүр, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг 20 минутын туршид сэргээж чадахгүй бол бүрэлдэхүүнд байгаа гар тоормосыг (зорчигчийн галт тэрэгний үйлчлэгч нар, галт тэрэгний дарга, аж ахуйн галт тэрэгний ажил удирдагч) ажиллагаанд оруулах, дохио өгөх.

е. Дээр дурдсан ажилтан байхгүй галт тэргэнд туслах машинч нь зүтгүүрт байгаа тоормосны тооцоот ивүүрээр бүрэлдэхүүнийг бэхлэхэд хүрэлцэхгүй байвал суурь бүтэц эзэмшигчээс тогтоосон журмаар вагоны зохих тооны гар тоормосыг ажиллагаанд оруулах.

ё. Хэрэв галт тэрэг, ганцаараа яваа зүтгүүр, дрезиний зогссон шалтгааныг 10 минутын туршид арилгаж чадахгүй бол зогссон шалтгаан ба хөдөлгөөнд тохиолдсон саадыг арилгахад шаардлагатай арга хэмжээний талаар галт тэрэгний радио холбоогоор өртөөний жижүүрт мэдэгдэх.

ж. Галт тэрэгний радио холбоо гэмтэлтэй үед телефон утастай ойролцоох газраас (туслах машинч, галт тэрэгний ажил удирдагч, зорчигчийн вагоны үйлчлэгч, аж ахуйн галт тэрэгний ажил удирдагчаар дамжуулан) галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч буюу өртөөний жижүүрт нэн даруй мэдэгдэх.

з. Галт тэрэг, ганцаараа яваа зүтгүүр, дрезинийг үйлчилж байгаа ажилтнуудтай хамтран хөдөлгөөнд тохиолдсон саадыг арилгах арга хэмжээ авах, шаардлагатай бол галт тэргийг дохиогоор хамгаалах.

17.89. Хоорондын замд зогссон галт тэргийг дараах үед хааж хамгаална.

а. Сэргээн босгох, галын галт тэрэг, туслах зүтгүүр шаардаж дуудсан үед дуудлага өгсний дараа нэн даруй

б. Хэрэв галт тэрэг нь дохиолол холбооны тогтоосон бүх хэрэгслийн ажиллагаа тасарсан үед явсан бол галт тэрэг зогссоны дараа нэн даруй

в. Хоорондын замд зогссон галт тэрэгний хаалт хамгаалалтыг “Дохиоллын журам”-д зааснаар гүйцэтгэх ба энэ үед төмөр замын ажилтан “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”-ын дагуу ажиллана.

17.90. Галт тэрэг өгсүүр дээр зогссон бөгөөд түлхэгч зүтгүүр байхгүй үед машинч нь галт тэргийг **уг хоорондын замын тэгш аястай хэсэг хүртэл** ухрааж болно.

а. Дээрх тохиолдолд ухрааж байгаа **галт тэрэгний хөдөлгөөний чиглэлийн дагуу эхний вагон дээр** зүтгүүрийн бригадын ажилтан тухайлбал, туслах машинч буюу аж ахуйн галт тэрэгний ажил удирдагч, **зорчигчийн галт тэрэгний дарга** байрлана.

б. Галт тэргийг ухраах хурд нь **10** км/цагаас ихгүй байна. Ухраах үед мэдэгдэх дохио байн байн өгч байна.

17.91. Дараах галт тэргийг ухрааж болохгүй.

а. Өртөөний хязгаарт байгаагаас бусад зорчигчийн галт тэрэг

б. Манан, цасан шуургатай зэрэг дохионы үзэгдэлтийг муутгасан бусад тааламжгүй нөхцөлд бүх төрлийн галт тэрэг

в. Хэрэв зогссон галт тэрэг дохиолол холбооны тогтоосон бүх хэрэгслийн ажиллагаа тасарсан үед явсан бол

г. Автомат хориглолтын үед бүх төрлийн галт тэргийг ухраахыг хориглоно.

д. Өртөө хоорондын хориглолтой үед бүх төрлийн радио галт тэргийг ухраахыг хориглоно.

е. Байрнаас хөдлөх нөхцөлийн хувьд жин нь нормоос хэтэрсэн буюу ухрааж үл болох галт тэргийг өгсүүр дээр зогссон үед машинч нь туслах зүтгүүрийг нэн даруй шаардана.

17.92. Галт тэргийг хоорондын замаас анх явуулсан өртөө рүү галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журамд зааснаар буцаан ирүүлж болно.

17.93. Хэрэв галт тэрэг хоорондын замд зогссоны дараа бие даан явж чадахгүй байвал бүрэлдэхүүнийг хоорондын замаас туслах зүтгүүрээр “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”-д тогтоосны дагуу татаж авна.

17.94. Галт тэрэг тасарсан үед зүтгүүрийн бригад “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”-ын дагуу ажиллана.

17.95. Галт тэргийг хэсэглэн татаж авах, галт тэрэг тасарсан үед үлдсэн хэсгийг өөрөө хөдлөхөөс хамгаалж, “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”-д тогтоосноор нэн даруй бэхэлсэн байна.

17.96. Хэрэв сэргээн босгох, галын галт тэрэг, туслах зүтгүүр дуудсан бол тусламж ирэхээс өмнө буюу явах тухай зохих зөвшөөрөл өгөгдөөгүй байхад зогссон галт тэргийг хөдөлгөж үл болно. Сэргээн босгох, галын галт тэрэг, туслах

зүтгүүр дуудах, товлох, хөдөлгөх, цааш явахыг “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”-д зааснаар гүйцэтгэнэ.

17.97. Галт тэрэг замд явж байх үед машинч, түүний туслах, өртөөний жижүүр, сумчин, замын ба **дохиолол** холбооны ажилтан, морин эргүүл, гармын жижүүр, ачаа хүргэж яваа цэрэгжүүлэн хамгаалахын ажилтан болон бусад ажилтан нь галт тэрэг осол аюулгүй явж байгаа эсэхийг анхааралтай ажиглахын зэрэгцээ вагоны явах анги, нум, вагоны автомат угсрааны байдал мөн галт тэргэнд хос дугуй гацсан, гүүшин халсан, хос дугуйн чирэг гарсан эсэх, тээвэрлэж байгаа ачааны бүрэн бүтэн байдал, задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачаа найдвартай бэхэлсэн, сүүлийн дохио байгаа эсэхийг онцгой анхаарч байна.

ЗАМААС АВАГДДАГ НЭГЖИЙН ХӨДӨЛГӨӨН

17.98. Замаас авагддаг нэгжийн хөдөлгөөнийг хоорондын зам эзлэх эрхийн зөвшөөрөл олгохгүйгээр зохицуулна. Том гүүр бүхий мөн түүнчлэн замын аясын хувьд бартаатай хоорондын замд замаас авагддаг нэгжийн хөдөлгөөний журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

17.99. Замаас авагддаг нэгжийн хөдөлгөөн нь галт тэрэгний цагийн хуваарийг хэрхэвч зөрчихгүй байна. Замаас авагддаг нэгж нь цахилгаан тусгаарлагч бүхий голтой байна.

Замаас авагддаг нэгжийн хөдөлгөөнийг “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”-д **заасны дагуу** гүйцэтгэнэ.

ГАРЧИГ

Нэгдүгээр бүлэг

Нийтлэг үндэслэл	2
------------------	---

Хоёрдугаар бүлэг

Төмөр замын тээврийн байгууллагын ажилтны нийтлэг үүрэг	12
--	----

Гуравдугаар бүлэг

Байгууламж, төхөөрөмж	15
-----------------------	----

Дөрөвдүгээр бүлэг

Замын аж ахуйн байгууламж, төхөөрөмж	17
Замын дэвсгэр ба огтлол зураг	17
Замын ул шороо, дээд бүтэц, хиймэл төхөөрөмж	18
Зам төмөр	20
Суман шилжүүлэг	21
Төмөр замын огтлолцол, гарам, бэлчир	23
Замын ба дохионы тэмдэг	24

Тавдугаар бүлэг

Зүтгүүр ба вагоны аж ахуй, сэргээн босгох хэрэгсэл	25
--	----

Зургаадугаар бүлэг

Өртөөний аж ахуйн байгууламж, төхөөрөмж	26
---	----

Долоодугаар бүлэг

Дохиолол холбооны байгууламж, төхөөрөмж	28
Замын автомат ба хагас автомат хориглол	31
Өртөө хоорондын хориглол	32
Галт тэрэгний хөдөлгөн зохицуулагчийн төвлөрүүлэлт	32
Зүтгүүрийн автомат дохиоллын замын байгууламж	33
Цахилгаан очрын систем	33
Сум, дохионы цахилгаан төвлөрүүлэлт	33
Сум, дохионы түлхүүрийн хамаарал	34
Өртөөний хориглол	35
Гармын автомат дохиолол, автомат хаалт ба сөхөгддөг саад	35

Холбоо	36
Мэдээллийн програм хангамж, сүлжээ, дүрс бичлэгийн төхөөрөмж	37
Дохиолол ба холбооны шугам	38
Дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны байгууламжийн техникийн завсар , үйлчилгээ	39

Наймдугаар бүлэг

Төмөр замын цахилгаан, ус хангамжийн байгууламж, төхөөрөмж	41
--	----

Есдүгээр бүлэг

Байгууламж, төхөөрөмжийн үзлэг, засвар	43
Байгууламж, төхөөрөмжийн засвар	43

Аравдугаар бүлэг

Хөдлөх бүрэлдэхүүн	45
--------------------	----

Арван нэгдүгээр бүлэг

Хос дугуй	46
1520 мм царигтай замд ашиглагдах хос дугуй	47
1435 мм царигтай замд ашиглагдах хос дугуй	48

Арван хоёрдугаар бүлэг

Тоормосны тоноглол, авто угсрааны хэрэгсэл	49
1520 мм царигтай замд	50
1435 мм царигтай замд	50

Арван гуравдугаар бүлэг

Хөдлөх бүрэлдэхүүний арчлалт, ачаа тээвэр, техникийн үйлчилгээ, засвар	51
Зүтгүүрийн техникийн үйлчилгээ, засвар	52
Вагоны үйлчилгээ засвар	53
Галт тэрэг ба вагонд ачаа тээврийн зөрчил илрүүлэх автомат төхөөрөмж	54

Арван дөрөвдүгээр бүлэг

Галт тэрэгний хөдөлгөөний зохион байгуулалт	55
---	----

Арван тавдугаар бүлэг

Хэсэглэх газар	56
----------------	----

Арван зургаадугаар бүлэг

Өртөөний ажлын техник зохион байгуулалт	57
Суман шилжүүлгийн ашиглалт	58
Сэлгээний ажил	61
Галт тэрэг найруулах	62
Галт тэрэгний тоормос залгах тухай	65
Галт тэргийг тоноглох ба үйлчлэх	67
Галт тэргэнд зүтгүүр холбох	68

Арван долоодугаар бүлэг

Галт тэрэгний хөдөлгөөн	69
Галт тэрэг хүлээн авах	70
Галт тэрэг явуулах	72
Галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах дохиолол, холбооны хэрэгсэл	75
Галт тэрэгний хөдөлгөөний журам	77
Зүтгүүрийн машинчаас галт тэрэг жолоодох журам	78
Галт тэрэг хоорондын замд заавал зогсох шаардлага гарсан үед ажиллах журам	81
Замаас авагддаг нэгжийн хөдөлгөөн	83